

## АГУУЛГА

### 1. Өгүүлэл, нийтлэл:

- **Г.Далайжамц**  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орчин бүрдүүлэх нэн чухал асуудал 3
- **Д.Тулгамаа**  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дэмжих асуудал 8
- **Г.Нарангуяа,**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийг байгуулах түүхэн нөхцөл байдал, агуулга, үзэл санаа 16
- **Ш.Сүхбаатар**  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр төрийн хамгаалалт ба анхаарах зарим асуудал 24

### 2. Ярилцлага

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгогдох ёстой, ХЭҮК-ын дарга С.Цэрэндоржтой хийсэн ярилцлага 30

### 3. 2006 оны Хүний эрхийн байгууллагуудын Үндэсний Чуулганы баримт бичгүүд

- Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн үг 35
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Прагиба Метагийн хэлсэн үг 39
- УИХ-ын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын Хорооны дарга Т.Гандигийн хэлсэн үг 42
- **У. Хүрэлсүх**  
2005 онд “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” сэдвээр зохион байгуулсан Үндэсний Чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн 44
- **Б.Одбаяр**  
Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, цаашид анхаарах асуудал 52
- **Л.Одончимэд**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын талаар авч буй арга хэмжээ, цаашид шийдвэрлэх асуудал 58
- **Ц.Оюунбаатар**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн байдал, учирч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам 63
- **Р. Сэлэнгэ**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын Стандарт Дүрмийн хэрэгжилт 74
- **Д.Даваадамдин**  
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн төлөв байдалд хийсэн судалгааны дүн 84
- **О.Сэлэнгэ**  
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, нийгмийн хамгааллын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал 94
- **Үндэсний Чуулганаас гаргасан зөвлөмж** 98

## CONTENT

### 1. Articles:

- **G. Dalajamts**  
Issues to be considered in the promotion of human rights of persons with disabilities 3
- **D.Tulgamaa**  
Promoting the human rights of persons with disabilities 8
- **G.Narantuya**  
United Nation’s Convention on the Rights of Persons with Disabilities:  
Historical situation and perspectives 16
- **Sh.Sukhbaatar**  
Protection of the reputation of persons with disabilities and relevant issues 24

### 2. Interviews:

- “Persons with disabilities must have equal opportunity” An interview with  
Mr. Tserendorj Suren, Chief Commissioner of the National Human Rights  
Commission of Mongolia 30

### 3. Documents of the 2006 Annual National Conference of Human Rights Organizations:

- Opening speech by His Excellency Enkhbayar Nambar, President of Mongolia 35
- Opening speech by Ms.Pratibha Mehta, UNDP Resident Representative in  
Mongolia 39
- Opening speech by Ms.Gandi Tugsjagral, Member of the Parliament and Chair  
of the Standing Committee on Social Welfare, Education, Culture and Science 42
- **U. Khurelsukh**, Minister of Mongolia  
Implementation and results of the Recommendations from 2005 Annual National  
Conference under the theme of “Right to live in a safe and healthy environment” 44
- **B.Odbayar**, Minister of Justice and Internal Affairs  
Implementation of the National Human Rights Action Plan of Mongolia and  
problems to be solved 52
- **L.Odonchimed**, Minister of Social Welfare and Labour  
Measures to promote rights and to strengthen social welfare of people with  
disabilities and further challenges 58
- **Ts. Oyunbaatar**, President of the National Federation of NGO’ s of Persons with  
Disabilities  
Situation of rights of persons with disabilities: Facing challenges and ways to solve the  
problems 63
- **R. Selenge**, Head of the Philanthropy Center  
Study report on the implementation of the Standard Rules on the Equalizations of  
Opportunities for Persons with Disabilities 74
- **D.Davaadamdin**, Director of the Social Monitoring and Development Center  
Study report on the situation of rights of children with disabilities 84
- **O.Selenge**, Head of the Disabled Women’s Association  
Current status of the rights and social welfare of women with disabilities and  
further issues 94
- **Recommendations of the 2006 Annual National Conference** 98

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАЖ, ХАМГААЛАХ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ НЭН ЧУХАЛ АСУУДАЛ**

**Г.Далайжамц,  
ХЭҮК-ын гишүүн**

Хүний эрхийг хангаж, хамгаалах ажлын хамгийн гол цөм нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгаа бүхий орчинг бүрдүүлэх явдал байдаг. Энэ талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...” гэж онцлон заасан билээ.

Хүний нийтлэг эрхийн дотроос нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс, тэдгээрээс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулах нь нэн чухал асуудал гэдэгтэй төр, олон нийтийн санал бодол нэгдмэл байдагт хэн ч эргэлзэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд төр, иргэний нийгэм, аж ахуйн бүх хэвшлийн нэгж, байгууллагууд, тодорхой иргэний дэмжлэг, туслалцаагүйгээр эрхээ бүрэн эдлэх боломжгүй байдаг. Тухайлбал, төрөл бүрийн шалтгааны улмаас эдгээр хүмүүс нь бие бялдар, оюун ухааны чадавхи нь алдагдаж хэвийн нөхцөлд сурч боловсрох, хөдөлмөрлөх, биеэ дааж амьдрах чадваргүй болсон байдаг. Иймээс Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хөгжлийн бэрхшээлтэй хүнд адил тэгш эдлэх бүх боломжийг бүрдүүлсэн байх явдал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх бүх талын боломж нөхцлийг бүрдүүлэхдээ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48 дугаар чуулганаар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох Стандарт дүрмийн заалт шаардлагыг үндэслэн хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлбэл зохино.

Энэхүү шаардлагаас үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хамгаалах доорх орчинг бүрдүүлэх нь төр, иргэний нийгмийнхний тулгамдсан зорилтууд болно.

1. Хууль, эрх зүйн орчин
2. Эдийн засгийн орчин
3. Улс төрийн орчин
4. Нийгэм, сэтгэл зүйн орчин

**НЭГ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ**

**1.1.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж, хамгаалах хуулийг хүний эрхийн стандартад нийцүүлэн улам боловсронгуй болгох ёстой.

- a) Давуу тал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, энэ чиглэлээр төрийн бус байгууллагын үйл ажиллагаа; Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие эрхтэний нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлт, тэдэнд үзүүлэх үйлчилгээг зааж тодорхойлсон.
- b) Энэхүү хуулийн сул тал: Зарим заалт нь хэт ерөнхий тунхаглалын чанартай буюу биелүүлэх баталгаа болон хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгаагүй.
- c) Одоогийн мөрдөгдөж буй дээрх хуулийг улам боловсронгуй болгох шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эдлэх ёстой бүх эрхийг эдэлж хэрэгжүүлэх аятай боломж нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг хуульд нарийвчлан тусгуулах. Тэдний эрхээ эдэлж хэрэгжүүлэх механизмуудыг тодорхой болгож өгөх. Энэ талаар холбогдох баталгааг хангах болон холбогдох субъектууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхойлох.
- d) Эдгээр асуудлаар Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.4.6.1-т: Эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэнд, экологийн болон бусад салбарын бүх түвшний үндсэн чиглэл, төсөв, хөтөлбөр болон хууль тогтоомжид тусгай хэрэгцээ бүхий хүмүүсийн талаар тодорхой бүлэг, заалт оруулж, тахир дутуу иргэдийн эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах хуулиудыг боловсронгуй болгох зэрэг нэмэлт арга хэмжээ авна” гэж заасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх эхний үе шатны арга хэмжээ авах гол чиглэл болж байна.

**1.2.** Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж гаргасан зарим тогтоол, дүрэм, журмыг шинэчилсэн боловч тэдний эрхийг хангах шаардлагад нийцэхгүй байгаа тул хөгжлийн бэрхшээлтэй хүнд зохих хөнгөлөлт үзүүлэх, эрхээ эдлэхэд нь боломж олгох чиглэлээр цаашид холбогдох эрх зүйн актуудыг улам боловсронгуй болгон хүний эрхийн стандартад нийцүүлэх.

**1.3.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, нийгмийн хамгаалал, тэдэнд хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаар бүх албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох ажилтан, иргэний нийгмийнхэнд сургалт явуулах, бие дааж судлуулах замаар тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх. Ялангуяа дурдсан холбогдох зарим албан тушаалтнуудын мэдлэг, чадвар дутмаг, тэдэнд чин сэтгэлээсээ санаачлага гарган ажилладаггүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх их зөрчигдсөөр байна.

**1.4.** Хүний эрхийн боловсрол олгох ажлын хүрээнд нийт иргэдэд зориулан нийгмийн хамгааллын талаархи хууль тогтоомжийг сурталчлах, сургалт явуулах замаар тэднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, холбогдох хууль, эрх зүйг хүндэтгэдэг болгох.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН**

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрлөх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эдийн засгийн аятай орчин зайлшгүй шаардлагатай. Тухайлбал:

**2.1.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дагнасан үйлдвэрүүд бий болгож ажиллуулах (хараагүйчүүдийн үйлдвэр шиг)

**2.2.** Тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохируулан жирийн эрүүл хүмүүстэй хамт дагалдуулан тодорхой хөдөлмөр эрхлүүлэх боломжтой нөхцөл бий болгох

**2.3.** Тэдэнд хувиараа жижиг, дунд үйлдвэр эрхлэх буюу гэрээрээ хөдөлмөр эрхлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх

**2.4.** Хөдөлмөрлөх чадвартай, хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт тэдний сонирхол, авьяас чадвар боломжинд нь тохируулан мэргэжил эзэмшүүлж, энэ дагуу ажил, хөдөлмөр эрхэлдэг болгох

**2.5.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аж ахуй эрхлэхэд нь татварын болон зээл тусламжийн хөнгөлөлт үзүүлэх журам тогтоон хэрэгжүүлэх

**2.6.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сурч боловсрох, мэргэжил эзэмших, хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэхэд нь зориулан зохих сан байгуулж ажиллах

**2.7.** Хараагүй, тулах эрхтэн, нуруу нугасны гэмтэл согогтой хүнд зориулан гудамжаар явах, зам хөндлөн гарахад зориулалтын тактелин зам, гүүр, тусгай орц, гарц, хаалга, шат, дохионы хэрэгсэл тэргэнцрээр явах боломжтой налуу пандус, замтай болгохын зэрэгцээ тусгай хэрэгцээний бусад төхөөрөмжөөр хангах

**2.8.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрх бүрийг амьжиргааны эх үүсвэртэй болгох, тэдэнд ажил, мэргэжлийн баримжаатай болгох, бүх талын дэмжлэг бий болгох

## **ГУРАВ. УЛС ТӨРИЙН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ**

**3.1.** Улс төрийн орчинг бүрдүүлэхийн тулд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан гаргаж буй шийдвэр, явуулж буй бодлого, үйл ажиллагаандаа хүний эрхийн стандарт, хэм хэмжээг чанд сахин мөрдөж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг онцгойлон анхаарч ажиллах

**3.2.** Улс төрийн нам, эвслийн болон төр, засгийн улс төрийн албан тушаалтны хүний эрхийн түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын талаархи мэдлэг, чадавхийг дээшлүүлэх, тэднийг энэ чиглэлийн мэдрэмжтэй болгох (Тэднийг энэ чиглэлд зөв шийдвэр гаргахад лоббидох)

**3.3.** Иргэдийн улс төрийн соёл, ухамсрыг дээшлүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг улс төрийн аливаа үйл ажиллагаанд алагчлан үзэхгүй байх ухамсрыг нийт иргэдэд төлөвшүүлэх (ийм хандлага бий болгох)

### **Дөрөв. НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ**

**4.1.** Төр, олон нийт, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, нийт иргэдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эерэг сэтгэлээр үзэж, тэдний эрхийг байнга хүндэтгэх уур амьсгалыг бий болгох

**4.2.** Сум, дүүрэг, баг, хорооны болон тодорхой байгууллага, хамт олны түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслан дэмжих хөдөлгөөн өрнүүлэх ажлыг зохион байгуулах. Энэ хөдөлгөөний хүрээнд нэн ядуу буюу ядуувтар амьдралтай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамж, туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажлыг өрнүүлэн нийтийн хүртээл болгох

**4.3.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийгэм-сэтгэл зүйн орчин бүрдүүлэхэд юуны өмнө тэдний эдлэх ёстой суурь эрхүүдийг хэрэгжүүлэхэд нийгмийн бүх (төрийн болон аж ахуй нэгж, байгууллага, иргэний нийгэм) субъектүүдийн зүгээс дэмжлэг, туслалцаа үзүүлэх хөдөлгөөн өрнүүлэх явдал юм. Иймэрхүү хөдөлгөөн өрнүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрхээ эдлэхэд бүх боломжийг хангах олон нийтийн аятай эерэг уур амьсгал бий болгоход төрийн бүх шатны байгууллага, иргэний нийгмийн хамтын хүчин чармайлтыг чиглүүлэх механизмыг бий болгож байнга ажилладаг болгох.

**4.4.** Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн улмаас хохирсон хөгжлийн бэрхшээлтэй хүний хохирлыг тэргүүн ээлжинд гаргуулж арилгуулдаг байх журмыг тогтоон хэвшүүлэх

**4.5.** Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй нэг ч хүний эрхийг зөрчихгүй байхын төлөө хөдөлгөөн өрнүүлэх

**4.6.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндлэн анхаарал халамж тавих, сэтгэлийн дэм үзүүлэхэд олон нийтийн нөлөөллийг нэмэгдүүлэх. Энэ зорилгоор сургалт, сурталчилгааны ажлыг бүх хэлбэрээр зохион байгуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах нийгмийн сэтгэлгээг эрс өөрчлөх шаардлагатай болж байна. Түүнчлэн энэ талаар Монгол Улсад

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.4.6.2-т “Тусгай хэрэгцээ, онцлог сонирхол бүхий хүмүүсийг ялгаварлах, гадуурхах, нийгмийн гаж сэтгэл зүй, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн ухуулга, сургалт, сурталчилгааг тогтмол явуулж энэ ажилд тэдний өөрсдийн оролцоог хангах механизм бүрдүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх нь уг асуудлаар нийгэм-сэтгэл зүйн орчин бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

### **Дээрх дөрвөн орчин, нөхцөлийг хэн бүрдүүлэх вэ?**

Үүнийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төр, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Тухайлбал: Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 1.1-д: “Хүний эрхийг хангах үндэсний механизмд:

- Хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага
- Хүний Эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд
- Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа
- Хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэглүүрүүд орно” гэж заасан байдаг.

Энэхүү механизмууд дээрх дөрвөн орчинг хамтын хүчин чармайлтаар бүрдүүлж ажилласнаар үр дүнд хүрэх болно.

### **Үүний ач холбогдол нь юу вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж хамгаалах дээрх дөрвөн орчинг бүрдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдөхгүй байх, тэд эрхээ зохих ёсоор эдэлж хэрэгжүүлэх аятай боломж нөхцөл бий болсон байх, тэд өөрсдөө эрхээ эдлэхийн төлөө тэмцдэг, нийгмийн идэвхи нь дээшилж, нэг хэсэг нь бие дааж амьдрах чадавхитай болно. Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж хамгаалах дээрх орчин нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр тэдний эрхийг хамгаалах, нийгмийн хамгаалалыг сайжруулах талаар ярихын ч хэрэггүй юм. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” сэдэвт Үндэсний Чуулганаас гаргасан зөвлөмжийн заалтыг биелүүлэх ажилтай нягт уялдуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж хамгаалах дээрх орчин нөхцөлийг бүрдүүлэх нь төр засгийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, иргэний нийгмийн хойшуулушгүй тулгамдсан нэн чухал асуудал болж байна.

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрхийг дэмжих асуудалд

*Д.Тулгамаа,  
АИФО байгууллагын Монгол  
дахь суурин төлөөлөгч*

НҮБ-ын “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (1948)-д хүний иргэний болон улс төрийн бүхий л эрх, эрх чөлөөг тодорхойлон гаргасны дотроос хүн бүр улс орондоо төрийн алба хаших, нийгмээс хангамж авах, нэр төрөө хамгаалах, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх, хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангуулах, хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж байдлыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх, сурч боловсрох эрхийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд яаж эдлүүлэх вэ гэдэг нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг болно.

Энэ тунхаглалд “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө ямарч ялгаваргүйгээр арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, язгуур угсаа, бусад ялгааг үл харгалзан адилхан эдлэх ёстой, ... ямарч хүнийг ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан байдаг. Үүнээс үзвэл энд нийгмийн бүх давхарга адил тэгш хамрагдах нь хэнд ч ойлгомжтой авч улс орнуудад эдгээр эрхийг жирийн эрүүл саруул иргэн бүр тэгш эдэлж чадахгүй байгаа талаар хүний эрхийн байгууллагууд нэг биш удаа тэмдэглэсэн байдаг.

Хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах зорилт тавьсан Монгол улсад ч ийм дутагдал нэгэн адил байсаар байгаа юм. Тэгвэл эцэг эх, асран хамгаалагч, нийгэм, хамт олны дэмжлэг тусалцаагүйгээр эрхээ эдэлж чаддаггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд бол бүр ч бэрхшээлтэй. Энэ хүмүүст тодорхой нөхцөл байдлыг бий болговол ялгаварлан гадуурхагдахгүй, нийгмийн идэвхтэй амьдралд орж нийгэмших, хөгжих эрхээ эдлэх бололцоо гарна. Энэ байдлыг харгалзан үзэж дэлхийн улс орнууд хууль тогтоомжиндоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгайлан оруулдаг юм. Ингэснээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэм хамт олноосоо тодорхой дэмжлэг авч чаддаг нь батлагдсан үнэн.



Дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагууд ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг нийтлэг баримт бичигт тусгаснаар хязгаарладаггүй тусгайлан баримт бичгүүд боловсруулан гаргаж улс орнуудад санал болгодог. Ингэж тусгайлан гаргасан баримт бичгүүдээс дурьдвал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тунхаглал (НҮБ, 1975)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох НҮБ-ын стандарт дүрэм (1994)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын хамтарсан баримт бичиг (ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО - 1994, 2001)
- Хөгжлийн бэрхшээл, үйл ажиллагаа, эрүүл мэндийн олон улсын ангилал (ДЭМБ, 2001)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын талаарх Хельсинкийн олон улсын хурлын зөвлөмж (2003)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги (ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО - 2004)
- “Хөгжлийн бэрхшээл, түүнээс урьдчилан сэргийлэх, удирдах, сэргээн засах” (ДЭМБ-ын 58.23 тогтоол, 2005)
- НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол улсад өгсөн дүгнэлт зөвлөмж (2005)

Эдгээр баримт бичгүүдийг улс орнууд заавал дагаж мөрдөх албагүй ч шударга ёсыг тогтоож, хүний эрхийг хүндлэн дээдэлдэг бол хүлээн зөвшөөрөх ёстой.

Аль ч улс оронд тодорхой нөхцөл байдлаас төрөлхийн эсвэл олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Эдгээр хүмүүс нь ямарваа нэгэн асран хамгаалагч, нийгэм, хамт олны дэмжлэггүйгээр эрхээ эдэлж чаддаггүй, сул дорой, нийгмээс тусгаарлагдсан, ядуу зүдүү, гадуурхагдсан, арчаагүй нэгэн болж хувирах нь олонтаа байдаг.

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик**

Дэлхийн эрүүл мэндийн судалгаагаар хүн амын 7-10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг гэж үздэг. Мөн хөгжиж буй улс орнуудад хүн амын 5,5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн АИФО байгууллагын судалгаа байдаг. Энэ аргачлалаар тооцвол Монгол улсад 140 гаруй мянган хүн хөгжлийн бэрхшээлтэй байх талтай.

Монгол улсад 1990-ээд оныг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг төрийн халамж, үйлчилгээний болон эрүүл мэнд, боловсролын байгууллагууд илүү анхаардаг байсан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн талаар олон улсын аргачлалаар хийсэн судалгаа байсангүй. Ялангуяа төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ эцэг эх нь нийгмээс тусгаарлаж, зарим нь бүр нуух, нийгэмд харуулахгүй байхыг оролддог нь нууц биш юм. Энэ нь нийгэм, хамт олонд тэднийг хүлээн авах, нийгэмшүүлэх ойлголт төлөвшөөгүй байгаатай холбоотой.

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш буюу 1990–ээд оноос сонирхогч олон улсын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар судалгаа хийх, тэдэнд тэгш боломж олгох арга замыг хайх, нийгэм хамт олонд нь түшиглэн сэргээн засах хандлагыг төлөвшүүлэх талаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болов. Түүний нэг нь Италийн төрийн бус байгууллага АИФО (Раул Фолерогийн анд нөхдийн холбоо) юм. Тус байгууллага нь Монголд 1991 оноос “Нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах хандлагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дэмжих” чиглэлээр төсөл хэрэгжүүлж байгаа юм.

АИФО байгууллагын төсөлд 12 аймаг, нийслэлийн 8 дүүрэг хамрагддаг бөгөөд төслийн зохицуулагч нар 2005 онд 1.919.741 хүнийг хамруулан судалгаа хийхэд харааны бэрхшээлтэй 7.879, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй 7.747, бие бялдрын бэрхшээлтэй 9.862, уналт таталттай 3.369, сэтгэцийн эмгэгтэй 5.822, оюун ухааны хомсдолтой 3.720, хавсарсан болон бусад бэрхшээлтэй 12.557, бүгд 50.956 хүн бүртгэгджээ. Үүгээр үзвэл нийт хүн амын 2,66 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Энэ тоо бодит байдлаас арай доогуур байж болох юм. Ийм үзүүлэлт гарсан нь илрүүлэлт, хөгжлийн бэрхшээлийн үнэлгээ зэрэгтэй холбоотой байж болно. Иймээс бид 2003 онд Баянхонгор аймагт загвар судалгаа явуулсан бөгөөд энэхүү судалгаагаар нийт хүн амын 5,2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна гэсэн тоо гарсан юм. Уг судалгаагаар харааны өөрчлөлттэй 940 (нийт хүн амын 1,1%), сонсгол, хэл ярианы өөрчлөлттэй 810 (0,9%), бие бялдрын өөрчлөлттэй 1010 (182%), уналт таталттай 203 (0,2%), сэтгэцийн эмгэгтэй 228 (0,3%) оюуны хомсдолтой 515 (0,6%) бусад 719 (0,8%) тус тус байна. Шалтгаанаар нь авч үзвэл өвчнөөр 1906 (43,1%), төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 1504 (33,9%), осол гэмтлээс шалтгаалсан 1021 (23,1%) байна. Энэ судалгаа бол үнэнд нэлээд ойртсон гэж үзэж болно. Ер нь тус улсад одоогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баталгаатай тоо байхгүй байгаа тохиолдолд АИФО байгууллагын аргачлалаар нийт хүн амын 5,5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцож болох юм.

## **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дэмжихэд ахиц өөрчлөлт гарсан уу?**

2005 онд Монгол Улсын Их Хурлаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийг баталж гаргасан нь тэдний эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж нийгмийн хамгааллын асуудлыг шийдэхэд томоохон алхам болжээ. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүх л эрхийг багцлан тусгаж чадаагүй, тэтгэмж талыг нь голчлон анхаарсан тул орхигдсон зүйлүүдийг салбарын хуулинд нэмж тусгах шаардлага бий болсон байна.

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо АИФО байгууллагын төслөөр анх удаа 2005 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын багц хууль” боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьсан боловч ихэнх асуудлууд нь “Халамж”-ийн” хуулинд тусгагдсан гэдэг шалтгаанаар ийм хууль гаргахгүй, зөвхөн орхигдсон асуудлуудыг салбарын хуулинд тусгахаар болсон юм. Энэ асуудлыг Монгол улсын Ерөнхийлөгч ивээлдээ авч Монгол улсын салбарын 15 хуулинд өөрчлөлт оруулах төсөл боловсруулж Засгийн газарт оруулсны 10 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжиж, үлдсэн хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжих боломжгүйгээ илэрхийлээд байна. Тухайлбал, Боловсролын тухай хуулинд өөрчлөлт оруулах боломжгүй шалтгаанаа “Улсын төсвөөс болон зээл тусламжийн хөрөнгөөр шинээр баригдаж буй сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан анги танхим, бие засах газрыг тохижуулж, тэргэнцэрийн зам, пандус хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлж байна” гэжээ. Үүгээр хуулинд оруулах заалтыг хаах нь туйлын хариуцлагагүй явдал. Хуульчлаагүй тохиолдолд шинээр барих сургууль ч, хуучин баригдсан сургуулийн байранд дээрх стандартыг хэрэгжүүлэхгүй байхад хүлээх хариуцлага байхгүй л байх болно. Мөн бага, дунд боловсролын хуулинд оруулах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг заавал суурь боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн нэг ангид суралцах хүүхдийн тоо 10-аас дээшгүй байх” гэсэн заалтыг хүлээж аваагүй байна. Гэтэл энэ нь эцсийн эцэст “чанарын үзүүлэлт” болох учраас онцгой ач холбогдолтойг ойлгоогүй буюу хүсээгүй нь харагдаж байна. Ер нь хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар тусгайлан заалт оруулах нь тэдэнд онцгой эрх эдлүүлэх гэсэн хэрэг биш, эдэлж чадахгүй эрхийг нь эдлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэгийг хувь хүн, нийгэм, хамт олонд ойлгуулахад ихээхэн цаг хугацаа хэрэгтэй болдогийг дээрх баримт харуулж байна.

Хүний эрхийн тухай ойлголт зөвхөн эрүүл хүмүүсийн өмч биш, бас эрхээ эдэлж, хамгаалж чадахгүй, гадуурхагдан дорд үзэгдэж буй нийгмийн тодорхой бүлэг - хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ч өмч юм гэдгийг төр

засаг, нийгэм хамт олон, гэр бүлийнхэнд төлөвшүүлэх талаар их ажил хийх шаардлагатай байна.

### **Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар юу хийж чадав аа?**

АИФО байгууллага Монгол улсын Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай 15 жилийн хугацаанд үр бүтээлтэй хамтран ажиллаж “Тэгш дүүрэн” хөтөлбөр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх” төсөл, бичил зээл, жижиг төсөл хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг өөрчилж тэднийг нийгэм хамт олны дунд оруулах, нэг хүнийг ч болов аз жаргалтай нийгмийн идэвхтэй гишүүн болгох, ядуурлаас аврахын төлөө “энэрэл хайр” үзүүлдэг юм.

АИФО байгууллагын өөрийнх нь эрхэм зорилго нь “Соёл иргэншил - энэрэл хайрыг бий болгож олны хүртээл болгох” билээ. “Соёл иргэншил бол энэрэл хайр юм” гэж энэ байгууллагыг үндэслэгч Раул Фолеро 1961 онд гайхамшигтай тодорхойлолтоо гаргасан нь энэ байгууллагын эрхэм зорилго болж байна. Энэ нь соёл иргэншлийг “өндөр технологээр” төсөөлөгчдөд цохилт өгчээ. Өнөөгийн соёл иргэншилт нийгэмд ар талд нь сая сая хүн өлссөөр, хөгжлийн бэрхшээлтэй болсоор, доод давхрагын хүмүүс улам бүр ядуурсаар байна. АИФО нь эдгээр ядуу хүмүүст бие даан амьдрахад нь боломж олгож чадвал соёл иргэншлийг хайраар бялуулна гэж үздэг байгууллага юм. Монголд ч энэ зорилгоо хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж дор дурьдсан амжилтанд хүрэв.

1. Нийгэм хамт олонд тулгуурласан сэргээн засалт (НХОТСЗ)-ын орчин үеийн хандлага, менежментийн онцлог, хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-тэй ажиллах арга барил, дадлага эзэмшүүлэх, ХБИ-ийн сэргээн засалтын үйлчилгээг мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй багаар үзүүлэх мэдлэг олгох, ХБИ-ийн бие даах чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 11 чиглэлээр явуулж 5010 хүнийг хамруулав. Мөн энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нар, эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үзүүлэх эмч мэргэжилтэн болон төрийн бус байгууллагуудын боловсон хүчин бэлтгэгдэв.
2. НҮБ-ын ХБИ-д тэгш боломж олгох стандарт дүрэм, НХОТСЗ-ын хандлага стратеги, сэргээн засалтын эмчилгээний зөвлөмжийг 15 сэдвээр, сургалтын гарын авлагыг 14 сэдвээр орчуулж нийтийн хүртээл болгосон ба баримтат кино 3-ыг гаргаж, төрөл бүрийн уралдаан тэмцээн, ХБИ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргах, хурал зөвлөгөөн зохиох, сонин хэвлэл, радио телевизээр сурталчлах зэрэг мэдээлэл сурталчилгааг өргөжүүлсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх мэдлэгийг тэлэх, нийгэм дэх ойлголтыг гүнзгийрүүлэх, нийгмийн идэвх, санаачлага сэргээхэд нөлөө үзүүлсэн гэж бодож байна.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар судалгаатай болох зорилгоор Баянхонгор аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн түвшин тогтоох загвар судалгааг 2003 онд, Монголын нөхөн сэргээх эмнэлгийн тусламжийн өнөөгийн байдлын талаарх судалгааг 2004 онд, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг 2005 онд явуулав.
4. 1999 оноос зээлийн эргэлтийн сан ажиллуулснаар хөгжлийн бэрхшээлтэй 488 хүн, гэр бүлийн 2400 гаруй гишүүдэд, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд жижиг төсөл 51-ийг хэрэгжүүлсний үр дүнгээс хөгжлийн бэрхшээлтэй 1156 хүн тус тус ашиг хүртэв.
5. 2006 онд АИФО болон бусад олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлаарх үндэсний чуулганд хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхэд оролцсон нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар дэд хөтөлбөр боловруулахад түлхэц өгөв. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар салбарын хуулинд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлыг Ерөнхийлөгч ивээлдээ авсан зэрэг нь ХБИ-ийн тэгш эрх эдлэх, ялгаварлан гадуурхагдахгүй амьдрах эрхийн асуудал төр засгийн анхааралд орсны илрэл болно.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг байгууллага, нийгэм хамт олны төлөөлөл оролцсон семинарын уриалгыг зарим яам идэвхтэй хүлээн авч байна. Тухайлбал, Зам, тээвэр, аялал, жуулчлалын болон Барилга, хот байгуулалтын яам ХБИ-д зориулсан Монголын хүүхдийн ордны гадна стандарт налуу зам тавьж, барилга төлөвлөлтийн нормаль боловсруулсан зэрэг ажлын эхлэл байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломж олгох хөдөлгөөн эмнэлэг, сургуулиудад амжилттай өрнөж байна.
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв /ХБИМССЗҮТ/-д сургалтын тоног төхөөрөмж бүхий сургалтын кабинет байгуулж, 12 аймаг, ХБИМССҮТ, нийслэлийн ясли цэцэрлэгийн 10-р цогцолбор дээр жижиг оврын ортопедийн цех, Монгол улсын Боловсролын Их сургуулийн Багшийн сургууль дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах бага ангийн багш бэлтгэхэд зориулан сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын кабинет байгуулах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг байгууллагуудын материалаг баазыг бэхжүүлэхэд тусалцаа үзүүлэв.
8. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэргээн засалтын тусламж үйлчилгээг хөтөлбөр хэрэгжүүлж буй аймаг, хотод 2003 оноос амжилттай хэрэгжүүлж олон арван сайн дурын идэвхтэн бэлтгэж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хөдөлгөөн засал, иллэг, бариа засал, ортопедийн хэрэгсэл хийж өгөх, хуулийн зөвөлгөө өгөх зэргээр тусалцаа үзүүлэх болов.

Энэ бүх ажил нь ХБИ-тэй ажилладаг Төрийн болон Төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ХБИ-дэд тэгш

боломж олгох НҮБ-ын стандарт дүрэм болон олон улсын холбогдох баримт бичгүүдийг ХБИ, тэдний гэр бүлийн гишүүд, энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд, нийт иргэдэд танилцуулах болон НХОТСЗ мэдлэг олгоход чиглэгдсэн болно. Ингэснээр ХБИ-ийг асран хамгаалагчид, эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн сэргээн засалтын үйл ажиллагаанд оролцох идэвх дээшилж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ авьяас чадвар, боломжийг нээх талаар ажиллагсдын тоо нэмэгдэж, ХБИ-ийн эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг арилгах өргөн боломж байдагт итгэх итгэл үнэмшлийг нийгэм хамт олонд бий болгосон юм.

### **ХБИ-ийн эрх, эрх чөлөөгөөр хангах талаар юу хийх хэрэгтэй вэ?**

1. Монгол улс нь “хүнлэг энэрэнгүй нийгэм” байгуулна гэж гайхамшигтай зорилт тавьсан орон. Иймээс “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тунхаглал”-д заасан бүхий л эрхийг бүх л хуулиндаа баталгаажуулахаас эхлээд түүнийг хэрэгжүүлснээр үр дүн нь тооцогдох учиртай. Энэ оны 4-р улиралд Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо санаачилж, Хүний эрхийн үндэсний комисс дэмжиж Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохиогдох “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх” Үндэсний Чуулган энэ чиглэлд ахиц өөрчлөлт гаргана гэдэгт итгэл дүүрэн байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн Үндэсний бодлого, стратеги, хөтөлбөр, бүтэц, тогтолцоог бий болгох нь нэн тэргүүний зорилт байх ёстой.
3. Тулгуур болон салбарын хуулиуд, хөтөлбөрүүдэд “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар” тусгайлан заалтууд оруулах нь тэдэнд давуу эрх эдлүүлэх гэсэн хэрэг биш, бусдын дэмжлэггүйгээр эрхээ эдэлж чадахгүй онцлогоос урган гарч байгааг бүх шатанд ойлгуулах ажил зохиовол зохино.
4. Хөдөлмөрийн чадвар алдалтын өвчлөлийн тодорхойлолтыг хэт хязгаарлах бодлогоор хийсэн гэх хандлагыг өөрчлөхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг зөрчигдөх магадлал өндөр байна. Одоогийн мөрдөж байгаа хөдөлмөрийн чадвар алдалтын тодорхойлолтонд мөрөө харах төдий нүдний харааны өөрчлөлттэй хүмүүс, өрөөсөн нүд сохор хүн ч тэтгэмж олгох хөдөлмөрийн чадвар алдалтын 70 хувьд хүрдэггүй тухай ХБИ ярьж гомдоллож байгааг судлан үзвэл зохино.
5. ХБИ жирийн иргэдийн адил нийгмийн бүхий л амьдралд оролцох тэгш боломж олгох үндэс нь материаллаг орчинд чөлөөтэй хүрэх боломж бүрдүүлэх явдал болно. Байшин барилгад нь тэргэнцэртэй хүн явах зам байна уу, гудамж, талбайд нь хараагүй хүн таягаараа мэдрэх зам байна уу, гэрлэн дохиололд дуут дохио байна уу, харааны өөрчлөлттэй хүнд брайлаар бичсэн үйлчилгээ байна уу, сонсголгүй хүнд дохионы хэлний орчуулга байна уу, телевизэд ийм үйлчилгээ нэвтэрсэн үү гэсэн наад захын асуултанд хариулах л ёстой. Бидэнд хийх юм их байна.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үр дүнтэй эмнэлгийн тусламжаар үйлчлэхэд тусгай хөтөлбөр боловсруулах нь оновчтой болно. Анагаах ухааны сургуулиудын сургалтын хөтөлбөрт ХБИ-ийн сэргээн засалтаар хичээл тусгайлан ордоггүйгээс энэ талаар дадлага туршлага багатай, ерөнхий нөхөн сэргээх тусламж, үйлчилгээндээ дулдайдах хандлага хэвшмэл байна. ХБИ-ийн сэргээн засалт нь ерөнхий нөхөн сэргээх тусламжаас ихээхэн ялгаатай, өвөрмөц онцлогтой тул энэ чиглэлээр мэргэжилтнүүдийг сурган бэлтгэх, энэ чиглэлийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай. Иймд сэргээн засалтын үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлбэл үр дүнтэй болно.
7. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, орлого олох, нийгмийн хамгаалал, гэр бүлийн амьдрал болон хувийн эрх чөлөө, соёл, спорт, чөлөөт цаг зэрэг асуудлуудыг бас л хуулиар хамгаалж нээлттэй болгох нь хойшлуулшгүй зорилт болно.
8. Дээр дурьдсан асуудлуудад анхаарал хандуулж ХБИ-ийн эрхийг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах гол арга нь НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”-д нэгдэн орох явдал болно. Ингэснээр XXI зуунд Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ энэрэл хайрыг бэлэглэх болно.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИЙГ БАЙГУУЛАХ ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АГУУЛГА, ҮЗЭЛ САНАА

**Г.Нарантуяа,  
ХЭҮК-ын референт**

Түүхийн өнгөрсөн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал нь хүүхдүүд, эмэгтэйчүүд, дүрвэгсэд, цагаач ажилчид зэрэг бусад эмзэг бүлгийн хүмүүстэй харьцуулахад олон улсын эрх зүйн зохицуулалтын гадна үлдсээр байжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээ, конвенциудад ямар нэг хэмжээгээр тусгалаа олсон нь үнэний хувьтай боловч эл асуудлыг хариуцан ажилладаг НҮБ-ын тусгай бүтэц байхгүй байгаа нь мөн бодитой зүйл билээ.

**НҮБ-ын Тусгай Илтгэгч Леандро Депюгийн 1993 онд хэлсэн үгнээс...**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1982 оны 12-р сарын 3-ны өдрийн 37/52 тоот тогтоолоор 1983-1992 оныг Хөгжлийн бэрхшээлтэй хүний 10 жил болгон зарлахын хамт энэ арван жилд хэрэгжүүлэх Дэлхийн Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлан гаргасан билээ. Уг 10 жилийн үйл явц, үр дүн болон Мөрийн Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлэлт өгөх зорилготой шинжээчдийн уулзалт 1987 оны 11-р сард зохион байгуулагдсан бөгөөд энэхүү уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын тусгай гэрээ байгуулах анхны санаачлага гарсан юм. Энэ санаачлагыг дэмжиж зарим улс орноос хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын гэрээний эх бичвэрийг боловсруулах ажлыг эхлүүлж байлаа. Тухайлбал, 1987 онд Итали улс, 1988 онд Швед улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын тусгай гэрээний зохицуулах асуудлыг хүрээг гаргаж НҮБ-д өргөн барьж байсан юм. Харин тэдгээр улсуудын санаачлага НҮБ-ын гишүүн улсуудын хангалттай дэмжлэгийг авч чадаагүй. Гэсэн хэдий ч Швед улсын боловсруулсан эх бичвэр хожим нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш боломж олгох стандарт дүрэм” (1993)-ийн эх үндэс болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар сэдэвчилсэн гэрээ байгуулах шаардлагатай эсэх талаарх маргаан, мэтгэлцээн 1987 оноос хойш 2000 оныг хүртэл НҮБ-ын хэмжээнд хүчтэй өрнөж байжээ. Эхэн үедээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал НҮБ-ын хүний эрхийн



суурь гэрээ, конвенцид хэдийнэ тусгагдсан учраас дахин тусгай гэрээ байгуулах шаардлагагүй гэсэн үзэл баримтлал түгээмэл байлаа. Энэ хандлагыг баримтлагчид олон улсын хүний эрхийн гэрээ, конвенциудын “...арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр...” гэсэн заалтын бусад нөхцөл байдал гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал багтаж байгаа гэж тайлбарлаж байсан юм. Харин бодит байдал дээр Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 23-р зүйлийг эс тооцвол өөр ямар ч хүний эрхийн гэрээ, конвенцийн зүйл заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байв. Түүнчлэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны 6-р Ерөнхий зөвлөмж, Эмэгтэйчүүдийн эрхийн Хорооны 18-р Ерөнхий зөвлөмжөөс<sup>1</sup> өөр НҮБ-ын хүний эрхийн үндсэн гэрээ, конвенцийн заалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай уялдуулж тайлбарласан Конвенцийн хорооны тайлбар байхгүй байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах талаар урьд өмнө нь гарч байсан олон улсын олон талт баримт бичгүүд бүгд заавал биелэгдэх хууль зүйн хүчин чадалгүй байсан нь улс орнуудын төр, Засгийн газрыг иргэдийнхээ өмнө хатуу амлалт өгүүлэх, тэрхүү амлалтад олон улсын зүгээс хяналт тавих боломжийг олгох эрх зүйн баримт бичгийг бий болгох нэгэн үндэслэл байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенци бий болгохыг дэмжигчдийн гаргаж байсан гол үндэслэлүүдийг нэг нь Конвенцийн хэрэгжилтийг хянах Хороо байгуулагдах тухай асуудал байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын хууль зүйн хүчин чадалтай баримт бичгийн хэрэгжилтийг хянах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдөж байгаа тухай гомдлыг шалгах, шийдвэрлэх төдийгүй НҮБ-ын үндсэн бодлого, хөтөлбөрүүд, эрх зүйн баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг тусгахад конвенцийн дагуу байгуулагдах Хорооны үүрэг нэн чухал байхыг тэд онцлон тэмдэглэж байлаа.

Энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд 2000 оны 3-р сард Бээжин хотноо зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн төрийн бус байгууллагуудын Чуулган (Самит) чухал түлхэц үзүүлсэн юм. Чуулганаас “Шинэ Мянганд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай Бээжингийн тунхаглал”-ыг гаргасан бөгөөд энэхүү баримт бичиг нь

<sup>1</sup> Конвенцийн Хороодоос гарсан Ерөнхий зөвлөмжийн талаар ХЭҮК-оос 2006 онд гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” гарын авлагаас үзнэ үү.

хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон зуун төрийн бус байгууллагын дуу хоолой байлаа.

5. Бид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэмд бүрэн оролцох явдлыг хангахын тулд заавал биелэгдэх хууль зүйн хүчин чадалтай олон улсын баримт бичиг бий болгох талаар хамтын хүчин чармайлт гаргах болно.
6. Бид, шинэ зууны эхлэл нь төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн байгууллагууд, НҮБ-ын гишүүн улсуудын хувьд олон улсын конвенцийг боловсруулах, батлах талаар нягт хамтран ажиллах боломжийг олгох түүхэн цаг үе байна гэдэгт итгэл төгс байна.
7. Иймийн тул бид, улс орон бүрийн төрийн тэргүүнээс энэ ажиллагааг аль болох хурдан эхлүүлэхийг шаардаж байна.
8. Түүнчлэн бид, энэхүү баримт бичгээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенц бий болгохыг уриалж байна.
9. Бид, өөр өөрсдийн байгууллагаа төлөөлөн олон улсын заавал биелэгдэх эрх зүйн хэм хэмжээ бий болгохын төлөө бүхий л хүчин чадлаа дайчлан ажиллахаа мэдэгдэх байна.

Тунхаглалд ийнхүү заасан байв.

2001 оны 12-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей тогтоол гаргаж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын конвенцийн эх бичвэрийг боловсруулах Түр Хороог байгуулсан бөгөөд Түр Хороо 2002 оны 7-р сараас үйл ажиллагаагаа эхлэсэн юм. Хороо бүтэн 4 жил ажилласны эцэст 2006 оны 8-р сарын 25-нд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийн эх бичвэрийг боловсруулж дууссанаа албан ёсоор мэдэгдсэн билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенци (цаашид Конвенц гэх) нь оршил хэсэг, 50 зүйл, нэмэлт протоколтойгоор боловсруулагдсан байна.

Конвенцийн оршил хэсэгт хүний эрхийн үндсэн зарчим, олон улсын гэрээ, конвенци, өгүүлэн буй асуудлын талаар урьд өмнө зохион байгуулагдсан гол арга хэмжээ болон конвенцийн баримтлах бодлого, үндэслэлийг дурдсан байна. *“Хөгжлийн бэрхшээл гэдэг байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд энэ нь нийгмийн амьдрал бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг танин мэдэж, ийм олон улсын конвенцийг батлан гаргах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах болон тэдгээр хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн бүхий л хүрээнд оролцох явдлыг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэн дараах зүйлийн талаар харилцан*

тохиролцов.” гэж Конвенцийн ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнгийн талаар оршил хэсэгт дурдсан байна.

Конвенцийн 1-р зүйлд зааснаар уг конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, ямар нэг алагчлагүйгээр эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих хийгээд тэдний салшгүй нэр төр, эрхэм зэргийг хүндэтгэн харилцахыг дэмжихэд оршино. Түүнчлэн тус зүйлд Конвенцийн зорилгод нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж ямар хүнийг хэлэх тухай тодорхойлсон бөгөөд *“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэгт урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд тийм бэрхшээл нь орчны бусад хязгаарлалттай нэгдэн нийлж бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүмүүсийг ойлгоно.”* гэжээ.

Конвенци нь дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:

- a) Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан салшгүй эрхэм зэрэг, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх
- b) Алагчилахгүй байх
- c) Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй хамрагдах
- d) Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүний ялгаатай байдлын нэг хэлбэр гэж хүлээн авах
- e) Тэгш боломж олгох
- f) Хүртээмжтэй байх
- g) Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх
- h) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхэд хүндэтгэлтэй хандах зэрэг болно.

Оролцогч улсын хүлээх үндсэн үүргийг тус Конвенцийн 4-р зүйлд тодорхойлсон байна. Оролцогч улсууд нь юуны өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар нэг алагчлалгүйгээр хүний бүх үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч баталгаажуулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэх үүднээс дараах арга хэмжээг нэн даруй авах ёстой. Үүнд:

- a) Дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээг Конвенцийн зүйл заалттай нийцүүлэх
- b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах нөхцөл байдлыг бий болгож байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, дадал зуршлыг устгах, өөрчлөх арга хэмжээг авах
- c) Төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгах

- d) Төрийн зүгээс Конвенцийн зорилгод үл нийцэх үйлдэл, дадал зуршил гаргахаас татгалзаж, болон төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа уг Конвенцийг баримтлаж ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- e) Хувь хүн, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн арга хэмжээг авах
- f) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээнд нийцсэн бүх төрлийн хэрэглэгдэхүүн, мэдээлэл харилцаа холбооны техник, технологийг зохион бүтээх, энэ төрлийн судалгаа шинжилгээ хийх явдлыг дэмжиж, эдгээр бүтээгдэхүүнийг хамгийн бага өртөгтэй байх нөхцөл бололцоог хангах
- g) Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүхий л төрлийн шаардлагатай мэдээллээр хангах арга хэмжээ авах
- h) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, төрийн байгууллагын албан тушаалтнуудад шаардлагатай ур чадвар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ.

Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн дүүрэн эдлэх нөхцөл байдлыг шат дараатай бий болгох үүднээс Оролцогч улс бүр өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэх талаар мөн зүйлд заасан байна.

Конвенцийн зарчим гэх хэлж болохоор өөр нэг үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх аливаа шийдвэрийг гаргахдаа тэдгээр хүмүүсийн төлөөллийг оролцуулах тухай заалт юм. Энэ талаар Конвенцийн 4.3-р зүйлд *“Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх чиглэгдсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг бий болгох, сайжруулах явцад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэднийг төлөөлөх байгууллагыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй сайтар зөвшилцөж, оролцоог хангана.”* гэж заажээ. Ер нь түүхийн бүхий л хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн байгууллагууд эрхийнхээ төлөө тэмцэхдээ *“Бидэнгүйгээр бидний асуудал шийдэгдэх учиргүй”* гэсэн уриа, дуу хоолойг илэрхийлж байсан бөгөөд энэ үзэл санаа Конвенцид тусгалаа олсон нь энэ юм. Конвенцийн Хороо байгуулах болон улс орнууд Конвенцийн хэрэгжилтийн талаарх тайлан илтгэлийг бэлтгэхдээ энэ зарчмыг баримтлах тухай заалт мөн тус Конвенцид бий.

Конвенцийн 10-30 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний бусдын нэгэн адил, ямар нэг алагчлалгүйгээр эдлэх хүний эрх, эрх чөлөөг нэрлэсэн байна. Тухайлбал:

- Амьд явах эрх

- Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдалд эрх, эрх чөлөөгөө дээд хэмжээгээр хамгаалуулах эрх
- Хуулийн өмнө тэгш байх эрх
- Шударга шүүхээр шүүлгэх эрх
- Халдашгүй эрх ба хувийн чөлөөт байдал
- Эрүүдэн шүүлт, хэршгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх
- Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх
- Бүрэн бүтэн байдлаа хамгаалуулах эрх
- Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх
- Бие даан амьдрах болон нийтийн үйл хэрэгт оролцох эрх
- Хувийн хөдөлгөөнт байдлаа хадгалах эрх
- Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүлээх авах эрх
- Хувийн нууцаа хүндэтгүүлэх эрх
- Гэр бүлийн болон орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах эрх
- Сурч боловсрох эрх
- Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Сэргээлт, нөхөн сэргээлт хийлгэх эрх
- Хөдөлмөрлөх эрх
- Хүрэлцэхүйц амьжиргаатай байх ба нийгмийн хамгаалал хүртэх эрх
- Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх
- Соёлын амьдрал, чөлөөт цагаа өнгөрүүлэх арга хэмжээ болон спортод оролцох эрхүүдийг тус тус баталгаажуулжээ.

Конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих механизмийг 31-33 дугаар зүйлийн заалтаар тодорхойлжээ. Конвенцийг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал бөгөөд Оролцогч улсууд нь бусад улсын Засгийн газрууд, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх үүрэгтэй. Конвенцид олон улсын хамтын ажиллагааны арга хэлбэрүүдийг тодорхойлж өгчээ. Түүнчлэн Оролцогч улсууд төрийн байгууллагынхаа тогтолцоонд нийцүүлэн нэг буюу хэд хэдэн төрийн захиргааны төв байгууллагыг Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр томилох учиртай. Мөн эдгээр байгууллагуудын Конвенцийг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээнд хяналтыг тавих механизмийг бий болгох ёстой бөгөөд чингэхдээ “Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын тухай Парисын зарчим”-уудыг харгалзан бий болгох юм. Конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавихад иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийг төлөөлөх байгууллагууд

бүрэн дүүрэн оролцох, хамрагдах боломж, нөхцлийг бүрдүүлэх нь Оролцогч улсын үүрэг мөн.

Конвенцийн 34-р зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороог (цаашид Хороо гэх) байгуулах, үйл ажиллагаа явуулах арга хэлбэр, зарчмыг тодорхойлсон байна. Уг зүйлд зааснаар Конвенцийг хүчин төгөлдөр болох үед Хороог 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулах ба Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 60 улс нэгдэн орсон, соёрхон баталсан нөхцөлд гишүүний тоог зургаагаар нэмэгдүүлэх ажээ. Гэхдээ ямар ч тохиолдолд Хорооны гишүүдийн тоо нь 18-аас ихгүй байна.

Хорооны гишүүд нь өөрийн нэрийн өмнөөс ажиллах бөгөөд ёс суртахууны эрхэм дээд чанарыг эзэмшсэн, Конвенциор зохицуулсан салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвартай хүмүүс байх ёстой бөгөөд тэднийг сонгохдоо газар зүйн шударга хувиарлалт, соёл иргэншлийн янз бүрийн хэлбэр, эрх зүйн үндсэн тогтолцооны болон хүйсийн тэгш төлөөлөл, хөгжлийн бэрхшээлийн талаар мэргэшсэн байдлыг харгалзаж үзнэ. Хорооны гишүүд нь дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Хорооны гишүүд нэр дэвшигчийг тодруулахдаа Оролцогч улсууд нь тус Конвенцийн 4.3-р зүйл буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах зарчмыг харгалзан үзэх учиртай.

Конвенцийн 35-р зүйлд Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээний тухай Оролцогч улсаас тайлан илтгэл боловсруулах, Хороонд хүргүүлэх асуудлыг зохицуулжээ. Оролцогч улсууд анхны тайлангаа энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Хороонд хүргүүлэх бөгөөд цаашид шинээр авсан арга хэмжээнийхээ тухай нэмэлт илтгэлийг дөрвөн жилд нэг удаа, түүнчлэн Хорооны хүссэн тухай бүр гаргаж өгөх ёстой. Хороо нь тайлан илтгэлийг хэлэлцээд Ерөнхий зөвлөмж гаргаж Оролцогч улсад хүргүүлэх бөгөөд Оролцогч улс уг Ерөнхий зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Конвенцийн төсөл Нэмэлт Протоколтойгоор боловсруулагджээ. Нэмэлт Протоколд нэгдсэнээрээ улс орнууд Конвенцид заагдсан аль нэг эрхийг нь улс зөрчсөний улмаас хохирсон хэмээн мэдүүлж буй иргэнийнх нь гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан хэлэлцэх Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм. Гэхдээ Нэмэлт Протоколд нэгдэн ороогүй Конвенцийн Оролцогч улсын холбогдол бүхий нэг ч мэдээллийг Хороо хүлээн авахгүй тухай Протоколын 1.2-р зүйлд заасан байдаг. Түүнчлэн Конвенцид заагдсан эрхийг Оролцогч улс ноцтойгоор удаа дараа зөрчиж байгаа тухай баталгаатай мэдээллийг Хороо хүлээн авсан бол мэдээллийг шалгахад хамтран оролцож, мэдээллийн талаарх саналаа ирүүлэхийг

Оролцогч улсаас хүсэх, Оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд энэ талаар газар дээр нь шалгалт хийх журмыг Протоколоор зохицуулсан байна.

Конвенцийн эх бичвэр одоо хуралдан буй НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61 дэх удаагийн Хуралдаанаар жинхлэн батлагдахаар төлөвлөгдсөн билээ. Конвенцийн 45-р зүйлд заасны дагуу тус Конвенц нь соёрхон баталсан болон нэгдэн орсон хорь дахь батламж жуух бичгийг хүлээн авснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болох учиртай бөгөөд дэлхийн 600 сая гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээр хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг мянга мянган байгууллагуудын анхаарал энэ үйл явцыг чих тавин хүлээж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын Конвенц батлагдсаны дараа уг Конвенцийг соёрхон батлуулах өргөн хүрээтэй кампанит ажил дэлхий даяар өрнөх нь дамжиггүй. Хөгжлийн бэрхшээл хэнд ч, хэдийд ч тохиолдож болзошгүй учраас энэ бол хүн бүрийн асуудал юм. Иймийн тул өөрийнхөө төлөө, нөхдийнхөө төлөө, хүн эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх нөхцөл бололцоо бүрдсэн ирээдүйн төлөө бид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын хууль зүйн заавал биелэгдэх хүчин чадал бүхий олон улсын гэрээг хүчин төгөлдөр болгоход хувь нэмрээ оруулах учиртай. Ялангуяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын Конвенци болон түүний Нэмэлт Протоколыг ямар ч тайлбаргүйгээр соёрхон батлуулахын төлөө хүчин чармайлт гаргах ёстой. Конвенцийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр төрийн халаасанд байхгүй гэдэг шалтгаан уг Конвенцийг соёрхон батлах ажиллагааг удаашруулах ёсгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх зорилтод бодитойгоор хүрэхийн тулд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын Конвенцийг соёрхон батлах нь гарцаагүй хийвэл зохих алхам юм.

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр төрийн хамгаалалт ба анхаарах зарим асуудал

*Ш.Сүхбаатар,  
Хууль зүй, Дотоод хэргийн дэд сайд  
МУИС-ын Хууль зүйн сургуулийн докторант*

Хүний тавилан таагдашгүй. Заримд нь гоо сайхан, үзэмж царай зүсийг харамгүй өгсөн атлаа нөгөө нэгнээс нь түүнийг хайрлахгүйгээр булаасан нь ч бий. Бидний өдөр тутмын амьдралд зарим нэгнийхээ төрөлхийн гажиг, хөгжлийн бэрхшээлтэй байдлыг нь далимдуулж хайрлаж халамжлахаасаа илүү хажиглан хачирхах, шоолон инээлдэх, бүр доромж үгээр зүрх сэтгэлийг нь шархлуулан мохоох үйлдэл цөөн биш гардаг нь нууц биш. Хүмүүс нийгэм маань ч түүндээ дасчихсан мэт сэтгэгдэл төрнө. Хувь тавилан хэнд ч юуг ч бэлэглэж болно. Хэдийгээр хялар долир, сохор дүлий, өрөөл татуу, ээрүү гацаа хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй төрсөн, амьдралын алагтай булагтай үед олсон байлаа ч хүн л бол хүн. Тиймээс хүн хүнээ зүрх сэтгэлээсээ хайрлаж, хөгжлийн бэрхшээлтэй нэгнээ бүр ч илүү энэрч байх нь хүнлэг энэрэнгүй хүн ёсны нэгэн эрхэм шинж юм. Ингэх нь хүн төрөлхтөний соёл иргэншлийн урт удаан хугацааны түүхэн хөгжлийн явцад буй болсон “Хүн бол эрхэмсэг шинжийг зөөгч, өөрөөр хэлбэл хамгийн үнэт зүйл”<sup>1</sup> гэсэн үзэл санаанд тулгуурласан эрх зүйн соёлын дээд хэлбэртэй нийцэх юм. Харин энэ эрхэм ёс, зан уламжлалаа үл тоон хөгжлийн бэрхшээлтэй нэгнээ доромжлон гутаах, элэглэн шоолох аваас энэ нь манай нийгмийн ямар ч хүний адил өмгөөлөх хуультай, өмөөрөх төртэй юм шүү гэдгийг сануулах үүднээс эл сэдвийг хөндлөө.

Хүний эрх энэ үг олон голын салаа шиг түмэн утгатай. Тэр дундаа хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах заалтууд манай улсын эрүү иргэний хуулиудад голлон тусаж иржээ.

Эдгээрээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр төр, алдар хүндэд халдах, тэдний эрх ашгийг хохироох, нийгэмд ялгаварлан гадуурхах зэрэг үйлдлийг манай улсын хувьд эрүүгийн гэмт хэрэгт тооцож нилээд эртнээс хамгаалж ирсэн билээ. Тухайлбал 1926 оны “Шүүх цаазын бичиг”-т “Бусдыг элдвээр доромжлох ба алдар нэрийг нь гутаах” тухай бүлгийг анх оруулсан

<sup>1</sup> Г.Зүмбэрэлхам. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйн презумпци. УБ 2005 он



байна. Үүнээс хойш 1929, 1934 оны Шүүх цаазын бичигт дээрхи бүлгийг бататган оруулсны дотор ийм төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял хариуцлагын асуудлыг нилээд чангаруулж албадан ажил хийлгэх болон торгох санкцыг давхар хэрэглэхээр заасан байна. Түүнчлэн 1942 оны Эрүүгийн хуульд “Хүний бие, эрүүл мэнд ба эрх чөлөө хийгээд нэр алдарт харшлах гэмт хэргүүд”, 1961 оны Эрүүгийн хуульд “Иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба нэр алдарт харшлах гэмт хэргүүд” бүлгүүдийг тус тус оруулж хуульчилсан нь хожим 1986 оны хуульд ч улам бататгагдан оржээ. 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-иос 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”<sup>2</sup> гэж заасан нь өнөө хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуулийн энэ зүйл ангид бусдыг доромжлох үйлдлийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр үйлдсэнийг гэмт хэрэгт тооцон, түүнд баривчлах ялыг оногдуулахаа нэмсэн нь 2002 оны Эрүүгийн хуулийн тухайн заалтын нэг онцлог шинж юм.

Бусдын нэр төр, алдар хүндийг амаар буюу бичгээр эсвэл бусад хэлбэрээр зориуд доромжилсон үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдож, уг хэргийг үйлдсэн этгээд хуулийн дагуу зохих хариуцлагыг хүлээх нь зайлшгүйг Эрүүгийн хуулиар хуульчилж өгчээ. Академич С.Нарангэрэл “Хүний амь бие, эрүүл мэнд, түүний эрх, эрх чөлөө нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан тэргүүн зэргийн объект юм. Өөрөөр хэлбэл Монгол улсын Эрүүгийн эрх зүйгээр хүний төрөлхөөс заяасан салшгүй эрх, түүнчлэн нийгэм, улс төр, иргэний эрхийг аливаа гэмт халдлагаас хамгаалдаг”<sup>3</sup> хэмээсэн нь өнөө мөрдөж буй эрүүгийн хуульд тусгалаа олжээ

Хүний нэр төр, алдар хүндэд халдаж гүтгэж доромжилсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх ба гүтгэх доромжлох зэрэг нь объектив талаараа ялгаатай бөгөөд гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүн нь илт худал мэдээлэл тарааж хүний нэр төр алдар, хүндийг гутаасан шинжтэй байдаг бол доромжлох үйлдэл нь бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө болон хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр доромжилсоны улмаас материаллаг бус хохирол учирсан байхаар илэрдэг байна.

Гүтгэх доромжлох гэмт хэргийн гаралтыг Монгол улсын хэмжээнд 1997-2004 он хүртлэх хугацаанд судлан үзэхэд нийтдээ 75 гэмт хэрэг (Үүнээс 1997 онд 5, 1998 онд 6, 1999 онд 11, 2000 онд 9, 2001 онд 10, 2002 онд 8,

<sup>2</sup> Монгол улсын хуулиуд. УБ 2002 он. 337 дугаар тал.

<sup>3</sup> С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ 1999 он.

2003 онд 12, 2004 онд 14 хэрэг) бүртгэгдсэнээс 36 эрүүгийн хэргийг шүүхээр таслан шийдвэрлэсэн байна.

Гүтгүүлсэн доромжлуулсан этгээд гомдлоо эрүү иргэний алинаар нь гаргахаа өөрөө шийдвэрлэдэг бөгөөд хохирогч этгээдийн хүсэл зоригоос хамаарч нэг бол эрүүгийн гэмт хэрэг эсвэл иргэний хэрэг болон хувирдаг нь судалгаанаас ажиглагдаж байна.

Гэмт хэрэг бол нийгэмд аюултай тодорхой этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах эрүүгийн хууль зөрчсөн зан үйл байдаг. Тэгвэл хувь хүний эрхтэй холбоотой нийгэмд аюул багатай доромжлох гүтгэх үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хуульд цаашид байлгах шаардлага байна уу үгүй юу гэдэг асуудал урган гаргана. Өөрөөр хэлбэл гүтгүүлсэн доромжлуулсан гээд байгаа этгээд хүсвэл цагдаад өргөдлөө өгдөг эсвэл иргэний журмаар шүүхэд хандах эсэхээ өөрөө шийдвэрлэдэг нь иргэдийн дунд “Мууг нь үзэх нь эрүүгээр явдаг, мөнгө хүссэн нь иргэнээр явдаг” гэсэн хэлц үг үүсэхэд хүргэжээ.

Бусдыг доромжилсон, гүтгэсэн бусад хэлбэрээр нэр төр, алдар хүндэд нь халдсан этгээд эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих ба үйл ажиллагаандаа дүгнэлт хийхгүй үйлдлээ үргэлжлүүлсээр байвал хуулийн этгээд бол дампуурч, хувь хүн бол өөрийн нэр хүндээ алдаж мөнгөн төлбөрт унадаг хариуцлагын шударга тогтолцоо цаашид нийгэмд илүүтэй үйлчлэх бизээ. Өнөөгийн практикаар гүтгэх доромжлох гэмт хэргийг шүүх шийдвэрлэхдээ гэм буруутай этгээдэд хуульд заасан голчлон хөнгөн ял оногдуулаад харин эд хөрөнгийн бус хохирлоо иргэний журмаар жич нэхэмжлэхийг хохирогчид зөвлөдөг байна. Учир нь Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115-р зүйл<sup>4</sup>-д гэмт хэргийн улмаас зөвхөн эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээд эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалт ёсоор санаа сэтгэл, нэр төр, алдар хүндэд учирсан эд хөрөнгийн бус хохирлыг эрүүгийн хэрэгтэй нь хамт шийдвэрлэх боломжгүй бөгөөд энэ тохиолдолд хохирлын асуудлыг иргэний журмаар дахин шийдвэрлэх шаардлагатай болдог.

Доромжлох гэж чухам юуг хэлэх вэ гэдгийг эрүүгийн хуульд тодорхой заагаагүй боловч ямар нэг зохимжгүй байдлаар бусдын нэр төр, алдар хүндийг санаатайгаар гутаасан үйл ажиллагааг доромжлол гэж эрх зүйн практикт ойлгож иржээ.

Энэ хэрэг нь иргэдийн нэр төр, алдар хүндийг гутааж байдаг учраас иргэдийн нэр төр, алдар хүнд нь гэмт хэргийн объект болдог. Нэр төр, алдар хүнд гэдэг ойлголтод зөвхөн иргэдийн нэр төр, алдар хүнд

<sup>4</sup> Монгол улсын хуулиуд. УБ 2002 он. 443 дугаар тал.

хамаарагдана. Түүнээс хуулийн этгээдийн нэр нь энэ хэргийн объект болж чадахгүй. Доромжлогдож байгаа хүн нь нэр төрөө гутаалгаж доромжлогдож байна гэдгийг ойлгох чадвартай эсэх, хэрэг гарах үед өөрөө биеэр байсан эсэх нь энэ хэргийн бүрэлдэхүүнд нөлөө үзүүлдэггүй байна. Энэ төрлийн гэмт хэргийг объектив талаас нь авч үзвэл ямар нэг зохимжгүй байдлаар бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан үйлдэл байх ёстой. Ямар нэг зохимжгүй байдал гэдэгт хүний эрх, эрх чөлөө, зан заншил, ёс суртахуунаар тогтоогдсон хэм хэмжээнээс гадуур хийгдсэн үйлдлийг хэлнэ гэж ойлгоход буруудахгүй. Тухайлбал, хүний хувийн шинж байдал тогтсон зан суртахуун болон аж байдлын журам горимд харш бөгөөд хүний хувийн зан төрхийг муутгасан шинж байдал, тодорхойлолт өгөхийг хэлж болно гэж үзэж байна. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг уг байдалтай нь холбон адилтгаж доромжлох үйлдэл байж болно.

Доромжлолын хэрэгт хүний хувийн шинж байдлыг муутган гутааж байгаа шинжүүд нь тэр хүнд үнэхээр байгаа тийм муу талуудтай нийцэж байгаа эсэх нь хэргийн бүрэлдэхүүнийг тогтооход ямар ч холбогдол байхгүй. Жишээлбэл, харааны согогтой хүнийг “хялар, долир” гэж хэлэх нь тэр хүний хараа муу байдалтай нийцэж байгаа боловч уг чанартаа түүнийг хялар долирт үзэж, нэр төрийг нь гутааж байгаа учраас доромжлол юм.

Доромжлол бол хүмүүсийн идэвхитэй үйл ажилгаагаар хийгдэнэ. Доромжлох нь ажиллагааны байдлаар амаар, бичгээр болон ямар нэг дохио хөдөлгөөнөөр хийгдэж болдог. Доромжлол нь идэвхгүй үйл ажиллагаагаар хийгдэх гэж байдаггүй. Доромжлол амаар хийгдэхдээ хуц уль, нохой гахай, илжиг, хялар солир гэх мэтийн үг хэлээр илэрхийлэгдсэн байдаг аж. Мөн дээрх доромжлолын чанартай үгийг бичих, хэвлэх янз бүрийн дүрсийн зураг зурах гэх мэт бичгээр хийснийг хамааруулан ойлгож болно. Бусад хэлбэрээр гэдэгт нүүр рүү нь нулимах, гараараа ямар нэг юмны дүрс гаргасан байх гэх мэтийг ойлгож болох юм.

Доромжлол нь хохирогчийн хувийн байдал, өөрөөр хэлбэл, нэр төр, алдар хүндийг гутаасан үйл ажиллагаа хийснээр төгссөн гэж үздэг байна. Тэр нь хохирогчийн болон хөндлөнгийн сонорт хүрч үнэхээр тийм ойлголт авсан буюу хохирогч доромжлогдлоо гэснийг ойлгосон нь хэргийн бүрдлийн зайлшгүй шинж биш юм. Доромжлолын хэрэгт завдалт гэж байдаггүй. Харин бэлтгэх ажиллагаа тухайлбал, бичгээр хийгдсэн тохиолдолд байж болох боловч түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Доромжлол нь хүндрүүлэн үзэх шалтгаангүйгээр бусдыг доромжилсон хэргийг хохирогчийн гомдлоор үүсгэдэг учир энэ тохиолдолд уг үйлдлээс болж хохирогчид заавал гомдох сэтгэгдэл төрүүлсэн байх ёстой мэт байна.

Өөрөөр хэлбэл, доромжлолын хэрэгт хохирогч бусдад доромжлогдлоо гэдгийг заавал ойлгосон байх мэт санагдаж болно. Тэгвэл энэ нь тийм бишээ. Доромжлол бол бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан үйлдэл хийснээр төгсдөг бөгөөд тэр нь хохирогчийн сонорт хүрсэн эсэх нь хэргийн бүрдэлд нөлөөлөхгүй. Хохирогчийн гомдол бол эрүүгийн хэргийн ойлголт биш харин эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ойлголт бөгөөд гомдол нь хуульд заасан тодорхой хэргүүдэд байцаан шийтгэх ажиллагаа явуулах эсэхэд шүүхээс анхаарах нөхцөл байдал юм.

Доромжлолын эсрэг хариу доромжлол гарч болдог бөгөөд ийм үед хийгдсэн доромжлолыг доромжлолын хэрэг гэж үзэн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцнэ.

Доромжлолын хэргээс болж хохирогч этгээд сэтгэл санааны талаар хүнд байдалд орох, түүнээс гутаж гуних зэрэг нь хэргийн бүрдэлд нөлөөлөхгүй гэж зарим судлаачид үзсэн нь эргэж харууштай зүйл юм. Учир нь энэ хэргээс болж хохирогчийн сэтгэл санаанд үүссэн гэм хорын асуудлыг нэн түрүүнд арилгах тал дээр анхаарч байх нь зүйтэйг хэлэх нь илүүц үг биш байх.

Энэ хэргийг субъектив талаас нь авч үзвэл гэмт этгээд уг хэргийг санаатай үйлдсэн байна. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд бусдад хандаж хэлсэн үг, бичсэн зүйл нь бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан шинжтэй гэдгийг ойлгосон төдийгүй, түүнийг хүсэж үйлдсэн байдаг. Доромжлол нь шууд санаатай байхаас гадна бас шууд бус санаатай ч байж болно. Субъект нь 16 нас хүрсэн сэтгэл мэдрэлийн хувьд хэрэг хариуцах чадвартай хүмүүс байдгаараа онцлогтой.

Бусдыг хэл амаар буюу үйлдлээр доромжлох нь ихэвчлэн нийгмийн хэв журам зөрчигдөх явдалтай уялдан гардаг учраас хэрэв олон нийтийн дунд эвгүй доромжлолын үг хараал хэлэх нь олон нийтийг илтэд үл хүндэтгэсэн үйлдэл бөгөөд зөвхөн хоёр этгээдийн хоорондын харилцаанаас хальсан байвал түүнийг танхайрсан гэмт хэрэг гэж шүүхийн практикт үзэж иржээ. Хохирогчийн хувьд түүний нэр төр, алдар хүндийг гутаасан шинжтэй боловч тодорхой худал (факт) баримтанд тулгуурлаагүй зүйлийг бусдад мэдэгдсэн үйлдлийг гүтгэлэг гэж үзэхгүй, харин доромжилсон хэрэг байж болно. Ийм учраас гүтгэлгийн хэрэгт ямар нэг тодорхой худал нөхцөл байдлыг тараасан байвал сая гүтгэлэг болно.

К. Маркс 1949 оны хоёрдугаар сард “Новый рейнск” сониныг ялласан шүүх хурал дээр гүтгэлэг ба доромжлолыг зааглан тэр үед Рейнск мужийн нутаг дэвсгэрт мөрдөгдөж байсан Францын эрүүгийн хуулийн ёсоор гүтгэлэг ба доромжлолын тухай заалтыг тайлбарлан хэлэхдээ “Гүтгэлэг гэдэгт юу тохирох вэ? гэвэл зэмлэгдэж байгаа хүнд аль нэг баримтыг тулгаж

буруушаахыг хэлнэ. Доромжлол гэдэгт юу тохирох вэ? гэж асуугаад “Ямар нэг өө сэв эрсэн, доромжилсон чанартай үг яриаг хэлнэ. Хэрэв “Та мөнгөн халбага хулгайлсан” гэж хэлбэл тэр хууль ёсоор таныг гүтгэсэн хэрэг. “Та хулгайч хүн харваас хулгайч шинжтэй хүн” гэж хэлбэл таныг доромжилсон хэрэг болно” гэжээ. Үүнээс үзэхэд гүтгэлгийн хэрэгт ямар нэг тодорхой баримт (факт) байх хэрэгтэй. Тухайлбал, тэр хээл хахууль авсан гэх мэт.

Хэдийгээр бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон шинжтэй боловч бодит үнэн байдлыг шүүмжлэх замаар тараасан байвал түүнийг гүтгэлэг доромжлол гэж үздэггүй байна. Мөн зориуд санаатай биш бодлогогүй хэлсэн үг, үйлдэл нь нөгөө талд бодит хор уршиг учруулаагүй, доромжилсон нь нотлогдоогүй бол гэмт хэрэгт тооцохгүй байх нь дэлхий нийтийн жишиг болсныг анхаарууштай юм.

Харин манай улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийг тайлбарласан тайлбарт-т “Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт бодит байдалд нийцэхгүй, өөр хэн нэгэн этгээдэд мэдээлсэн байхыг ойлгоно. Харин тийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан мэдээ тараасан гэж үзэхгүй. Уг мэдээ, мэдээлэл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр төдийгүй тухайн иргэний ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотоор буюу амаар өөр этгээдэд хүргэгдсэн байхыг ойлгоно. Өөр нэг л этгээдэд уг мэдээ мэдээлэл хүргэгдсэн байхад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэх үндэстэй”<sup>5</sup> хэмээн заасан байна. Жишээ: Иргэн Дорж нэгэн албан газарт ажилд орохоор болжээ. Гэтэл тухайн албан газрын дарга Доржийн өмнө ажиллаж байсан газраас түүний ажил байдлын тодорхойлолт ирүүлэхийг хүссэн байна. Доржийн ажлын газрын дарга нь түүнийг өөр газар ажиллах хүсэлт гаргасанд дургүйцэж түүний талаар “Таг дүлий юмтай нөхөр” гэж тодорхойлсноос болоод Доржийг тухайн албан газар ажилд авахаас татгалзсан байна. Доржийн тодорхойлолтонд дурьдсан мэдээлэл нь бодит байдалд нийцэж байсан ч Дорж өөрийн нэр төрийг гутаасан гэж үзэж шүүхэд хандах эрхтэй. Дээрх жишээ нь Доржийн талаарх мэдээллийг зөвхөн нэг этгээдэд шууд хүргэх замаар тараагдсан гэж үзнэ. Харин ийм мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (радио, телевиз, тогтмол хэвлэл гэх мэт) тараасан байж болно. Ийм мэдээ мэдээллийг мөн нэг удаагийн мэдээллийн хэрэгслээр, эсхүл ам дамжин тараасан байж болно. Ийм тохиолдолд уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгслийг ашиглан няцаалт хийх боломжгүй юм. Иймээс нэр төр нь гутаагдсан иргэний хүсэлтээр шүүх, мэдээ тарсан хүрээ, хэлбэр зэргийг

<sup>5</sup> Монгол улсын Иргэний хуулийн тайлбар.УБ 2005 он. 76 дугаар тал.

харгалзан үзэж өөр хэлбэр хэрэгслээр няцаалт хийх үүргийг эрх зөрчигчид хүлээлгэж болох юм.

Иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ямарваа нэгэн хэлбэрээр дүрслэн түүнийгээ нийтэд тарааснаас тухайн иргэнд гэм хор учирч болно. Ийнхүү дүрслэхдээ дүрслэгч нь тухайн иргэний нэр төрийг гутаах зорилго агуулаагүй ч тухайн гомдогчын хувьд нэр төрөө гутаагдсан гэж үзэх үндэстэй юм.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ хайрлан хүндэтгэж тэдний нэр төрийг эрх зүйгээр хамгаалах асуудалд анхаарлаа хандуулахыг зөвхөн хүний эрхийн төлөө зүтгэгчдийн хэрэг биш гэдгийг энэ дашрамд нийтэд хандаж хэлмээр байна.

## **“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОГДОХ ЁСТОЙ” ХЭҮК-ЫН ДАРГА С.ЦЭРЭНДОРЖТОЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА**

**Үндэсний чуулган зохион байгуулахтай холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг олон нийт нэлээд анхаарах болжээ. Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хүний эрхийн үүднээс тайлбарлавал?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эдлэж үүрэг хүлээдэг субъект биш, нийгмийн халамж, тусламж, дэмжлэгийг хүртэж байдаг объект мэтээр ойлгож, хандаж ирсэн хандлага дэлхийн аль ч улсад түгээмэл байсан. Ийм үзэл хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн ерөнхий хандлагаас тусгаарлагдаж, тусгай сургууль, ажлын байр, орон байраар “хангагдаж” байв. Харин 1980-аад оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх зүйн харилцааны субъект гэдгийг хүлээн зөвшөөрөх болсонтой холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хүний эрхийн үүднээс хандах болсон. Хөгжлийн бэрхшээлийн талаарх хүний эрхийн үзэл хандлагыг үндэс нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм зэрэг, тэгш байдал, салшгүй нэр төрийг хүлээн зөвшөөрөх явдал юм.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх гэж ямар эрхүүд байдаг вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын бүхий л эрхийг ямар нэг алагчлалгүйгээр эдлэх эрхтэй. Харин эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх арга зам нь ялгаатай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх гэж хууль тогтоомжоор баталгаажигдсан тусгай эрх байдаггүй. Харин ийм тусгай эрх байдаг мэтээр ойлгох, ярих нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах үзэл хандлагыг улам бүр дэврээх уршигтай юм. Тухайлбал, дохионы хэлний орчуулгатай телевизийн нэвтрүүлэг үзэх нь сонсголын бэрхшээлтэй хүний эрх биш, гагцхүү тухайн хүний мэдээлэл хүлээн авах эрхийг эдлүүлэх арга зам юм. Харин хүн хөгжлийн бэрхшээлтэй болсноор зөрчигдөх эрсдэлтэй тодорхой эрхүүд бий. Өөрөөр хэлбэл, хуулийн өмнө тэгш байх, алагчлалд өртөхгүй байх, тэгш боломжтой байх, хараат бусаар бие даан амьдрах, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох болон халдашгүй байх зэрэг эрх нь зөрчигдөх эрсдэлтэй байдаг.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бусдын нэгэн адил эрхээ эдлэх боломж нөхцлийг бий болгох нь хэний үүрэг хариуцлагын асуудал вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ эрхээ эдлэх нөхцөл бололцоог бий болгох нь юуны өмнө төрийн үүрэг хариуцлагын асуудал юм. Өөрөөр хэлбэл эрхээ эдлэх боломж нөхцлийг бий болгох үүргийн олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу төр иргэнийхээ өмнө хүлээдэг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний хамт олон, гэр бүлийн гишүүд мөн тухайн хүн өөрөө энэ асуудалд хариуцлага хүлээх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд олноор байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхээ эдлэх боломж нөхцлийг төр бий болгох үүрэгтэй гэж ярилаа. Тэгвэл төр энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх бүх талын боломж нөхцлийг бүрдүүлэхдээ төр 1993 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэм”-д заасан шаардлага, үйл ажиллагааг мөрдөн хэрэгжүүлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, энэхүү баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш боломж олгохын тулд авах арга хэмжээний талаар нарийвчлан заасан олон улсын жишиг стандарт юм. Удахгүй НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид ч бас төрийн хүлээх үүрэг хариуцлагын талаар тодорхой заалтууд орсон байгаа. Дүрэм, стандартад заасан шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хамгаалахын тулд хууль-эрх зүй, эдийн засаг, улс төр, нийгэм-сэтгэлзүйн орчинг бүрдүүлэх асуудал туйлын чухал байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн талаар товч танилцуулахгүй юу?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар олон улсын заавал биелэгдэх хууль зүйн хүчин чадалтай хэм хэмжээ бий болгох асуудал 1980-аад оноос хойш яригдаж эхэлсэн юм. Дэлхийн улс орнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын хүчин зүтгэлийн дүнд 2001 оны 11-р сард Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн эх бичвэрийг боловсруулах Түр Хороо байгуулах шийдвэрийг НҮБ-аас гаргасан бөгөөд Түр Хороо 5 жил ажилласны эцэст конвенцийн төслийг боловсруулсан юм. Конвенцийг тун удахгүй НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэж батлана. Тус конвенцид хөгжлийн



бэрхшээлтэй хүний эрхийг хангахад улс орнуудын хүлээх үүрэг, хөгжлийн бэрхшээлтэй хүний эдлэх эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хороо байгуулах тухай асуудлуудыг зохицуулсан. Тус Конвенц нь нэмэлт Протоколтой бөгөөд нэмэлт Протоколоор хувь хүн Конвенцийн Хороонд гомдол мэдээлэл хүргүүлэх журмыг зохицуулсан байдаг. Конвенц тухайн гэрээнд 20 улс нэгдэн орж, соёрхон баталснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх Монгол улсад хэр хангагдаж байна гэж та үзэж байна вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ эдлэх нөхцөл бололцоо манай улсад туйлын хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусламж, дэмжлэг, нийгмийн халамжийн объект гэж үзэх хандлага манайд амь бөхтэй оршсоор байгаагаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс “үл үзэгдэгч” байдлаар амьдарч байна. Төрийн үйлчилгээ, нийгмийн үйл хэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэрээсээ гараад явахад ямар нэг бэрхшээл хүндрэлгүй хүрэх газраа хүрдэг, хүссэн үйлчилгээгээ хүртдэг байх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бий болгох асуудал эдийн засгийн учир шалтгааны улмаас удаашралтай байгаа ч зарим нэг асуудлыг тушаал, журамд өөрчлөлт оруулах замаар хялбархан шийдвэрлэх боломжтой байгаа. Тухайлбал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” үндэсний чуулганаас гарах зөвлөмжид энэ талаар тусгайлан авч үзэх болно. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг бид төрийн ордноосоо эхлэх учиртай.

### **Хүний эрхийн үндэсний комисс байгуулагдснаасаа хойш хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд нэлээд анхаарч ажиллаж байгаа. Энэ талаар ХЭҮК-ын хийсэн ажлаас танилцуулахгүй юу?**

Комисс байгуулагдсанаасаа хойш нийгмийн эмзэг бүлгийн эрхийн асуудал, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар ихээхэн анхаарал тавин ажиллаж байна. Энэ жилийн Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах үндэсний чуулганыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” сэдвээр хийж байгаа нь ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудалд хандах Комиссын хандлагыг тодорхойлж байгаа гэж үзэж байна. 2003 онд ХЭҮК-оос “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” судалгааны ажлыг хийж, “Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл”-д оруулсан. Судалгааны дүнд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах орчин бүрдүүлэх талаар зөвлөмж гаргаж байсан юм. Түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” үндэсний

чуулганыг зохион байгуулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтцийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг нь хангах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн 2004 онд тус Комиссоос Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Эмзэг бүлгийн эрх” сэдэвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх олон улсын гэрээ конвенц, үндэсний хууль тогтоомжийн эмхтгэлийг эрхлэн гаргаж нийтийн хүртээл болгож байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ХЭҮК-т цөөнгүй гомдол гаргадаг. ХЭҮК-ын дэргэд ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудаас бүрдсэн Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын төлөөлөл бий.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандаж та юу хэлэх вэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын өмнөө тавьдаг уриа байдаг. “Бидэнгүйгээр бидний төлөө ямар ч асуудлыг шийдвэрлэхгүй” гэсэн утгатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд тэдгээр хүмүүсийн үүрэг оролцоо төрийн үүрэг хариуцлагатай эн зэрэгцэхүйц чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ эдлэх орчин нөхцлийг бий болгохыг төрөөс шаардах ёстой. Эрхээ шаардахын тулд юуны өмнө боловсрох, сурах, судлах хэрэгтэй. Боловсрохын тулд нийгмийн амьдралд оролцох шаардлагатай болох нь гарцаагүй. Мэдээж их бэрхшээлтэй туулах хэрэгтэй ч хүмүүс өөрсдөө идэвхтэй байх нь чухал юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал зөвхөн хэсэг бүлэг “золгүй” хүмүүсийн хэрэг биш гэдгийг бусад хүмүүс ойлгох хэрэгтэй. Учир нь хэн ч, хэзээ ч хөгжлийн бэрхшээлтэй болж болзошгүй байдаг учраас хөгжлийн бэрхшээлийн асуудал бол хүн бүрийн анхаарвал зохих асуудал. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй байна гэдэг нь “золгүй тавилан” биш байх ёстой. Энэ бол нас, хүйс, нийгмийн гарал гэдэг шиг онцлог нөхцөл байдлын нэг юм гэдгийг бүгд хүлээн зөвшөөрөх ёстой.

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАМБАРЫН ЭНХБАЯРЫН ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН ДЭЭР ХЭЛСЭН ҮГ**

**2006 оны 12 дугаар сарын 01-ны өдөр**

Үндэсний чуулганы хүндэт зочид, төлөөлөгчид өө

Ноёд, хатагтай нараа!

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаар зохион байгуулж байгаа энэхүү үндэсний чуулганы ажиллагаанд оролцож буй Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхныг ерөөе.

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулж, Монгол Улсын Төрийн тэргүүний ивээл дор хүний эрхийн тулгамдсан аливаа нэг асуудлыг үндэсний чуулганаар хэлэлцдэг сайхан уламжлал бий болж тогтсон. Өнгөрсөн онд хүний эрхийн олон улсын өдрөөр үндэсний анхдугаар чуулганыг зохион байгуулж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлыг хэлэлцэж, томоохон хэмжээний зөвлөмж гаргасан билээ. Энэхүү зөвлөмжийн заалт болон Улсын Их Хурлаас батлан гаргаж мөрдүүлсэн Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажил, үр дүнгээ Засгийн газрын гишүүн, хоёр сайд маань өнөөдрийн чуулганд илтгэх гэж байна. Хүний эрх, эрх чөлөөг хангах явдал бол нэг, хоёр өдөр хэлэлцээд шийдвэрлэх асуудал биш, хүний нийгэм оршин тогтнож, ардчиллыг хөгжүүлж буй улс орон бүрийн төр, засаг, иргэний нийгмийн байнгын анхааралд байх, тасралтгүй, бас уйгагүй ажиллагаа шаардсан үйл явц юм.

Анхдугаар чуулган дээр миний бие хэлсэн үгэндээ жил бүрийн энэ өдрийг Монгол Улсынхаа хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдтэйгээ хамтран хэлэлцэж, хүн бүрийн эрхийг хангуулахын төлөө бодит ажлыг санаачлан, түүнийхээ гүйцэтгэл, дүгнэлтийг хэлэлцдэг өдөр болгох тухай саналаа илэрхийлж байсан билээ. Энэ санаачлага ийнхүү бодит биелэлээ олж байгаад баяртай байна.

Энэхүү чуулганыг зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж Ерөнхийлөгчийн Тамгын Газартай хамтран ажилласан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо, олон улсын АЙФО байгууллага болон түүний ажилтнуудад гүн талархал илэрхийлье.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг энэ чуулганаар хэлэлцэх болсон нь олон учир шалтгаантай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань эрх зөрчигдөх, эрхээ эдэлж чадахгүй байх явдал түгээмэл байгаа нь Хүний Эрхийн Үндэсний Комисс болон бусад байгууллагуудын гаргасан судалгаа, дүгнэлт болон бодит амьдралаас илэрхий харагдаж байна. Үндсэн хуульд тунхагласан хүмүүнлэг нийгэм байгуулах зорилтын нэг чухал хэсэг нь хувь заяаны эрхээр хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэндээ тусалж, дэмжих явдал яах аргагүй мөн юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуульд заасан эрхээ баталгаатай эдлэх, тэдний эрх ашгийг зөрчиж буй аливаа үйлдэл, илрэлтэй тэмцэхэд өөрсдийн зүгээс идэвхтэй тэмцэж байгаа ч амьдрал дээр төдийлөн нааштай ахиц өөрчлөлт гарахгүй байна.

Саяхан НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг хэлэлцэн баталсан нь тэмдэглүүштэй хэрэг юм.

Хүний эрхийг хангаж, хамгаалах ажилд юуны өмнө нийгмийн эмзэг бүлэг болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хүүхдийн эрхийг хангаж хамгаалах ажлыг багтаах, тэднийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллыг нь эрс сайжруулахтай нягт уялдуулан зохион байгуулах, шаардлагатай байна.

Эдгээр хүмүүс нь төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн идэвхтэй оролцоо, дэмжлэг тусалсаагүйгээр хууль болон олон улсын гэрээнд заасан эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломж мөхөс, эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны хувьд чадамж нь хязгаарлагдмал байдгаараа онцлогтой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнх нь сурч боловсрох, авьяас чадвараа дайчлан өөрийгөө хөгжүүлэх, ам бүлээ тэжээх, гэр орноо өөд татахаас эхлээд улс нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахын төлөө чин эрмэлзлэл гарган, тэмцэж ажилладаг нь та бидэнд бүгдэд ажиглагдсан билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх, сайн сайхан аж төрж амьдрах зорилго, эрмэлзлэлээ биелүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлэх, эрхээ эдлэх боломж нөхцөл болон аятай таатай орчин бүрдүүлэх нь төр засгийн байгууллагуудын чухал үүрэг юм.

Энэхүү шаардлагыг үндэслэн миний бие хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг баталгаатай болгох, хууль эрх зүйн орчинг дээшлүүлэхийн тулд холбогдох 10 гаруй хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл санаачилж, Улсын Их Хуралд өргөн бариад байна. Эдгээр хуулийн төслүүдийг Улсын Их Хурал ойрын үед хэлэлцэж батлана гэдэгт найдаж байна.

Нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх нь Монгол улсын шинэ Үндсэн хуулийн эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан, нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсэн заалтад нийцсэн үйл хэрэг юм.

Иймийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүн бүхэнд элэгсэг дотно хандаж, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэдэнтэй хамтран ажиллах, хамт олонд түшиглэсэн сэргээн засах ажиллагааг өргөжүүлэх, тэдэнд анхаарал халамж тавих хөдөлгөөн өрнүүлэх зэргээр аятай уур амьсгал бий болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийгэм сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх нь нэн чухал байна.

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд эрхээ эдлэх тэгш боломж, нөхцөл бүрдүүлэхийн тулд хүний эрхийг алагчлан гадуурхахгүй, адил тэгш байх үндсэн зарчимд тулгуурлан төрийн болон төрийн бус байгууллагууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

1. Төв, суурин газрын гудамж, замын гарцууд, уулзварууд болон нисэх, төмөр зам, орон сууц, эмнэлэг, сургууль, албан газар, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, давхрын шатанд тэргэнцэртэй хүнд зориулан зохих стандартын дагуу зам барих;
2. Хараагүй буюу харааны согогтой хүмүүст зориулан гудамжны дагуу явган хүний зам болон замын гарц уулзварт хөтөч чиглүүлэгч болох тусгай зам, дуут гэрлэн дохиолол тавих, хана багананд зориулалтын тэмдэглэгээ байрлуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бие засах болон ариун цэврийн өрөө бий болгох;
3. Сонсгол хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн эмнэлэгт үзүүлэх, эмчлүүлэх, янз бүрийн шалтгаанаар эрх зүйн харилцаанд оролцох нь ойлголмжтой. Ийм учраас холбогдох байгууллагууд дохионы хэлний орчуулагчтай болох асуудлыг судлан шийдвэрлүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сурч боловсрох, мэргэжил эзэмшихэд нь бүх талын дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй үнээр мэргэжил олгох, суралцах орчныг нь бүрдүүлэх арга хэмжээг авах.
5. Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө хөдөлмөрлөх, хувиараа аж ахуй эрхлэх, аль нэг аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж, хөдөлмөрлөх боломж нөхцлийг нь бүрдүүлэх, энэ талаар дэмжлэг туслалцаа үзүүлдэг байгууллага хамт олныг урамшуулдаг хөшүүрэг бий болгох.

Нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгай хэрэгсэл болох хэрэгцээ шаардлага хангахуйц, эдэлгээний аяг даах чанартай тэргэнцэр, сонсголын аппарат зэрэг тэдэнд шаардагддаг өдөр тутмын хэрэгцээний зүйлээр хангах нь тэдний эрхээ эдэлж, тав тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг хангасан орчин, дэд бүтцийг бий болгох нь хөрөнгө мөнгөний гэхээсээ сэтгэлгээ, ажлын арга барилын хөрөнгө оруулалтыг илүүтэй шаардаж байна. Өнөөдөр олон тоогоор ашиглалтанд орж буй орон сууц, барилга объектуудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулагдсан олон улсын стандарт жишигт нийцсэн нэг ч тоноглол, төхөөрөмж байхгүй байгааг хүний эрхийн байгууллагууд зүй ёсоор шүүмжилж байна.

Энэ бүгдийг шийдвэрлэхгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, хамгаалах асуудал дорвитой үр дүнд хүрэхгүй гэдгийг хаана хаанаа ухамсарлаж ойлгох хэрэгтэй байна.

Эрхэм нөхөд өө,

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн маань дийлэнх олонх нь сурч боловсрох, хийж бүтээх, хөгжих хүсэл эрмэлзэлтэй, амьдралын төлөө өрнүүн сэтгэлээр зүтгэгдэг, оюунлаг хүмүүс байдаг. Тэдэнд сэтгэлийн дэм, хүнлэг нөхөрсөг харьцаа, тусч энэрэнгүй хандлага хэрэгтэй байна. Ийм хандлага чиглэлийг төр засаг, иргэний нийгэм, иргэдийн зүгээс бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүний өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, дэмжлэг, тусалцаа үзүүлэх, учирч буй бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замыг нарийвчлан тодорхойлж, оновчтой шийдэлд хүрэхэд өнөөдрийн чуулганы гол зорилт оршиж байна.

Чуулганыхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, үнэтэй санал дүгнэлт гаргахыг Та бүхэнд уриалж байна.

Үндэсний Чуулганы ажилд амжилт хүсье.

## **ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД ЗОРИУЛЖ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ ПРАТИБА МЕТАГИЙН ХЭЛСЭН ҮГ**

**2006 оны 12-р сарын 01**  
**Улаанбаатар хот, Монгол улс**

Эрхэмсэг ноён, Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраа  
Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид, ноёд, хатагтай нараа

Миний бие Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийг төлөөлөн Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй хүний эрхийн байгууллагуудын хоёр дахь удаагийн Үндэсний чуулганы төлөөлөгчид та бүхэнтэй мэндчилж байгаадаа таатай байна. Жил бүр зохион байгуулагддаг энэхүү арга хэмжээ нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор үндэсний хэмжээнд авч буй арга хэмжээг бэхжүүлэх, нийгэмд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг тусгайлан хэлэлцэх, Монгол улсад хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бодитой санал, зөвлөмжүүдийг боловсруулж, түүнд эрх бүхий албан тушаалтнуудын анхааралд хандуулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ.

Өнгөрсөн жилийн Үндэсний Чуулганаас гарсан зөвлөмжүүдийн хэрэгжилт энэ жилийн туршид янз бүрийн төвшинд хэлэлцэгдэж байсан бөгөөд өнөөдрийн чуулганы хөтөлбөрт ч тэдгээр зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэхээр тусгажээ. Энэ нь тухайн асуудлаар ахиц дэвшил гаргах үүднээс Чуулганыг зохион байгуулагчдаас авч буй арга хэмжээ гэдэг нь харагдаж байна.

Түүнчлэн Ерөнхийлөгчийн Тамгын газраас гарсан санаачлагын үр дүнд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг жил бүр зохион байгуулагдах энэхүү арга хэмжээний үеэр тогтмол хэлэлцэж байх сайхан уламжлал тогтож байна.

Өнөөдрийн Чуулганаар бид тусгай асуудлаар ярилцлага өрнүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах явдлыг баталгаажуулахад чиглэгдсэн зөвлөмжүүдийг батлан гаргах гэж байна.

Түүхийн өнгөрсөн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс “үл үзэгдэгч”-ийн зовлонг туулж, эрх эдэлдэг субъект гэхээсээ илүүтэйгээр

эмчилгээ сувилгаа, халамж хамгаалал, тусламж дэмжлэгийн объект хэмээн үзэгдэж ирсэн билээ. Тэдний эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, сонгох, соёлын амьдралд оролцох зэрэг үндсэн эрх, эрх чөлөөгөө бусадтай адил тэгш эдлэх боломж нөхцөл нь хязгаарлагдсаар ирсэн.

Сүүлийн хорь гаруй жилд дээрх үзэл баримтлалд эрс өөрчлөлт гарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх, эрх чөлөөний эзэн гэдгийг хүлээн зөвшөөрөх болжээ.

Энэхүү үзэл хандлагад гарсан өөрчлөлт Нэгдсэн Үндэсний Байгууллагын үйл ажиллагаагаар нотлогдож байгаа бөгөөд 1981 оныг **Хөгжлийн бэрхшээлтэй хүний олон улсын жил** болгон зарласнаас хойш олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан хөгжлийн хэд хэдэн чухал арга хэмжээнд энэ асуудал тусгалаа олсон байдаг.

1982 онд Ерөнхий Ассамблейгаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдрал ба хөгжилд оролцох “тэгш байдал”, “бүрэн дүүрэн оролцоо”-г хангахад чиглэгдсэн дэлхийн стратегийн удирдамжуудыг агуулсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх Дэлхий Үйл ажиллагааны Мөрийн Хөтөлбөрийг** батлан гаргасан юм.

1993 онд Ерөнхий Ассамблейгаас Дэлхийн Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн залгамж болох **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмүүдийг** батлан гаргасан. Стандарт дүрмүүд нь “хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нь нийгмийн гишүүн болохынхоо хувьд бусадтай нэгэн ижил эрх эдлэж үүрэг хүлээх” явдлыг баталгаажуулахад чиглэгдсэн бөгөөд тэгш оролцоог хангахад саад учруулж буй хүчин зүйлсийг арилгахыг улс орнуудаас шаардсан байдаг.

2001 оны 12 дугаар сард Ерөнхий Ассамблей хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрхэм зэргийг хамгаалах, хөхиүлэн дэмжих өргөн хүрээтэй, цогц конвенцийн төслийг боловсруулах Түр Хороог байгуулсан билээ.

2006 оны 8 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо Түр Хорооны 8 дахь удаагийн хуралдаан зохион байгуулагдаж, 8 дугаар сарын 25-нд Түр Хороо **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын Конвенцийн төслийг** баталсан юм.

Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандахын гол агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрх зүйн этгээд гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал байдаг. Өнөөдрийн Чуулганы үндсэн зорилгын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрх мэдэл олгох явдлыг хөхиүлэн дэмжих, Чуулганы ярилцлага, зөвлөмжүүдээрээ дамжуулан тэдгээр хүмүүс өөр



өөрсдийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй бөгөөд нийцтэй байдлаар улс төр, эдийн засаг, нийгэм болон соёлын амьдралд оролцохыг өмгөөлөн хамгаалах явдал юм.

Өнөөдрийн Чуулган биднийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгчид мөн гэдгийг харуулаад зогсохгүй хүний эрхийг хамгаалан баталгаажуулах нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх арга зам мөн гэдгийг танин мэдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт би итгэлтэй байна.

Эцэст нь өнөөдрийн Чуулганыг зохион байгуулахад оруулсан Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хүчин зүтгэлд талархалаа илэрхийлье.

Эрхэмсэг нөхөд, хүндэт төлөөлөгчид, ноёд, хатагтай нараа,

Та бүхний Чуулганы ажилд амжилт хүсье.

Баярлалаа.

## **УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Т.ГАНДИГИЙН ХЭЛСЭН ҮГ**

Монгол Улсын Ерөнхийлөгчөө,

Эрхэм хүндэт чуулганы зочид, төлөөлөгчид өө,

Та бүхний энэ өдрийн амрыг эрэн мэндчилж байна.

Удахгүй болох гэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийн мэндчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэднийг дэмжин тусладаг сайн санаат хүн бүрт хүргэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нэг дор хуран цугларч асуудлаа харилцан ярилцаж, оновчтой шийдэлд хүрэхийг зорьж байгаа нь хүний эрхийг хангахад чиглэсэн чухал үр дүнтэй алхам гэж үзэж байна.

Олон улсын чиг хандлагад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахад түлхүү анхаарсан, боловсрол, соёл, эрүүл мэнд, нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгааллын зохистой хууль эрх зүйн орчин бий болгохын төлөө Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо ажиллаж байна.

Улсын Их Хурлаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зарчим, бодлого нь Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд тусгалаа олж Засгийн газар хэрэгжүүлж байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх халамж, асрамжийн үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж, тэтгэвэр, тэтгэмж олгох, төрийн үйлчилгээний болон төрийн бус байгууллагын гүйцэтгэх үүрэг чиглэлийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд тодорхой тусгаж өгсөн. Түүнчлэн энэхүү хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүн дотоодын их дээд сургуульд элсэн орвол сургалтын зардлыг төр хариуцах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл хүүхэдтэй хамт сурч боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, тусгай сургуулийн багш, ажиллагчдад нэмэгдэл хөлс олгох зэрэг асуудлыг баталгаажуулсан билээ.

Цаашид Боловсролын тухай багц хуулийг энэ оны намрын чуулганаар хэлэлцэх явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын талаар дэмжсэн заалтуудыг тусгахаар ажиллах болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах асуудал зөвхөн төрийн үүрэг мэт үздэг хандлага зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийнхөө эрхийн төлөө төртэй хамтран ажиллах чиглэлээр өөрчлөгдөж байгаа нь бидний үйл ажиллагаанд гарч байгаа нэг чухал алхам гэж ойлгож байна.

Өнөөдөр манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрхээ мэддэг болж, эрхээ эдлэхийг хүссэн чин эрмэлзэлтэйгээр дуу хоолойгоо нийгэмд хүчтэй хүргэдэг болсон байна. Энэ чуулганы үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах өнөөгийн нийгмийн хандлага, үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Чуулганы үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхээ эдлэхэд учирч буй саад бэрхшээлийг бодитоор гаргаж ирэх, түүнийг шийдвэрлэх зөв оновчтой арга зам, гарцыг тодорхойлоход ашиг тусаа өгнө гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсад анх удаа зохион байгуулагдаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх Үндэсний чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Ариун цагаан буянт үйлс дэлгэрэх болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

## ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АНХДУГААР ЧУУЛГАНААС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ТУХАЙ

*УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн,  
Мэргэжлийн хяналт асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх*

Эрхэм хүндэм Монгол Улсын Ерөнхийлөгч өө!

УИХ, Засгийн газрын гишүүд ээ!

Хүндэт төлөөлөгчид, хатагтай, ноёд оо!

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн асуудлаарх Үндэсний Чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулахаар шийдвэрлэснийг талархалтайгаар хүлээн авсан билээ.

Эх орныхоо өнцөг булан бүрээс төлөөлөл болон хүрэлцэн ирсэн Та бүхэнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” сэдвээр 2005 онд зохион байгуулсан хүний эрхийн байгууллагуудын Үндэсний чуулганаас гарсан зөвлөмжид Засгийн газраас хариуцаж биелүүлэхээр заасан 22 асуудлыг зохих түвшинд биелүүлж ажиллаа. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр Засгийн газраас өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар 3 бүлэг багцлан товч илтгэе.

### НЭГ. ҮНДЭСНИЙ ХөТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ хийх, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудаас зохион байгуулж байгаа бүх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Үндэсний хөтөлбөрийн Хорооны бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газрын 2005 оны 167 дугаар тогтоолоор баталсан.

Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүй, техник-зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын албыг 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2006 оны 3-р сард Хууль зүй, Дотоод хэргийн яамны бүтцэд байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээ.

Энэ хугацаанд төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад салбар хороодыг байгууллаа. Мөн Үндэсний Хөтөлбөрийн Хорооны анхдугаар хуралдааныг зохион байгуулж, 2006-2008 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцүүлэн Засгийн газрын хуралдаанд оруулахад бэлэн болголоо.

## **ХОёр. АЮУЛГҮЙ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР**

Монгол улсад мөрдөгдөж байгаа 300 гаруй хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулах ажлыг Засгийн газар хариуцан гүйцэтгэж байна. 2006 онд Монгол Улсын Их Хурлаас 25 бие даасан хуулийг батлаж, 58 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Зөвлөмжид нэр дурдсан хуулиудаас Химийн хорт ба аюултай бодисын тухай хуулийг шинэчлэн найруулж батлуулсан ба Эрүүл мэндийн тухай, Эмийн тухай, Байгаль орчны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, Хүнсний тухай хуулийг шинэчлэн найруулах болон Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хуулийн төслийг тус тус боловсруулж байна.

Үндэсний 125 стандартыг шинээр буюу шинэчлэн баталж, олон улсын 37 стандартыг үндэсний стандарт болголоо.

УИХ, Засгийн газрын тогтоолоор баталсан 162 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсронгуй болгоход ч ихээхэн анхаарч ажилласан.

Ийнхүү хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд төрийн бус болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулах, санал дүгнэлтийг нь тусгах зэргээр хамтран ажилласан.

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн зарим томоохон үзлэг шалгалтуудын талаар Та бүхэнд товчхон танилцуулья.

### ***Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:***

Улсын Мэргэжлийн Хяналтын газраас 2005 онд хийсэн шалгалтаар хаврын тариалалтанд зориулан 11 салбарт хадгалагдаж байсан буудайн үрийн дөнгөж 19.0% нь тарих үрийн стандартын шаардлага хангаж, үлдсэн 81% нь тэнцэхгүй дүн гарч байсантай холбогдуулан зохих арга хэмжээ авсны дүнд 2006 оны хаврын тариалалтанд ашигласан үрийн 61% нь стандартын шаардлагад тэнцэж, үрийн чанарт мэдэгдэхүйц ахиц гарлаа.

Хиам, ундаа, кремтэй бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд эгзэгтэй цэгийн эрсдлийг хянах судалгаат хяналтыг хийж, үйлдвэрийн дотоод хяналтын мэргэжлийн ажилтнуудад тогтмол сургалт явуулснаар хордлого, хордлогот халдварын тохиолдлын тоо жил бүр буурч байна. Мөн огноо тавигдаагүй хиам, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүний хадгалалтыг зогсоож, халгалалтын онцгой нөхцөл шаардагдах бүтээгдэхүүнийг хөргөлттэй автомашинаар зөөвөрлүүлдэг болсон нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чухал арга хэмжээ боллоо.

2006 онд Улсын Мэргэжлийн Хяналтын газр, Үндэсний Татварын газрын хамтран хийсэн шалгалтаар үйлдвэрлэлд тавигдах стандарт, техник, технологийн шаардлагыг хангаагүй 12 аж ахуйн нэгжийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, 2 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлүүлээ.

Манай улс 2005 онд 31 нэр төрлийн 550 мянга гаруй тонн хүнсний бүтээгдэхүүн импортлосны 40 гаруй хувийг Улсын Мэргэжлийн Хяналтын газрын дэргэдэх лабораторид шинжлэхэд тэдгээрийн 2.5 хувь нь стандартын шаардлага хангаагүй байсныг илрүүлж, хүн амд тохиолдож болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийллээ.

Улсын Мэргэжлийн Хяналтын газрын дэргэд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Лавлагаа, лабораторын барилга барих, техникийн чадавхийг бэхжүүлэх төсөл боловсруулж, МУ-ын Ерөнхий сайдын 2006 оны 11-р сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр эцэслэн шийдвэрлүүлээ. Энэхүү лабораторыг байгуулснаар хүнсий бүтээгдэхүүнийг шинжлэх цар хүрээ өргөжин шинжилгээний аргууд боловсронгуй шуурхай болж, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдлоо өгөх болно.

### ***Эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр***

Чанарын шаардлага хангагдаагүй баригдсан болон баригдаж байгаа барилга байгууламжуудын талаар шат дараалсан арга хэмжээ авч байна. Тухайлбал, барилга угсралтын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл аваагүй барилга угсралын ажил гүйцэтгэсэн 15 барилга, байгууламжийг хэрэглээний ус, цахилгаанаар хангахгүй байх арга хэмжээг авлаа. Мөн барилга байгууламжийн газар олголт, зураг төсөл хянах, ашиглалтанд оруулахад эрүүл ахуй, халдвар судлалын хяналт хийдэг болсноор 2006 оны эхний 10 сарын байдлаар шинээр баригдах 256 барилгын зураг төслийг хянаж, 352 зөрчил илрүүлэн арилгууллаа.

Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдсан бүх барилгын судалгааг гаргаж 1960-1980 оны хооронд баригдсан 3 барилгыг сонгон авч паспортжуулан санал дүгнэлийг хүргүүлсний дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын

газраас 1950 оны сүүлч 1960 оны эхээр баригдсан 40, 50 мянгатын хуучин барилгуудад холбогдох арга хэмжээг авч эхлээд байна.

Сүүлийн 16 жил техникийн шинэчлэлт үндсэндээ хийгдэхгүй байгаа өргөх байгууламжийн салбарт ажиллагсдын аюул осолгүй ажиллаж, амьдрах эрх ашгийг хамгаалах үүднээс улсын хэмжээнд өргөх механизмийн шинэчлэсэн бүртгэлийг явуулж 2004 оноос ашиглаж байгаа лифт болон автокраныг хамруулан техникийн магадлалыг тогтмол хийдэг болгосноор болзошгүй эрсдлийг бууруурах нөхцөл сайжирч байна.

Автозам, замын байгууламжид ашиглалтын түвшин тогтоодог болсон төдийгүй, автозам, замын байгууламжийн барилга, угсралтын ажилд ашиглагдаж байгаа материалд химийн бүрэн шинжилгээ хийдэг болсны үр дүнд авто замын барилгын болон хяналтын ажлын чанарт ихээхэн ахиц гарч байна.

“Дугуйн зам ба явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын стандарт”-ыг боловсруулж байна. Уг стандарт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс зам, талбайн налууг оновчтой тогтоох, зам хөндлөн гарах үед гэрлэн дохионы байршлын мэдрэмж, зориулалтын товгор зам зэрэг аюулгүй байдлыг хангах олон хүчин зүйлийн цогцолбор бүхий аятай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Энэхүү стандартыг боловсруулах явцад Баянгол зочид буудлын автобусны буудлаас Хүүхдийн ордон хүртлэх 100 гаруй метр замыг болон Хүүхдийн ордны гаднах шатыг шинэчлэн засварлаад байна.

Уул уурхайн олборлолтонд өртсөн газрын нөхөн сэргээлтийг сайжруулах чиглэлээр авч байгаа олон арга хэмжээний үр дүнд техникийн нөхөн сэргээлт 2003 онд дөнгөж 3%-тай байсан бол 2006 оны эхний хагас жилийн байдлаар 41.6% болоод байна. Цаашид биологийн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх талаар ихээхэн анхаарч байна. Энэ ч үүднээс 9 сард Өвөрхангай аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж буй Гацуурт ХХК-ны биологийн нөхөн сэргээлтийг алт олборлож буй 60 орчим аж ахуйн нэгж, байгууллагуудыг оролцуулан үзүүлэх сургууль зохион байгуулсан нь үр дүнтэй ажил болсон. Энэ оноос эхлэн нөхөн сэргээлтийг үлгэр жишээ хийж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон шалгаруулж, урамшуулж байна. Нөхөн сэргээлт сайн хийсэн аж ахуйн нэгжүүдийг урамшуулж, дэмжихийн зэрэгцээ ашигласан талбайдаа нөхөн сэргээлт хийхгүй хаяж явсан болон нөхөн сэргээлт хийгээгүйгээс экосистемд олон зуун сая төгрөгийн хохирол учруулсан хэд хэдэн компанид эрүүгийн хэрэг үүсгээд байна.

Байгаль орчны хуулиудын дотор Ойн тухай хуулийн зөрчил 45-52 хувийг эзэлж байгаа ой модыг мөнгө олох төлбөрийн хэрэгсэл болгож,

хууль бусаар мод бэлтгэх ажиллагаа тасрахгүй байгааг харуулж байна. Ийм ч учраас мод, модон материалын худалдаалалтанд тавих хяналтыг эрчимжүүлэх, хууль бусаар мод бэлтгэх явдалтай тэмцэхэд, таслан зогсооход ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Мөн химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх материал, түүхий эдийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, ашиглалт, борлуулалт тавих хяналтыг эрчимжүүлэх, энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, агаар, ус, орчны бохирдлыг багасгах талаар төрийн захиргааны төв байгууллагууд, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд олон төрлийн арга хэмжээг санаачлан зохион байгуулж байгааг дурдахыг хүсч байна.

Өөрийн гэсэн цэвэрлэх байгууламжгүй, бохир, цэвэр усны төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй 70 гаруй арьс ширний үйлдвэр Улаанбаатар хотод ажиллаж байсныг шалгаж, 40 болгож, эдгээр үйлдвэрүүд нь нэг цэгт төвлөрөн, “Харгиа” ХК-ийн цэвэрлэх байгууламжид хаягдал бохир усаа нийлүүлдэг болсон нь нийслэл хотын болон Туул голын усны болон хөрсний бохирдлыг бууруулахад зохих нөлөө үзүүлсэн ач холбогдолтой ажил болсон.

Цацрагийн үүсгүүрүүдийг улсын бүртгэл, хяналтанд байнга хамруулж, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл, мэргэжлийн шарлагын тун, зөвшөөрөл олголт болон хяналт шалгалтын бүхий л мэдээллийг багтаасан иж бүрэн мэдээллийн системийг ашиглаж эхлээд байна.

“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 02, 06 тоот албан даалгавар гарч, үүнийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгон тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Энэ хугацаанд 10842 байгууллага, аж ахуйн нэгж, 223771 айл өрхөд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, гал түймрийн хэрэг зөрчилд хүргэж болзошгүй 149648 зөрчлийг илрүүлж, 63459 зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Ой хээрийн болон объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар 911 лекц, 2166 удаагийн яриа, танилцуулга хийж, сонин хэвлэлд 274 удаа сэрэмжлүүлэг, сурталчилгаа явуулж, радио, телевизээр 594 удаа мэдээ, мэдээлэл гаргаж, 12413 зурагт хуудас тараан үзүүлэх сургуулийг 375 удаа зохион байгуулсан.

### ***Хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр***

Эмийн сангуудын эмийн зохисгүй хэрэглээг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа зөрчлийг таслан зогсоох, хүн амд энэ талын мэдлэг олгох үүднээс 2004 онд улсын хэмжээнд хийсэн шалгалтын мөрөөр “Эмийн жорын



маягт, жор бичилт” MNS5376-2004 стандарт батлагдаж гарснаар 2006 онд дээрх зөрчил 10-12%-иар буурсан байна.

2005, 2006 онд Монгол улсад анх удаа хуурамч эмийн тандалт, судалгааг хийхэд 2005 онд судалгаанд хамрагдсан эмийн 13% нь стандартын бус эм, 13% нь хуурамч эм болох нь тогтоогдож байсан бол 2006 оны судалгаанд хамрагдсан эмийн 10.7% нь стандартын бус эм, 6.3% нь хуурамч эм болж, хуурамч болон стандартын бус эмийн тоо хэмжээ мэдэгдэхүйц буурсан. Эмийн хуулийн хэрэгжилтээс хамгийн хангалтгүй байсан эмийн бүртгэлийн хэрэгжилтийн зөрчил 2004 онд 23.9%-ийг эзлэж байсан бол 2006 оны эхний хагас жилд 1.6% болж буурчээ.

2003-2006 онд улсын бүртгэлийн жагсаалтанд бүртгэгдээгүй хаяг, шошгийн зөрчилтэй 293820 кг, 150700 л буюу 14.3 сая төгрөгийн биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хүн амын хүнсний хэрэгцээнээс хасч, устгах арга хэмжээ авлаа.

2004 оны улсын хэмжээнд гарсан эхийн эндэгдэлт судалгаа хийсний үндсэн дээр эхийн эндэгдлийг бууруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, эхийн эндэгдлийн аюултай тохиолдлыг бүртгэх журам, эхийн амрах байрны бүтэц үйл ажиллагааг боловсруулж, биелэлтийг хангаж байгаа нь эхийн эндэгдлийг бууруулахад багагүй ач холбогдолтой арга хэмжээ болж байна.

2006 онд Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг холбогдох төрийн байгууллага болон тамхины худалдаа, импорт, үйлчилгээ эрхэлдэг 4528 аж ахуйн нэгжид шалгалаа. Шалгалтын үр дүнд тусгай зөвшөөрөлгүй тамхи импортлох үйл ажиллагаа явуулж байсныг зогсоолоо.

Мөн ерөнхий боловсролын сургуулиудын анги дүүргэлтийн норм, нормативыг улсын хэмжээнд шалгаж, аймгуудын төв, нийслэлийн олонх дүүргийн анги дүүргэлтийн дундаж 40-өөс дээш зарим сургуулийн хувьд 60-62%-д хүрч, анги танхимын агааржуулалт, чийглэгийн хэмжээ багасаж, төрөл бүрийн халдварт өвчин тархах нөхцөл бүрдүүлснийг тогтоосны үр дүнд нийслэлийн бүх дүүргүүд, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргоор шинэчлэн тогтоосон, боловсрол, сургалтын байгууллагын эдэлбэр газрын асуудлаар холбогдох арга хэмжээ авч байгаа зэрэг сурагч, багш нарын ажиллах орчин нөхцлийг сайжруулах чиглэлд тодорхой ажил хийгдэж эхлээд байна. Эдгээр ажлуудыг хийсний үр дүнд зарим үр дүнд гарсныг товчхон дурдья.

Хүний эрхийн байгууллагуудын Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас өнгөрсөн нэг жилийн хугацаанд дээр дурдсан ажлуудыг хийж багагүй үр дүнд хүрсэн байна. Тухайлбал:

1. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн эрх зүйн орчныг боловсронгуй болох чиглэлээр холбогдох хуулийг шинэчлэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулсны зэрэгцээ хөгжил дэвшлийг залуурдагч хэрэгсэл гэж яригдах болсон стандартуудыг өнөөгийн хэрэгцээ, шаардлага, хөгжлийн түвшинд нийцүүлэн шинэчлэн ажлууд зохих ёсоор хийгдлээ.
2. Улсын хэмжээнд санал дүгнэлт гаргаж, түүний мөрөөр нийгэм, байгаль орчинд эерэг, үр нөлөөтэй арга хэмжээ авах байдлаар хяналт шалгалтын ажлыг төлөвлөн зохион байгуулах бодлого, чиглэл баримтладаг боллоо.
3. Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн хэв журам зөрчигдөх, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хүчний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн байна.

Ийнхүү Засгийн газраас хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах чиглэлээр олон ажлуудыг төлөвлөн хийж, бодитой үр дүнд хүрсэн хэдий ч зөвлөмжид дурдагдсан зарим ажлууд шаардлагын түвшинд хүртэл хийгдэж чадаагүй байгааг хүлээн зөвшөөрөх ёстой.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хот төлөвлөлтөд иргэд, оршин суугчдын оролцоог хангах, тэдний санал, санаачлагад тулгуурлан өмчлөгдсөн газарт дахин төлөвлөлт хийж, дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх замаар амьдрах нөхцлийг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Хот байгуулалт, төлөвлөлтийн онцлог шаардлага бүхий газарт барилга барих асуудлыг төсөл сонгох шалгаруулах замаар шийдвэрлэх хэрэгтэй байна. Мөн төв суурин газрын авто зам, газар доорх явган зорчигчийн нүхэн гарц хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих зам болон шат, авто машины зогсоол, гарц, уулзварыг орчин үеийн хот байгуулалтын техникийн шаардлагад нийцүүлэх ажил удаашралтай байна гэж үзэж байна. Түүнчлэн орчны бохирдлыг бууруулах цогц бодлого, бодит ажил үгүйлэгдэж байгааг хэлэх хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан цаашид доорх ажлуудыг анхаарч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

1. Шинэ тутам байгуулагдаж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг хүний эрхэд суурилсан эрх зүйн зохицуулалттай болгох
2. Хууль хяналтын байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, тэдгээрийн дэргэдэх лабораториудын материаллаг баазыг бэхжүүлэх, ажилтнуудынх нь нийгмийн баталгааг сайжруулах
3. Хүнсний бүтээгдэхүүн, химийн хорт болон аюултай бодисын импорт, үйлдвэрлэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд тавих хяналтыг сайжруулах, хүн амын зохистой хоол хүнс хэрэглэх мэдлэг дадлагыг дээшлүүлэх
4. Хот суурин газрын хот байгуулалт, төлөвлөлтийг орчин үеийн хот байгуулалтын техникийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах

5. Агаар, ус, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр сургалт, сурталчилгааг оновчтой хэлбэрээр зохион байгуулж, цогц үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх
6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхой авч хэрэгжүүлэх
7. Байгалийн гамшигтай тэмцэх, ой хээрийн түймрээс сэргийлэх, унтраах арга ажиллагаанд ард иргэдийг сургах, мэдлэг олгох ажилд өөрчлөлт гаргах
8. Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйлүүдийг судлаж, түүний мөрөөр арга хэмжээ авч хэвших. Мөн хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа иргэнд гэм хор учруулбал нөхөн төлүүлэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох ажлуудыг анхаарч зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Энэ чиглэлийн асуудлаар холбогдох байгууллагууд асуудал боловсруулах удирдах байгууллагадаа оруулахаар бэлтгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Чуулганы ажиллагаанд амжилт хүсье.

## МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХөТөлБөРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, ЦААШИД ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛУУД

Д.Одбаяр,  
Хууль зүй, дотоод хэргийн сайд

Монгол Улсын Ерөнхийлөгчөө!

Үндэсний Чуулганд оролцогч хүний эрхийн байгууллагын төлөөлөгчид,  
зочидоо!

2003 онд Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг баталсан нь “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн Үндсэн хуулийн тунхаглал амьдралд хэрэгжихэд бодитой түлхэц болсон билээ. Хөтөлбөр батлагдснаас хойшхи 3 жилийн хугацаанд хөтөлбөрт тусгагдсан зарим зорилтууд тодорхой хэмжээнд шийдвэрлэгдээд байна.

Сонгуулийг олон мандаттай тойргоор явуулах, түүнчлэн нам, эвсэл сонгуульд оролцох, эвслийн гэрээ байгуулах, сонгуульд нэр дэвших, нэр дэвшигчдэд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхой болгох, сонгуулийн зар сурталчилгаа, сонгууль явуулах журмыг боловсронгуй, олон нийтэд нээлттэй болгох зэргээр сонгуулийн тогтолцоог бүхэлд нь шинэчилсэн УИХ-ын сонгуулийн тухай хууль батлагдлаа. Энэ хууль батлагдснаар гадаад улсад амьдарч байгаа манай иргэд сонгуульд оролцох, нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх, ээлжит сонгууль явуулахын өмнөх 6 сарын дотор сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх зэрэг хүний эрхийг өргөтгөсөн нилээд тодорхой зохицуулалтууд тусгагдсан.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн үндсийг өргөтгөх, олон намын тогтолцоо (УИХ-д бүлэгтэй намуудын тогтолцоо)-г төлөвшүүлэхэд нийцүүлэн улс төрийн нам байгуулж, ажиллуулахад тавих шаардлагыг шинэчлэн тогтоох үүднээс Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Хуульд нам үүсгэн байгуулагдаж Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэнээсээ хойш 18 сарын дараа сонгуульд оролцож болохоор заасан нь зохион байгуулалт, санхүүгийн хувьд бэхжиж төлөвшсөн нам сонгуульд

оролцох боломжийг нээн өгч байгаа хэрэг юм. Түүнчлэн сонгогчийн санал, гишүүний суудлыг мөнгөн илэрхийллээр тооцох болсон нь сонгогчийн саналыг худалдан авах, шударга бусаар өрсөлдөх явдлаас сэргийлэх чухал алхам болж байна.

Монгол Улс 2005 онд авилгалын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэн орж, өөрийн орны хууль тогтоомжийг конвенцийн үзэл санаанд нийцүүлэх, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор авилгалын гэмт хэргийн ойлголт, хөрөнгө орлогын мэдүүлгээ санаатай худал мэдүүлэх зэрэг шинэ зүйлийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах, Авилгын эсрэг хуулийг батлах улмаар Авилгатай тэмцэх газрыг шинээр байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн албан хаагч авилгад автах үйлдэлд өртөхгүй байх үүднээс дээрх хуульд төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг нийтэд нээлттэй байлгах, төрийн өндөр албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэх зэрэг зарчмын чухал заалтыг тусгасан.

Улс оронд шинээр үүсч буй нөхцөл байдлыг харгалзан зарим төрлийн олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох шаардлага урган гарч байна.

Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан “Газрын минаны эсрэг Оттавагийн Конвенц”-д нэгдэн орох асуудлыг Хорооноос судалж байна.

Дэлхий нийтийн даяарчлалтай холбоотой гарч байгаа зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүний дотор охид эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалахаас сэргийлэх зорилгоор НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай тэмцэх тухай” Палермогийн конвенц болон түүний нэмэлт протоколуудад нэгдэн орох асуудал ирэх оны 3 дугаар улиралд шийдвэрлэгдэх болно.

Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс “Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай” Конвенцид нэгдэн орох асуудлыг мөн шийдвэрлэхээр судалж байна.

Хүүхдийн эрхийн болон насанд хүрээгүй хүмүүсийн талаархи НҮБ-ийн баримт бичгүүдийг үндэслэн насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэргийн дараа болон эрүүгийн хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсоны дараа шинээр үйлдсэн гэмт хэргийг рецидив гэмт хэрэгт тооцохгүй байх, насанд хүрээгүй этгээдэд хуульд зааснаас хөнгөх ял оногдуулах зохицуулалтыг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндсэн

хугацааг нэг сар, онц хүнд гэмт хэрэгт 8 сараас хэтрэхгүй байхаар ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус тусган УИХ-д өргөн бариад байна.

Энэ ажлын хүрээнд “Хүүхдийн гэмт хэрэг: тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт удирдах албан тушаалтны зөвлөгөөнийг энэ оны 6 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж, хүүхдийн гэмт хэргийн асуудлыг хариуцах загвар хороодыг Нийслэлийн Баянгол, Багануур дүүрэг, Хэнтий аймагт тус тус байгууллаа. Ганц худаг дахь насанд хүрэгчдийн цагдан хорих байрны таагүй нөлөөллөөс хүүхдийг хамгаалах зорилгоор хүүхдийг цагдан хорих байрыг шинээр барьж энэ оны 3 дугаар сараас эхлэн цагдан хоригдож буй насанд хүрээгүйчүүдийг тэнд байрлуулж байна.

Мөн хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн ялын бодлогод дүн шинжилгээ хийх, хуулийн байгууллагын ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор насанд хүрээгүй этгээдэд холбогдох эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг гаргалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж мэдээлэл авах хүсэлт тавих, түүнийг байгууллага, албан тушаалтнаас хянан үзэж хариу өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулан Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

УИХ-ын энэ намрын чуулганы нээлтэнд Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ: “Төр дэх намчирхлаас ангижрахын тулд төрийн жинхэнэ албыг намын гишүүнчлэлгүй болгож, тэнд ажиллуулах хүмүүсийг төрийн албаны зарчимч шалгуураар сонгож ажиллуулдаг журмыг хэвшүүлэх ёстой” гэж тэмдэглэсэн билээ.

Иймээс ч Төрийн жинхэнэ албан тушаалтныг намын харьяалалгүй болгож, тэднийг улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзүүлэх, сонгуулийн сурталчилгаанд оролцохыг хориглох, төрийн жинхэнэ албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, төрийн албаны зөвлөлийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төрийн албаны зөв шударга тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Төрийн албаны тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад байна.

Сүүлийн үед хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой үүсээд байгаа нэн төвөгтэй байдлыг зохицуулах зорилгоор тусгайлсан ажлын хэсэг байгуулсны дүнд эдгээр хоршоодтой холбоотой хэргийг шалгах ажил эрчимжиж хохирогчдын бухимдал тодорхой хэмжээгээр буурч байна. Санхүүгийн зохицуулах хороог шинээр байгуулж цаашид банк бус

санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг зөв гольдрилд оруулах боломжийг бүрдүүлж чадсан.

Татварын дээд хэмжээг бууруулах, татвар төлөгч нэгжид ноогдох хэмжээг бууруулах үүднээс Татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлтүүдийг орууллаа.

Иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг ханган бүрэлдүүлэх чиг үүрэг бүхий Орон сууцны корпорацийг байгуулаад байна.

Хүний эрхийг хангах хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулалтын зарим асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байсны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хорооны ажлын албыг, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар хороодыг байгуулж ажлыг нь эхлүүлээд байна.

Үндэсний хөтөлбөрийн хорооноос 2006-2008 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж төрийн болон төрийн бүс байгууллагуудын гаргасан саналуудыг тусган төлөвлөгөөний төслийг энэ сарын 13-ны өдөр хуралдсан хорооны анхдугаар хуралдаанаар хэлэлцэн сайшааж, Засгийн газарт өргөн мэдүүлэхээр тогтлоо.

Түүнчилэн тус хуралдаанаар аймаг, нийслэлд хэрэгжсэн хүний эрхийг хангах арга хэмжээний дундаж хугацааны төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж дүгнэн цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг салбар хороодод үүрэг болголоо.

Орон нутгийн хүний эрхийг хангах салбар хороодын үйл ажиллагаа нь нилээд өргөн цар хүрээг хамрах тул эдгээр хороодын нарийн бичгийн дарга нарыг орон тоогоор ажиллуулах шаардлагатай байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт тусгай хэрэгцээ, онцлог эрх ашиг бүхий бүлгийн эрхийг хангах талаар тодорхой зорилтууд тусгагдсан билээ.

Холбогдох байгууллагуудын судалгаагаар дэлхий дээр 600 сая гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагийн 70 орчим хувь нь хөгжиж буй орнуудад амьдарч байна гэж үздэг юм байна.

Манай улсын нийт хүн амын 2,7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Энэ нь бага биш тоо бөгөөд эдгээр хүмүүс тав тухтай амьдарч чадахгүй байгаа нь нууц биш юм. Өнөөдөр манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрт төвөггүйгээр хэвийн зорчих, хөдөлмөрлөх наад захын боломж бололцоо алга байна.

Сул хараатай болон хараагүй хүнд зориулсан ном, сурах бичих, зам хөндлөн гарах гарц зэрэг наад захын зүйлс үгүйлэгдсээр байна.

Хэл ярианы өөрчлөлттэй, хэлгүй, сул сонсголтой, сонсголгүй хүнд зориулсан дохионы орчуулагч хангалтгүй хэвээр байна.

Оюуны хомсдолтой, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг зөвхөн мэргэжлийн болон ойр дотны хүмүүсээс нь өөр анхаарч байгаа байгууллага, хүн бараг үгүй гэж хэлж болохоор байна.

Бие эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн асуудал ч мөн хүнд байна. Дотор эрхтний эмгэгтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж авч үзэх үзлийг ч бид бүрэн ойлгож хүлээн авч чадахгүй байна.

Ердийн хүнд бэрхшээлтэй санагдаж болох зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд жинхэнэ эмгэнэл, зовлон болж буйг бид ойлгох цаг нэгэнт болжээ.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2005 оны 12 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найрууллагыг баталсан ба цаашид Монгол Улсын нэгдэн орсон Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенцийн 168 дугаар зөвлөмжийн дагуу тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Тухайлбал, тус хорооноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дохионы хэл болон брайль бичгээр хичээл заах нарийн мэргэжлийн багш бэлтгэх ангийг нээж ажиллуулах асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай тоноглол, хэрэгслийг зарим гудамж талбай, нийтийн үйлчилгээний газар, ажлын байр, орон сууцанд байрлуулах зэрэг арга хэмжээг авах болно.

Дээрхи арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор Монгол Улсын төрийн тэргүүний санаачилсан Эрүүл мэндийн тухай, Хөдөлмөрийн тухай, Барилгын тухай, Автозамын тухай зэрэг 11 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ихээхэн ач холбогдолтой юм.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооноос эдийн засаг, нийгэм, соёл, эрүүл мэнд, экологийн болон бусад салбарын бүх түвшний үндсэн чиглэл, төсөв, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тодорхой бүлэг, заалт оруулах асуудлыг үргэлжлүүлэн судалж зохих арга хэмжээг авна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлах, гадуурхах нийгмийн гаж сэтгэл зүй, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн ухуулга, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт хугацааны туршид хорооноос явуулах болно.



Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь төрийн болон төрийн бус байгууллагууд, нутгийн удирдлага, хувийн хэвшлийн хамтарсан бүтээлч, санаачлагатай, идэвхитэй үйл ажиллагаанаас шууд хамаарна. Ингэж чадвал бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ сурч, ажиллаж, амьдрах нэн таатай орчинг бүрдүүлж, нийгмийн сэтгэл зүйд мэдэгдэм өөрчлөлт гаргаж чадна.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлст үнэтэй хувь нэмэр оруулж байгаа хувь хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудад талархал илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ЦААШДЫН ЗОРИЛТ**

*Л.Одончимэд,  
Улсын Их Хурлын гишүүн,  
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд*

Эрхэм хүндэт чуулганы төлөөлөгчид өө,  
Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тохиолдуулан энд хуран цугларсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөгчид болон тэднийг дэмжин ажилладаг, асран халамжилдаг сайн санаат бүх хүмүүст чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудалд өндөр ач холбогдол өгч, үндэсний хэмжээний чуулганыг санаачлан зохион байгуулж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоонд талархал илэрхийлье.

Хүн болж төрсөн хэн бүхэнд хамаатай, бүх хүнд заяасан Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд нь төр, засгаас нийгэм, эдийн засгийн тааламжтай нөхцөл, бололцоогоор хангаж байх ёстой. Манай орны хүн бүр хэвлэн нийтлэх, өөрийн үзэл бодол, дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэж байгаа боловч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд эрүүл саруул хүний нэгэн адилаар боловсрол эзэмших, хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих нөхцөл зохих түвшинд хүртэл бүрдэж чадаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдад үл тоомсорлогдох, аливаа чадвараараа эрүүл нэгнээс дутуу байгаагийнхаа улмаас нийгэмд ялгаварлан гадуурхагдах учиргүй билээ.

Монгол Улсын төр засгаас хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогодоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах шинэ хандлагыг нийгэмд төлөвшүүлж бэхжүүлэх, тэдэнд тулгарч болох аливаа гадуурхлыг арилгах, тэдэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний зарчмыг тодорхойлсон юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг юм. Нийгмийн эмзэг бүлэг гэдэг ойлголт нь орлогын хомсдол буюу

ядуурлаас нэлээд өргөн хүрээтэй, оюун санаа, сэтгэл зүй, чадавхийн хувьд ядууралд орсон, аливаа бэрхшээл, дарамт, хавчлагад хялбархан өртөж болзошгүй нийгмийн хэсэг юм. Иймээс тэдэнд нийгмийн баялгаас бусдын адил тэгш эрхтэй хүртэх бололцоог олгох, нийгмийн харилцааны аливаа хавчлага хязгаарлалтыг устгах, цаг зуурын бэрхшээлээс хамгаалах аюулгүйн сүлжээг буй болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс туслах ёстой гэж үзэж байна.

Өнөөдөр манай оронд албан ёсны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй нийт 69 мянган иргэд байгаагийн 55.2 хувийг эрэгтэйчүүд, 44.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэдний 35.5 хувь нь төрөлхийн, 64.5 хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд байгаа нь осол гэмтлээс урьдчилан сэргийлэх дадал, зан үйл, хөдөлмөр хамгаалал, зохистой эрүүл амьдралын зан үйлд хүн ардыг сургах асуудал чухал байгааг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөөц бололцоог хөгжүүлэн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тэдэнд тэгш боломж олгож шийдвэр гаргах бүх түвшинд тэдний дуу хоолой, оролцоог хангах зэргээр бүх хүнд ээлтэй нийгмийг бүрдүүлэхэд дэлхий нийт онцгой анхаарч байна.

Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих 10 жилийг 2003-аас 2012 он хүртэл зарлаж, энэ хугацаанд хэрэгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүрэн оролцоог хангасан, саад тотгоргүй, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны “Бивакогийн мянганы хөтөлбөр”-ийг батлан гаргалаа. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш боломжийг хангах, эрхийг нь хүндэтгэх, боломж чадавхийг нь нэмэгдүүлэх, тэднийг боловсруулж хөгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг Бүсийн улс орнуудын Засгийн газруудад зөвлөсөн юм. Энэ зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авч “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг саяхан шинэчлэн баталлаа.

Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд төр анхаарлаа хандуулж, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэх замаар нийгмийн амьдралд идэвхитэй оролцох оролцоог нь нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байгаагаараа 1998-2005 онд хэрэгжсэн нийгмийн хамгаалал, аж байдалд нь түлхүү анхаарсан “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-өөс давуутай болсон юм.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудаас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн төсөлд өгсөн боловч тусгагдаж чадаагүй зарим санаа, асуудлуудыг хөтөлбөрт тусгаж оруулсан гэдгийг энд тэмдэглэе. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” Үндэсний хөтөлбөрийг төрийн болоод төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, санал санаачлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааны үр дүнд бид хамтран хэрэгжүүлнэ. Улсын Их Хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар дэмжиж байгаагаас бас хэлэх нь зүйтэй гэж үзлээ.

Засгийн газраас баримталж байгаа нийгмийн хамгааллын бодлого хөтөлбөрүүд нь төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай нягт уялдаатай хэрэгжиж байж нийгмийн салбарын уналтыг зогсоох, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад бодитой үр дүнгээ өгөх юм. Төрийн бус байгууллагууд улам нэгдэн нягтрах нь илүү эрч хүчтэй байж төр засаг, гадаад, дотоодын байгууллагын дэмжлэг тусалцааг авч ажиллах боломж бүрдэх ёстой гэдгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн гишүүн Ц.Оюунбаатар тэргүүтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны ажил үйлс бэлхэнээ нотлон харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн оролцоо, санаачлагаар байгуулагдсан төрийн бус байгууллагыг бие даан хөгжих нөхцөл бололцоог хангаж өгөх, Олон улсын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тусламж дэмжлэг авах чиглэлээр холбож өгөх арга хэмжээг бид хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Манай яамны харьяа хуучнаар Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын төвийг Сэргээн засалтын Үндэсний төв болгон өөрчлөн зохион байгуулах тухай шийдвэрийг гаргаад байна. Ингэхдээ тус байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн үйл ажиллагааг нь өргөжүүлэхийн зэрэгцээ нийгэм рүү чиглэсэн байдлаар үйл ажиллагааны стратеги, бүтэц, чиг үүргийг шинэчлэн зохион байгууллаа. 2007-2008 онд багтаан тус төвийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон дэд бүтэц, орц гарц, бүхий тоног төхөөрөмжтэй Үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тусгай төв болгон хөгжүүлэхээр Нийгмийн хамгааллын хөгжлийн хөтөлбөр төсөлтэй хамтран ажиллаж байна.

Нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ойлгож, хүндэтгэдэг, тусалж дэмждэг сэтгэхүй, дадал зуршлыг бий болгох шаардлагатай байна. Үүнд соёл урлаг, спортын цогц хөтөлбөрүүд болон хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой байдаг тул энэ төрлийн арга хэмжээг

түлхүү зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өргөнөөр хамруулж байх болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд анхаарал халамж тавих үүргийг ихэвчлэн гэр бүл, үр хүүхдүүд нь хүлээдэг байсан бол зах зээлийн харилцааны өнөө үед төр, иргэний нийгмийн байгууллагууд хамтран хүлээх боллоо. Тэдэнд зориулсан үйлчилгээний байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, ялангуяа эрүүл мэнд, асрамж, халамжийн үйлчилгээ зэрэг байнгын ажиллагаатай үйлчилгээний газруудыг бий болгоход нийгмийн бодлого чиглэгдэж байна. Үүний эхлэл болгож нийгэм, хамт олонд тулгуурласан хэлбэрээр хүргэх асран халамжлах үйлчилгээг Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зэрэг шинэлэг хэлбэрийн ажлуудыг ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөд байна.

Манай оронд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхол нэмэгдэж, бэлэнчлэх сэтгэлгээ давамгайлсанаас иргэд өөрсдийн нөөц бололцоогоо дайчлах сонирхол буурах, түүнчлэн хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл мүү байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилгүйдэл, ядууралд өртөх эрсдэл өндөр байгааг бид өөрчлөх, энэ чиглэлд шаардлагатай шинэчлэлийг хийх замаар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд албан байгууллагын нийт ажиллагсдын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд байх зохицуулалтыг хийхээс гадна тэдний онцлогт тохирсон хөдөлмөр эрхэлж, орлого олох боломжтой ажлын байр бий болгоход анхаарлаа хандуулж байна. Тухайлбал, харааны бэрхшээлтэй иргэдэд массажистын хөдөлмөр эрхлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэхэд тохиромжтой үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж эхлээд байгаа бөгөөд цаашид энэ талаар түлхүү анхаарч ажиллах болно.

Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн байгуулсан иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхижиж, төр засгаас бэлнээр тусламж гуйхаа больж, “хийе бүтээе”, “хамтран ажиллая” гэсэн бүтээлч санал санаачлага гаргадаг болж байгаа нь томоохон дэвшил мөн. Энэ талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань зарим тохиолдолд эрүүл чийрэг иргэдээс ч илүү идэвх санаачлага гаргаж байгаа нь бидний хамтран ажиллах урам зоригийг сэргээж, үр дүнд хүрэх итгэлийг төрүүлж байгаа юм.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сайн сайхны төлөө ямагт анхаарч энэ үйлсэд хүч хөдөлмөр, нинжин сэтгэлээ зориулж байгаа иргэний нийгмийн байгууллагын санал

санаачлагыг дэмжиж нягт хамтран ажиллах болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалсан хууль эрх зүйн акт баримт, тэдний эрх ашгийг хамгаалсан байгууллагын тоо цөөдөөгүй гэж хэлж болох ч үнэн чанартаа тэдний эрх байнга зөрчигддөг үнэнийг бид өнөөдөр нүүр тулан ярилцаж шийдвэрлэх ёстой. Мөн бусдаас хамаагүй илүү амьдралын хэрэгцээтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэдхэн төгрөгийн тэтгэмж олгосноор бүхнийг шийдсэн мэт ойлгодог хуучинсаг үзлийг арилгах ёстой гэж үзэж байна.

Үүний тулд юуны өмнө Нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчид, манай үйлчилгээний ажилтнууд, нийгмийн талаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний төлөө санаа тавигч төрийн бус байгууллагууд, сайн санаат хүмүүстэй хамтран энэ чухал үйлсийн хошуучлагчид байх үүргээ умартах учиргүйг зориуд тэмдэглэж байна. Энд аль дорой буурайдаа илүү анхаарал халамж тавьдаг Монголчуудын уламжлалт сэтгэлгээ бидний үйл ажиллагааны нэг үндэс суурь байх ёстойг ч санах учиртай. Хүнд сурталтан, цэвдэг сэтгэлтэн, биеийн амарыг харагчид, хүний зовлон зүдгүүрээр хувийн ашиг хонжоо хайгчид нийгмийн хамгааллын салбарт, тэр тусмаа онцгой халамж, анхаарал шаарддаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллагсадын дотор байх ёсгүй гэдгийг бид хатуу санаж ажиллах ёстой.

Төр засаг нийгэм хамт олны дэмжлэг хүмүүнлэг энэрэнгүй үйлст нийгмийн тус дэмийг авч хэнээс ч дутахгүй аж төрөн амьдарна гэсэн ирээдүйдээ итгэл төгс байхыг та бүхнээс хүсье.

Чуулганы үйл ажиллагааны үр дүнд бидний хамтын ажиллагаа цаашид илүү идэвхитэй, нээлттэй, эрчтэй болж өргөжнө гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДАЛ, УЧИРЧ БУЙ БЭРХШЭЭЛ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ**

**Ц.Оюунбаатар,  
МХБИБҮХ-ны Ерөнхийлөгч**

Эрхэм хүндэт Монгол улсын Ерөнхийлөгчөө,  
Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид өө,

Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаар дүн шинжилгээ хийж, дүгнэн ярилцах бололцоо олгож байгаа Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр танд болон чуулганыг санаачлагч, чуулганыг зохион байгуулагч, Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс, НҮБ-ийн Монгол дахь суурин төлөөлөгч, МХБИБҮХолбоо, Италийн засгийн газрын бус “АЙФО” байгууллагын хамт олонд хувиасаа болон нийт төлөөлөгч, гишүүдийнхээ нэрийн өмнөөс баярласнаа илэрхийлэе.

Энэ чуулганы үр дүнд Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаа чанарын шинэ шатанд хүрч, Монголын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хангагдаж, амьдрал нь сайжрах эхлэл тавигдана гэж гүнээ найдаж байна.

Монгол Улс 1990 оноос хойш ардчилал зах зээлийн харилцаанд шилжиж 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталсан орон. Монгол улсын Үндсэн хуулинд “Хүний эрх, эрх чөлөө, шудрага ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” гэж заасан байдаг билээ.

Энэ хорвоод эхээс мэндлээд хүн гэдэг нэрийг зүүж яваа хэн ч байсан эдлэх ёстой эрхүүдийг Монгол Улс, НҮБ-ын гишүүн орныхоо хувьд, олон улсын гэрээний заалтуудыг хүлээн зөвшөөрсний хувьд үндсэн хуулиндаа нэлээд сайн тусгасан гэж үздэг. Төрт ёсоо дээдэлдэг аль ч улсад Үндсэн хууль гэдэг ард түмний дээдлэх ёстой зөрчиж болшгүй баримт бичиг. Хэрэв үндсэн хуулийнхаа үзэл санааг хэрэгжүүлбэл Монголд иргэн төвтэй тогтолцоо байх ёстой, иргэн бүрийн эрх, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хэрэгжиж байх учиртай билээ.

Гэтэл өнөөдөр Монголд иргэн төвтэй биш, нам төвтэй, төр төвтэй тогтолцоо хөгжиж ирсэн учраас намын томилгоогоор ажил, үүрэг гүйцэтгэж

байгаа албан тушаалтнуудын буруу үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын өлбөгөр байдлаас шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөх асуудал байнга тавигдсаар байна. Хэрэв бид иргэнд үйлчилдэг, иргэдийн санаа бодлыг сонсож, ажилдаа тусгадаг тогтолцоог бий болговол гарч байгаа хууль нь ч, төрийн бодлого нь ч хэрэгжих бололцоотой болж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөх асуудал гарахгүй байхсан.

### **1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэгч хэн бэ?**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулинд тодорхойлсноор: “Төрөлхийн болон удамшлын эмгэг, өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно” гэжээ. Тэгэхээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэг нь чадавхи нь алдагдсан боломж нь хязгаарлагдсан болохоос биш эрх нь хязгаарлагдаагүй Монгол улсын иргэн учраас Монгол улсын үндсэн хуулинд заагдсан эрхийг эдлэх ёстой. Энэ эрхүүдийг эдэлж чадаж байна уу үгүй юу гэдэгт дүгнэлт хийхийн тулд үндсэн хуулийн заалтуудтай харьцуулан үзье гэж бодож байна.

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 16-Р ЗҮЙЛИЙН:**

### **2-д Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй.**

Гэмт хэргийн ертөнц, замбараагүй барилгажилт, орчны бохирдол, хүнсний хомсдол, гадна талбайн зүй бус тохижилт гэх мэт зүйлээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орчны зүгээс байнга аюул нүүрлэж байдаг.

#### **Жишээ 1**

Хараагүй хүнд зориулсан зам байхгүй, байсан ч тэр нь траншейны нүх дамжуулж хийх юмуу эсвэл шон дайруулж хийсэн байдаг. Осолдох тохиолдлууд байна.

#### **Жишээ 2**

Тэргэнцэртэй хүнд зориулсан орц гарц налуу зам байхгүйгээс шатаар гаргахдаа түүнийг өргөх болдог, хэрэв гар алдуурч унавал яах вэ?

#### **Жишээ 3**

Хотын гудамж талбайг гялгар хавтангаар чимэглэн хийдэг учир таягтай хүмүүс халтирч унах аюул байнга байдаг.



### **3-д Хөдлөх үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрхтэй.**

Авилгал хээл хахууль, танил талаар асуудлыг шийддэг болсон энэ цаг үед нийгэмтэйгээ олигтой харьцаж чаддаггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөрөнгө олох үл хөдлөх хөрөнгөтэй болох асуудал ярихын ч хэрэг алга.

### **4-д Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.**

Монголд 115000 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг гэсэн тоо бий. Эдгээрээс хөдөлмөр эрхлэж буй 2000 орчим хүн байдаг. Өнөөдөр Монголд Хөгжлийн бэрхшээлтэй хүний аятай нөхцлийг хангасан ажлын байр нэг ч алга. Ажилдаа очих боломж ч байхгүй, цалин хөлс нь ялгавартай олгогддог асуудал ч байна. Ялангуяа оюуны хомсдолтой, сэтгэцийн эмгэгтэй иргэдийн хувьд илүү их ажиглагдаж байна. Учир нь цалингийн ялгаваргүй байх хууль батлагдаагүй шүү дээ.

Хөдөлмөрийн Хуулийн 111-р заалтын дагуу квот тогтоосон боловч энэ заалт хэрэгждэггүй, Засгийн газрын тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөрөнгө төвлөрөх ёстой ч бүрэн төвлөрдөггүй төвлөрсөн хөрөнгө нь төрийн бодлого байхгүй, Төрийн бус байгууллага, иргэний хяналт сул байгаагаас учир утгагүй сургалтанд зарцуулагдахаас цаашгүй. Сургалтанд хамруулсаны дараа ажлын байртай болгох ажил хийгддэггүй. үүнтэй холбогдуулан хөдөлмөрлөх эрх нь байнга зөрчигдөж байдаг билээ.

### **5-д өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах ... болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй.**

Энэ заалт халамжийн болон нийгмийн даатгалын хуулиар дамжин хэрэгждэг билээ. Өнөөдөр Монгол улсад 42000 орчим хүн халамжийн сангаас, 46000 орчим хүн Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч, олон хүн янз бүрийн хөнгөлөлт авах ёстой боловч үзүүлж байгаа тусламж нь чанаргүй оновчтой биш байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээ нийгмийн хамгааллын үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтоох, энэ талаар иргэн хуулийн этгээдийн хүлээх үүргийг тодорхойлох, харилцааг зохицуулах ёстой суурь хоёр хууль батлагдан гараад 2006 оны 07 сарын 01-нээс хэрэгжих явцаад олон олон зөрчил дагуулсныг хэлэхэд харамсалтай байна. Тухайлбал:

Халамжийн хуулийн 18, 1, 4-т энэ хуулийн 18, 1, 3-т зааснаас бусад хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжинд заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй бол халамжийн тэтгэвэр авах эрхтэй гэж заасан нь Эрүүл мэндийн сайдын

250А тушаалтай хавсран олон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрийг хасах эх үндэс боллоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3-т Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно гэж заасан хэрнээ халамжийн хуулинд заагдсан нөгөө л 70 ба түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвар алдсан иргэн тэтгэвэр авах, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдах эрх үүсэхээр заасан учраас хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой, шилбэ, шууны тайралттай, түнхний мултралттай, өрөөсөн нүдгүй, сул хараатай, сул сонсголтой, ортопед гутал хэрэглэдэг ерөнхийдөө сонгодог хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд группээс хасагдаж, ямар ч хөнгөлөлт эдлэх боломжгүй болж байна. Тэдэнд цаашид амьдралаа авч явахад нь зориулж сар бүр 20,000 төгрөгийг бүтэн жилээр тооцож, 240,000 төгрөг өгөөд л боллоо.

Гэтэл хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой зэрэг олон улсын ангиллаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэтгэвэр авах эрх үүсэхгүй ч гэсэн бусад хөнгөлөлт байх ёстой шүү дээ. Мөн эдгээр иргэдийг ажлын байртай болгох төрийн бодлого хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжин хэрэгжих ёстой гэж үзэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт энэ хууль тэгш үйлчлэх ёстой атал хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ хөрөнгөөр нь ялгаварлаж, зөвхөн нэн ядуу амьдралтай бол хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдах боломжтой гэж хуульд оржээ. Гэтэл өнөөдөр Монголын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 88 хувь нь ядуу байгаа шүү дээ.

#### Жишээ 1

Говь-Алтай аймагт 460 хүн группээс хасагджээ. Эдгээрийн дотор шуу шилбэний тайралттай, өрөөсөн нүдгүй, хөнгөн хэлбэрийн оюуны хомсдолтой, сул сонсголтой зэрэг сонгодог хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Халамжийн хууль нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчиж байна.

#### **6-д Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.**

Өнөөдөр Монголд чанартай болгон үнэтэй болсон цаг. Нөгөө талаар Монгол улсын аль ч эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих бололцоо алга. Өөрөөр хэлбэл иргэн бүрт хүрч үйлчлэх тогтолцоо байхгүй учир энэ заалт алдаг оног хэрэгждэг. ХБХүүхдийн эм тариа, оношилгоо, эмчилгээ, амин дэмийн үнэ өртгийг хөнгөвчлөх тал дээр ЭМЯ болон бусад холбогдох байгууллагууд анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай байна. Тархи гуурсны хангамж, олдоц муутайгаас эмч эмнэлэгийн байгууллагууд, аптекийн дундах бизнес болсон. Өрхийн орлогынхоо дийлэнхи хувийг

ХБХүүхдийнхээ эмчилгээнд зориулдаг ч тэр нь хүрэлцээгүйгээс нөхөн сэргээлт бүрэн хийгддэггүй, хоол тэжээл, амин дэмийн хүрэлцээ муугаас хавсарсан эмгэг үүсэх, өвчлөмтий болоход ч нөлөөлдөг. Мөн олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ихэнх хувь нь эмнэлэгийн ажилтнуудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэлтэй байдаг. Тухайлбал:

Эх баригч, эмч нарын төрөлтийн явцыг буруу удирдсанаас тархины саажилт өвчин их үүсдэг. Мөн оношлогоо эмчилгээний буруугаас олон хүүхэд давхар согог үүсэх шалтгаан болж байна. Иймээс эмч эмнэлэгийн ажилтнуудын хариуцлагын тогтолцоог улам сайжруулах, эмнэлэгийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд нөхөн төлбөр гаргуулах, хүн эмчлэх эрхийг хаах зэрэг тодорхой арга хэмжээг авах механизмыг бий болгох шаардлагатай байна.

Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхэдтэй, хүүхдээ асарсанаас ажил хийх боломжгүй асран хамгаалагчид сард 18450 төгрөг олгодог. Мөн энэхүү заалт нь дунд зэргийн болон хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхэдд хамаардаггүйгээс олон хүүхэд тэтгэмжинд хамрагдаж чаддаггүй байсан.

Гэтэл энэ оны шинэчлэсэн хуулиар байнгын асаргааны мөнгөнөөс ихэнх хүүхдүүд халамжийн байцаагч хороо хорины зөвлөлийн хурлаар ороод хасагддаг. Энэ нь эмч нарын зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг онош мэдэхгүй мэргэжлийн бус хүмүүс хэрэгжүүлэх мөн нэн ядуу гэдэг заалтаар жинхэнэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг асран хамгаалагч нар нь авч чадахгүй байна. Гэтэл эдгээр хүүхдүүдэд ядуу болон дунд түвшиний амьдралтай өрх гэлгүйгээр хэрэгцээ шаардлага жирийн хүүхдийнхээс илүүтэй байдаг.

## **7-д Сурч боловсрох эрхтэй.**

Төрөөс бүх нийтийн боловсролыг төлбөргүй олгоно. Үнэхээр чухал заалт, чухал эрх. Хүн боловсролтой байж гэмээн нийгэмд байр эзлэх, ажил мэргэжилтэй болох бүх суурь үндэс нь бий болдог. Гэтэл Монголд 40 орчим мянган хүүхдүүдийн 61,2% нь сургуулийн гадна 31% нь алдаг оног энгийн сургуульд хамрагдсан болж, 2000 орчим хүүхэд тусгай сургууль, Мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв гэх мэтэд хамрагддаг. Байдал ийм тааруу байгаа нь ирээдүйд 40-өөд мянган ажилгүй, боловсролгүй, халамжийн хүмүүсийг бэлтгэж байна гэсэн үг.

ХБХүүхдийг ердийн сургуульд хамруулна гэж үзэж байгаа боловч сургуулийн дэд бүтцийн асуудал, хамт олны сэтгэл зүйн орчин, багш мэргэжилтний ур чадвар, ном гарын авлага, сургалтын хөтөлбөр, хүүхэд, багш, сургуулийн үнэлгээ зэрэг олон асуудлууд гарч байна. Эдгээр

асуудлыг хуулинд тусгаагүй, бусад хүмүүсийн ойлголт хандлага муу байгаа зэргээс шалтгаалан ерөнхий боловсролын сургуулиуд ХБХ-ийг авч сургахаас эрс татгалзах тохиолдол байнга гарч олон ХБХүүхдүүд сургуульд суралцаж чадахгүй байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд ажил хийж амьдрал ахуйгаа дээшлүүлэх боломж маш хязгаарлагдаж байна. Тархины саажилттай хүүхдүүдийг өдрөөр хүлээж авдаг ганцхан төв байдаг. Энэ нь 10-р Сувилалын цэцэрлэг ясли. Тэнд өнөөдөр олон хүүхэд хүлээн авах хүчин чадал алга. Тэдгээр хүмүүс зөвхөн хүүхдээ харахаас өөрөөр нийгмийн амьдралд оролцох бололцоо байхгүйгээс өнөөдөр зарим нь хүүхдээ адлах, тэдгээр хүүхдийн ээж нь эсвэл хүүхэд өөрөө гэр бүлийн хүчирхийлэлд өртөх нийгэмд хэрэггүй болсон мэтээр үзэгдэх хандлага байсаар байна. Яагаад байдал ийм байна вэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулах тэдэнд хэрэгцээтэй боловсролыг нь олгох төрийн цэгцтэй бодлого байхгүй байгаатай холбоотой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын бодлогыг тодорхойлох үүрэг бүхий бүтцийг БСШУЯамны дэргэд байгуулах шаардлагатай болжээ.

### **8-д Соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, үр шимийг хүртэх эрхтэй.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд иргэдийн авьяасыг хөгжүүлэх, соёл урлагийн ажлыг дэмжих төрийн бодлого алга. Ийм хүүхдүүдийн авьяасыг дэмжих курс, дугуйлан, соёл урлагийн үйл ажиллагааг төрийн бус байгууллагаас явуулж байгааг эс тооцвол юу ч алга.

#### **Жишээ 1**

Өнөөдөр эрүүл тамирчин олимпийн аварга болбол 120 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн параолимпын аварга болбол 12 сая төгрөг гэх мэт ялгаварлал байна. Адилхан хүч гаргаж, адилхан төрийн далбааг мандуулж байгаа шүү дээ. Гэтэл Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын бэлтгэл сургуулилт хийдэг заал танхим, техник хэрэгсэл байхгүй байна. Харин Монгол улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан хуулийн төсөл батлагдвал нэлээд ахиц гарах бололцоо бүрдэнэ.

### **9-д Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй**

Энэ эрхээ хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь сонгуулийн тухай хуулийн хэрэгжилт нөгөө талаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрд нөлөө үзүүлэх, төрийн хэрэгт оролцох эрхээ төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх учиртай. Өнөөдөр Монголд 7000 орчим харааны бэрхшээлтэй,

160 гаруй одой хүн, 6800 орчим тэргэнцэртэй иргэд, 7500 орчим сонсголын бэрхшээлтэй иргэд байна. Эдгээр иргэд сонгуульд яаж оролцох, яаж саналаа өгөх журам байхгүй сонгуулийн хуульд ч тусгагдсан зүйл алга байна.

#### Жишээ 1

Хараагүй хүн санал өгөх тохиолдолд саналын хуудсан дээр брайл тэмдэглэгээ байх ёстой. Одоо ийм зүйл байхгүй.

#### Жишээ2

Сонгуулийн үеэр нэр дэвшигч ярилцлага өгч байхад дохионы тайлбар явах ёстой. Тэгж гэмээ нь дүлий иргэдэд зөв сонголт хийх бололцоо олдоно. Одоогоор аль ч телевиз тийм зүйл байхгүй байна. Ер нь Хөгжлийн бэрхшээлтэй 115 000 хүнийг томсгосон 3 тойрог болгож санал авах замаар тэдний төлөөллийг Улсын Их Хуралд бий болгох цаг болжээ.

### **10-д Эвлэлдэн нэгдэх эрхтэй**

Эвлэлдэн нэгдсэн байгууллага нь та бид. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд сайн дурын үндсэн дээр ажилладаг хэдий ч их зүйл хийж байна. Хийх эрмэлзэл байна. Төр бодлогоор дэмжиж тэднийг тодорхой төсөвтэй болгож, тэдний хүчийг ашиглах хэрэгтэй.

### **11-д Улс төр нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй эмэгтэй тэгш эрхтэй.**

Өнөөдөр Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийг дэмжих, бодлого байхгүйгээс салалт их, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй гэр бүл болох асуудал өөрөө төвөгтэй асуудал юм. Үүнийг төр дэмжих ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бага наснаас нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн хичээл зааж амьдралд бэлтгэх шаардлагатай байна. Гэр бүлгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд физиологийн тэнцвэрт байдал алдагдаж, түүнээс үүссэн сэтгэл зүй болон сэтгэцийн хямрал их бага хэмжээгээр илэрч, хүчирхийлэлд өртөгч хамгийн эмзэг хэсэг болж байна.

### **12-д Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль зүйн мэдлэг дорой тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын чадавхи сул зэргээс шалтгаалан өөрийгөө илэрхийлэх, гомдол гаргах асуудлыг шийдвэрлүүлэх явдал туйлын хангалтгүй байна. Нөгөө талаар манай асуудал хариуцсан дарга нар 2-оос дээш давхарт ажлаа явуулдаг, тэдний албан газрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарц, байхгүйгээс холбогдох газар

орж гомдол хүсэлтээ гаргах бололцоог нь хааж байна. өөрөөр хэлбэл эрхийг нь зөрчиж байна.

**13-д** Шүүх тогтолцоо нь авилгал хээл хахууль хүнд сурталд автагдсан болохоор угаас мөнгөгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд залилан хүчирхийлэлийн хэргийн гол золиос болж хохирсоор үлдэж байна.

### **15-д Мэдээлэл олж авах, хайх эрх байнга зөрчигддөг.**

Жишээ 1.

Брайл бичгээр хэвлэгдсэн ном сэтгүүл алга  
Гол гол мэдээллийг дохиогоор орчуулдаг телевиз алга  
Номын сан, дэлгүүрт орох бололцоо алга  
Байдал өнөөдөр ийм л байна.

### **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлт үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт хүргэх асуудалд чанарын ахиц гаргахын тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудын дуу хоолой, тэдний бодит ажиллагаа туйлын чухал. МХБИБҮХолбооны үйл ажиллагааг сүүлийн жилүүдэд эрчимжүүлж 4 үндсэн чиглэлээр үйл ажиллагааг явуулж байна.

1. Төрийн бодлогыг олон нийтэд зөв сурталчлах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөв сурталчлан таниулах чиглэлээр 7 аймаг 9 дүүргийн иргэдтэй уулзаж, шинээр хэрэгжиж буй хуулийн асуудлаар санал бодлоо солилцлоо. “Хүмүүн заяа”, “Урсгал” сонин гаргаж, телевиз, радиогоор ярилцлага өглөө.
2. Төрөөс үзүүлж буй хөнгөлөлт үйлчилгээ хүндээ хүрч буй эсэхэд хяналт тавих, Нэгэнт төрөөс үзүүлж буй хөнгөлөлт үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт чанартай оновчтой хүргэх нь тэдний эрхийг хамгаалах тэдэнд туслах үйл ажиллагаа учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудын хувьд хөндлөнгийн хяналт хийж зөвлөмж боловсруулж байх нь чухал зүйл. Нөгөө талаас төрийн үйл ажиллагааг шудрага ил тод байлгахад ач холбогдолтой. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлж буй хөнгөлөлт үйлчилгээнд хөндлөнгийн хяналт хийлээ. Байдал туйлын хангалтгүй байна. Зөвхөн нэг жишээ дурьдахад, улсын төсвөөс протез, ортопедын хэрэгсэлд зориулж жилд 1 тэрбум төгрөг гаргадаг хэдий ч 12 сая орчим төгрөг нь протез, ортопед хийхэд үлдсэн 980-аад сая төгрөг нь тэргэнцэр, таяг, сонсголын аппарат, хиймэл шүд, хийхэд зарцуулагдаж байна. Учир нь ашиг унадаг учраас, сайдын тушаалаар нэг хүнд 150000 төгрөгийн тэргэнцэр

олгох ёстой, бодит байдал дээр 52000 төгрөгийн үнэтэй тэргэнцэр өгч байна. Зөрүү мөнгө нь хаачив аа. Бид хөндлөнгийн хяналтаар л гаргаж чадна. Өч төчнөөн ийм жишээ дурьдаж болно. Энэ нь бидний хариуцлага өндөр байх ёстойг сануулж байна.

3. Төрөөс гарах шийдвэрт нөлөөлөх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын хуулийн төсөл өргөн барьсан боловч УИХураар хэлэлцэгдээгүй учир Монгол Улсын Ерөнхийлөгч салбарын хуулиудад оруулахаар хуулийн төсөл өргөн бариад байна. Мөн аймгийн Засаг даргын захирамж, НХХЯам, ХХҮГазраас болон бусад яам, газруудаас гаргаж буй журамд саналаа өгч байна.
4. ТББ-ыг боловсон хүчний болон материаллаг баазын хувьд бэхжүүлэх зэрэг болно. Төрийн бодлогод нөлөөлөх, хүчтэй хяналт тавихын тулд төрийн бус байгууллага боловсон хүчний болон материаллаг баазын хувьд чадварлаг байх ёстой. Боловсон хүчний чадавхийг сайжруулахын тулд НҮБ-ын Нийгэм эдийн засгийн комисс, АЙФО, МХБИБҮХолбоо хамтарсан төсөл хэрэгжүүлж, Үндэсний холбооны гишүүн байгууллага, салбар зөвлөлийн удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх сургалт явуулж байна. ХХҮГазрын дэмжлэгтэй 3 үйлдвэр, интернет кафе байгуулан орлого олох, түүгээрээ байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулж байна. үүний үр дүнд үндэсний холбоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах хангалттай чадавхитай болж байна. Төрийн байгууллагууд ч тодорхой дэмжлэг үзүүлж эхэллээ. НХХЯ, ХХҮГазар, Баянгол дүүргийн засаг дарга П.Цогтбаатар болон түүний Тамгын газар, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүрэг, Хэнтий, Говь-Алтай, Баянхонгор аймгийн засаг дарга, Засаг даргын тамгын газрууд, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүд тодорхой ажлууд хийснийг тэмдэглэхэд таатай байна.

Гэвч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөх явдал түгээмэл байгаа учраас цаашид яах вэ? Юу хийх вэ?

Сүүлийн үед төр засаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд онцгой анхаарал хандуулж эхэллээ. Энэ бол сайн юмны эхлэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах ажлын эхлэл гэж ойлгож байна.

Жишээ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар салбарын 11 хуулинд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа. Энэхүү чуулганыг санаачлан хийлгэж байна. НХХЯ, ХХҮГазар үндэсний холбооны бодлого зорилгыг ойлгосны үндсэн дээр хамтын ажиллагааны гэрээ байгуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжин туслаж байна.

**ЦААШДЫН ЗОРИЛТ**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахын тулд:

**1. Хууль эрх зүйн орчин бий болгох**

Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж, хамгаалах хууль түүнийг дагалдан гарч байгаа тогтоол дүрэм журмыг хүний эрхийн стандартад нийцүүлэх боловсронгуй болгох. НҮБ-гаас гаргаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн конвенцийг Монгол улс яаралтай соёрхон батлах шаардлагатай байна. Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн хуулийн шинэ төсөл өргөн барих, олон улсын конвенцууд, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах

**2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хэрэгжүүлэх эдийн засгийн орчинг бий болгох**

- а/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ХБХүнд зориулсан хөрөнгийг зөв зохистой зарцуулах
- б/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний аж ахуй эрхлэх татварын болон зээлийн хөнгөлттэй нөхцөл бий болгох
- в/ Тэдний мэдээлэл олж авах, ажил хөдөлмөр эрхлэх боловсрол эзэмших гэх мэт эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц (орц гарц, зам, гүүр, хаалга, шат, дохио, брайл, зам гм)-ийг бий болгох
- г/ Мэргэжлийн боловсролд хамрагдах боломжийг нээлттэй болгох
- д/ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэмжих

**3. Улс төрийн орчин бүрдүүлэх**

- а/ Саналыг бүрэн авах, сонголт хийх, сонгогдох бололцоог сонгуулийн хуулийг өөрчлөх замаар бүрдүүлэх

**4. Нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх**

- а/ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа ОНРТелевизийн бодлогод таатай уур амьсгал бий болгох асуудлыг тусгуулах
- б/ Олон нийтийн хандлагыг өөрчлөх талаар төрөөс бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагтай.

**5. Дээр дурдсан 4 орчинг бүрдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах үйл ажиллагаа явуулахын тулд тодорхой эрх мэдэл бүхий ажлын албыг бий болгох ёстой. Энэ алба Ерөнхийлөгч, Монгол улсын төрийн тэргүүний ивээл дор байгуулагдвал илүү ач холбогдолтой болно.**



**6.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг албан тушаалтаныг тогтвор сууршилтай, хариуцлагатай болгох

**7.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг төрөөс тусгайлан дэмжиж иргэддээ үйлчилдэг чадварыг нь дээшлүүлэх

**8.** Төрөөс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй хөнгөлөлт үйлчилгээ, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт чанар хүртээмж, хөрөнгийн зарцуулалтанд төрийн бус байгууллагуудын оролцоотой үнэлгээ өгдөг байх шаардлагатай.

**9.** Хүүхэд суралцах хувьсах зардлыг өгөх

**10.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид урамшуулал олгох асуудал чухал байна.

**11.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих, хүрэх боломжийн дээшлүүлэх зорилгоор бүх байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох.

**12.** Бүх шатны дарга нар чуулганаас гарсан шийдвэрийг ажилдаа тусган ажиллаасай.

Анхаарал тавьсанд баярлалаа!

## “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ”-ИЙН ХЭРЭГЖИЛТ

*Илтгэгч Р.Сэлэнгэ  
Филантропи Хөгжлийн төлөө төв*

Эрхэмсэг хатагтай, ноёдоо,  
Хүндэт зочид төлөөлөгчид өө

Та бүхний амгаланг айлтгая. Хүний эрхийн өдөрт зориулсан энэхүү үндэсний чуулганы индэрээс та бүхэнтэй мэндчилж, амжилт хүсч байгаадаа баяртай байна.

Энэхүү илтгэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмийн тухай, уг стандарт дүрмийн хэрэгжилтийн байдлыг судалсан судалгааны тухай товчхон танилцуулахын хамтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны боломжит байдлын тухай судалгааны зарим үр дүнг хүргэхийг зорилоо.

### НЭГ. “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ”-ИЙН ТУХАЙ

1993 онд хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох Стандарт дүрмийг баталсан нь 200 гаруй жилийн хөгжлийн үр дүнд бүрэлдэн тогтсон хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд нь нийгмийн бусад гишүүдийн адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх бодлогыг баталгаажуулахад оршжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын стандарт дүрэм нь:

1. Тэгш оролцооны угтвар нөхцөл байдлыг бүрдүүлэх
2. Тэгш оролцооны зорилтот салбаруудын үйл ажиллагаанд тусгах
3. Тэгш оролцооны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд нийт 22 дүрмийг өөртөө багтаажээ.

### ХОЁР. СУДАЛГААНЫ ТУХАЙ

Стандарт дүрмийн хэрэгжилтийн байдлыг тодруулах ажлыг тус төвийн судлаачдын баг Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн

Байгууллагуудын Үндэсний Холбооны багийн хамтаар гүйцэтгэсэн бөгөөд төслийн хүрээнд харьцангуй богино хугацаанд асар их мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийхээр ажилласан болно. Судалгааны үр дүнг төрийн бодлого, хууль, эрх зүйн акт, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, өмнө нь хийгдсэн судалгааны тайлан болон нэмж цуглуулсан асуулгын судалгааны мэдээлэлд үндэслэн гаргасан юм. Судалгааны үр дүнд тулгуурлан бид өнөөдөр та бүхний анхаарлыг энэхүү стандарт дүрмийн хэрэгжилт ямар байна вэ гэдэгт хандуулахыг хүсч байна.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ ОРОЛЦООНЫ УГТВАР НӨХЦӨЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны угтвар нөхцлийг бүрэлдүүлэхэд юуны тэргүүнд:

- Тэднийг<sup>1</sup> хүлээн зөвшөөрөх нийгмийн хүлээн авалтыг зөвөөр бүрдүүлэх
- Нийгмийн харилцаанд тэгш оролцоход өөрсдийг нь бэлтгэх асуудал тавигдаж байгаа бөгөөд энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн эрх, тэдний хэрэгцээ, чадамж, хувь нэмрийн талаарх ойлголтыг нийгэмд хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой юм.

Монгол Улсын төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой баталсан хууль дүрэмд нийгмийн хандлага, ойлголтыг өөрчлөх, тэгш хамруулах нийгэм сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх тухай зохих хэмжээнд зааж өгсөн байна.<sup>2</sup>

Түүнчлэн холбогдох төрийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр олон нийт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлуудыг цөөнгүй зохион байгуулжээ<sup>3</sup>.

<sup>1</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

<sup>2</sup> Тухайлбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дугаарт “ажил, амьдралынх нь талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах” арга хэмжээг төрийн зохих байгууллага зохион байгуулна хэмээн зааж өгчээ. Түүнчлэн БСШУЯ, ЭМЯ, НХХЯ-ны сайд нарын хамтарсан 435/302/173 тоот тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр”-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах нийгэм-сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэх, багш, удирдах ажилтанд тусгай сургалт зохион байгуулах, сургууль, гэр бүл, олон нийтэд хандсан мэдээлэл, сургалт явуулах, мэдээлэл, сурталчилгааны хэвлэмэл болон электрон гарын авлага, аудио, видео материалууд, радио, телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулж байгаа боловсролын байгууллага, багш нарыг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх тухай тусгагдсан байна.

<sup>3</sup> 2001 оноос “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”, 2003 оноос МХБИБҮХолбооны дэргэдэх “Хүмүүн заяа” сонин зэрэг нь энэ талын мэдээллийг олон нийтэд хүргэх болжээ, МУ-ын ЗГ, АХБ-ны шугамаар Японы Ядуурлыг бууруулах сангаас санхүүжигдэн хэрэгжсэн “Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төсөл нь хэрэгжих хугацаандаа (2002-2005) 548 мэдээ, сурвалжлага, яришлага, өгүүлэл нийтэлж, телевизийн 28, радиогийн 30 нэвтрүүлэг цацаж, “Тэргэнцэртэй хүний түүх” сэдэвт цуврал радио зохиомжийг Монголын Үндэсний радиогоор явуулжээ.

Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт хандлагад үр дүнтэй нөлөөлөл үзүүлж чадахгүй байна. Судалгааны дүнгээс харцгаая.

Энд 1999 онд ЭМНХЯ-ны захиалгаар МУИС-ийн Социологийн тэнхимээс явуулсан “Тахир дутуу иргэдийн нийгмийн хэрэгцээ”, 2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүнгээс танилцуулья. Зураг №1

**Тайлбар:** 1999 онд хэрэгжүүлсэн судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 71,4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсээс ялгаатай “өөр хүмүүс” гэж үзэж байжээ.

2005 онд хийгдсэн судалгааны дүнгээс харахад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн дунд “нийгмийн эмзэг” хэмээх бүлгийн өвчин, эмгэгтэй (23,8%), нийгмийн зүгээс анхаарал, халамж байнга шаарддаг (45,5%) хүмүүс гэжээ (нийт 69,3%).

Эндээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай олон нийтийн ойлголт төсөөлөлд сүүлийн 6 жилд ахицтай өөрчлөлт гараагүй байна гэж хэлэх боломжтой байна.

Өөрөөр хэлбэл нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусдын адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээж, нийгмийн харилцаанд адил тэгшээр оролцох ёстой гэсэн ойлголт бүрдээгүй бөгөөд энэ хэрээрээ нийгмийн хүлээн авалт ч бий болоогүй байна.

Зөвхөн нийгмийн хүлээн авалт тухайд биш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд ч нийгмийн амьдралд эрх тэгшээр оролцох талаар ойлголт, мэдлэг бүрдээгүй төдийгүй тэдний нилээдгүй хувь нь өөрийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлгүй байдаг ажээ<sup>4</sup>.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны угтвар нөхцлийг бүрэлдүүлэхэд анхаарах дараахи зүйл нь:**

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үр дүнтэй эмнэлгийн тусламжаар хангахыг баталгаажуулах явдал юм.

<sup>4</sup> Тодруулан хэлбэл судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 45 орчим хувь нь өөрсдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг ямар нэг хэмжээгээр мэддэг бол тэдний гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын 48 орчим хувь, энэ чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг хоёр хүн тутмын нэг нь дээрх хууль, тогтоомж, тушаал тэргүүтнийг тодорхой түвшинд мэддэг байна.

-2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны тайлан

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар суурь харилцааг хуульчлан тогтоож өгсөн<sup>5</sup> ч үндэсний хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн нэр төрөл, тоо хэмжээ нь нийгмийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй, эмнэлгийн тусламж үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд жигд хүрч чадахгүй байна<sup>6</sup>.

### **Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдон гарч ирэх дараахи угтвар нөхцөл бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сэргээн засалтын үйлчилгээгээр хангагдах явдал юм.**

“Сэргээн засалт” гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие бялдрын, мэдрэхүйн, оюун санааны, сэтгэцийн ба нийгмийн үйлдлүүдийн түвшингийн өөрийнх нь дээд хэмжээнд хүргэхийн тулд тэдгээрийн амьдралыг биеэ даах хамгийн дээд түвшинд хүргэхэд хэрэглүүр болгож чадваржуулах үйл явц юм<sup>7</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засалтын үйлчилгээгээр хангах тухай үндсэн харицаа нь хууль эрх зүйн хийгээд төрийн бодлогын түвшинд баталгаажсан<sup>8</sup> ч энэ чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн бүх хэлбэрийг багтаасан үндэсний хэмжээний нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн байдал нь учир дутагдалтай байна. Төрөөс ч тэр, олон улсын байгууллагуудын дэмжлэг, оролцоотойгоор хэрэгжиж буй

<sup>5</sup> Нийгмийн эрүүл мэндэд хандсан хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх бодлого, үйл ажиллагааны үндэсийг Эрүүл мэндийн тухай хууль (1998.05.07)-д зааж өгсөн бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль (2000.04.20), Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2002.04.25), Нийгмийн халамжийн тухай хууль (2005.12.01)-иар зохицуулж байна. Үндэсний хэмжээнд “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр” (2002.04.03), “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр” (2002.07.16)-үүдийг хэрэгжүүлж байна. 2006 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдалыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.

<sup>6</sup> Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн таван хүн тутмын хоёр нь, тэдний асран хамгаалагчид, гэр бүлийн гишүүдийн гурван хүн тутмын нэг нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой ажил үйлчилгээ эрхлэгчдийн гурван хүн тутмын хоёр нь л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авч чадааг гэжээ.

2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулын судалгааны тайлан

<sup>7</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэм НҮБ-1993

<sup>8</sup> Эрүүл мэндийн тухай хууль (1998.05.07), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль-д (2005.12.01), Засгийн газрын 118 тоот тогтоол (2006.05.24)- “Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам, НХХЯ-ны сайдын 55 тоот тушаал- “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр”, 2006 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдалыг сайжруулах үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 118 тоот тогтоол (2006.05.24)- “Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх журам, НХХЯ-ны сайдын 55 тоот тушаал- “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хөтөлбөр”, 2006 оны 11 дүгээр сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдалыг сайжруулах үндэсний хөтөлбөр”

төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд ч тэр олон үйл ажиллагааг хэрэгжүүлж, басхүү одоо ч хэрэгжүүлсээр байна<sup>9</sup>.

Гэсэн хэдий ч Сэргээн засалт шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс энэхүү үйлчилгээг хүртэж чадахгүй байна<sup>10</sup>.

**Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр тутсын амьдралд бие даан оролцох, өөрсдийн эрхийг эдлэхэд нь туслахын тулд туслах хэрэгсэл, үйлчилгээгээр хангах ёстой.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг туслах хэрэгсэл, үйлчилгээгээр хангах асуудлыг мөн л хууль, дүрмээр баталгаажуулж<sup>11</sup>, төрийн үйлчилгээний байгууллагууд ч зохих үйлчилгээг хүргэсээр<sup>12</sup> байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн туслах хэрэгслийг Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хүргэж байгаа ч нэр төрөл, тоо хэмжээний хувьд тэр бүр хангалттай байж чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нийгмийн халамжийн газраас нийлүүдэг тэргэнцэрийн чанар хангалтгүй байдаг гэсэн гомдол их байгаа бөгөөд асуудал хариуцсан албан тушаалтнууд төсөвлөгдсөн мөнгөнд багтаан өмнөд хөршөөс хямдханыг оруулж ирдэг тул чанартайг нийлүүлж чаддаггүй гэж байв.

**Энэ бүгдээс дүгнэхэд:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны угтвар нөхцөл нь төрийн бодлого, хууль эрх зүйн актын хүрээнд зохих байдлаар тусгагдан баталгаажсан ч хэрэгжилтийн түвшиндээ хангалттай бус байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны нөхцөл өнөөгийн байдлаар хангалттай бүрдээгүй байна. Үүнийг

<sup>9</sup> Жишээ нь: ЭМЯ, Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах Тэгш дүүрэн хөтөлбөр”, Сэргээн засалтын Үндэсний Төв нь 2005 онд болон 2006 оны эхний хагаст 833 өвчтөн хүлээн авч 8230 ор хоног ашиглан хэвтүүлж, амбулаториор 1225 хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн байна.

<sup>10</sup> 2005 онд Италийн засгийн газрын бус АИФО байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн асуулгын судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 45.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байдалд шилжихээс өмнөх урьдчилан сэргийлэх үзлэгт, 47.1 хувь нь бие эрхтний ажиллагааг нөхөн сэргээх эмчилгээнд, 51.4 хувь нь алдагдсан ажиллагааны хязгаарлалтыг нөхөн сэргээх эмчилгээнд, 33.1 хувь нь эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээнд огт хамрагдаж байгаагүй ажээ.

<sup>11</sup> “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль” (2005.12.01), “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль” (1994.06.07), “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль” (2002.04.25), “Боловсролын тухай хууль” (2002.05.03), Бага дунд боловсролын тухай хууль” (2002.05.03), Дээд боловсролын тухай хууль” (2002.05.03).

<sup>12</sup> Сэргээн засалтын Үндэсний Төв нь 2005 онд болон 2006 оны эхний хагаст 1561 хүнд үйлчилж 70773.3 сая төгрөгийн протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэсний 16223.1 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас, 18637.6 сая төгрөгийг иргэд өөрсдөө төлж, 1138.7 мянган төгрөгийг буяны болон албан байгууллагын хандив тусламжаар үйлдвэрлэсэн байна.

нийгэмд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “нийгэмд тэгш эрх эдэлж, үүрэг хүлээж, тэгш оролцох” тухай ойлголт бүрдээгүй, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийн түвшин хангалтгүй байдалтай холбоотой ч нөгөө талаар төр, төрийн үйлчилгээний байгууллагууд өөрсдийн нэгэнтээ батлан гаргасан хууль, тогтоомжоо үр дүнтэй хэрэгжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

## **Стандарт дүрмийн дараагийн хэсэг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны боломжийг зорилтот салбаруудад бүрдүүлэх явдал юм.**

### **ТЭГШ ОРОЛЦООНЫ ЗОРИЛТОТ САЛБАРУУД**

Олон улсад чадвар алдалтын гол шалтгааныг бие эрхтний чадваргүй байдал бус оролцоонд учирч буй орчны саад бэрхшээл<sup>13</sup> гэж үзэх болжээ. Тэгвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцооны байдал ямар байгааг авч үзье.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог хүртээмжтэй болгох хууль эрх зүйн асуудлыг боловсронгуй болгоход цаашид анхаарах хэрэгтэй байгаа нь холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгагдаагүй буюу хэт ерөнхий байдлаар тусгасан байгаагаас харж болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хүргэж байгаа ч энэ нь хүн бүрт хүрэх боломж, нөхцөл бага байгаа бөгөөд тухайлбал, өдөр тутмын мэдээ мэдээллийг дохионы хэлний орчуулгатай хүргэх асуудал бүрэн шийдвэрлэгдэж, тогтмолжоогүй байна.
- Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байхгүй. Сүүлийн жилүүдэд хараагүй болон тэргэнцэртэй хүний зорчих зам, орц, гарцын дуут дохио зэргийг нийслэл хотод цөөн тоогоор барьж байгаа нь сайшаалтай ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгох нь зайлшгүй хэрэгцээ болоод байна.<sup>14</sup>
- Төрийн бодлого, хөтөлбөрт багагүй тусгагдаж, хэрэгжиж буй нь боловсролын салбар дахь үйл ажиллагаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр зохих дэвшил гарсан ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт бага, ердийн сургалттай сургуульд суралцахад гарч буй хүндрэлтэй байдлууд их, интеграцчилсан сургалт явуулж буй сургалтын байгууллагууд дахь орчны хүртээмж, туслах үйлчилгээнүүд хүрэлцэхгүй

<sup>13</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги 2004 ОУХБ, НҮБ-ын БШУСБ, ДЭМБ

<sup>14</sup> 2004 онд Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” (БД 31-101-04)-ийг баталсан бөгөөд мөн оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

байгаа зэргийг дурьдах нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай боловсролын хэрэгцээ чухал хэвээр байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дэмжин<sup>15</sup> хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажиллуулаагүй тохиолдолд төлөх төлбөр хийгээд түүний зарцуулалт, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцлийн хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлт, мэргэжлийн сургалтаар мэргэжил эзэмшүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх боломжийг олгожээ. Төсөл, хөтөлбөрийг ч цөөнгүй хэрэгжүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс бодлого, хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэхэд анхаарч байгаа ч хөдөлмөр эрхлэх боломжтой олон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Энэ нь дээрх үйл ажиллагаанууд өргөн цар хүрээг хамарч чадахгүй байгаатай холбоотой, нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх сэтгэл хийгээд бие бялдарын хувьд бэлтгэх, нийгмийн хүлээн авалт, үнэлэмжийн асуудал багагүй нөлөөлж байгаа билээ.
- Монгол улсын хэмжээнд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг буюу хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан, бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн, хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтод ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмсэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон хүн зохих орлоготой байхыг баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлээс үүдсэн хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгон, дээрх шалгуурыг хангасан хүн л нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагддаг. 2004 онд гаргасан ҮСГ-ийн бүртгэл, түүвэр судалгаагаар Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.6 хувь нь буюу 8000 гаруй иргэн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээ тогтоолгоогүй байв. Түүнчлэн 22.6 хувь нь Нийгмийн халамжийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлдэг хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаг гэсэн бөгөөд үлдсэн 77.4 хувь нь буюу 2057 иргэн хамрагдаж чадаагүй гэжээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан нийгмийн хамгааллын чиглэлийн төрийн бодлогод иргэдийг зөвхөн халамжийн тэтгэвэр аваад суухаас илүүгээр ажил хөдөлмөр эрхлэхэд, нийгэм, хамт олны дунд идэвхтэй амьдрах, өөрсдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дэмжихэд анхаарсан бодлого хэрэгжүүлэхээр болж үүнийгээ ч зохих хууль, тогтоомжийн хүрээнд баталгаажуулжээ. Хэдийгээр энэ нь хэтийн ирээдүйтэй бодлого ч өнөөдрийн нөхцөл байр сууринд нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчихгүй байхад чухалчлан цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд илүү ихээр анхаарах хэрэгтэй байна.

<sup>15</sup> Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар (2006 оны нэмэлт өөрчлөлт)



- Хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй л биш бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувь хүний эрхийн дагуу гэрлэх, гэр бүлийн амьдрал зохиох эрхтэй төдийгүй тэжээн тэтгүүлэх, харгалзан дэмжүүлэх эрх зүйн зохицуулалт хуульчлагджээ. Гэсэн ч хуулийн заалт бодит байдалд хэрэгжихгүй байх нь олонтаа. 2004 онд НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр НХХЯ-ны захиалгаар Гал голомт хөдөлгөөний судлаачдын багийн гүйцэтгэсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын хандлага” судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн байдлаар хүүхдээ насанд хүртэл тэжээн тэтгэж, хөдөлмөрийн чадваргүй бол насанд хүрсэн хойно нь тэжээн тэтгэх үүргийг эрэгтэйчүүдийн 61.8 хувь нь, эмэгтэйчүүдийн 57.0 хувь нь л сайн биелүүлж байгаа гэж үзсэн бол хүүхэд насанд хүрээд эргээд эцэг эхээ тэжээн тэтгэж байгаа байдал сайн байгаа гэж нийт хүмүүсийн тал хүрэхгүй (47.0) хувь нь үнэлжээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, спортын үйл ажиллагаанд оролцохыг хуулиар баталгаажуулж өгсөн ч бодит байдал дээр энэ нь жигд хүртээмжтэй байж чаддаггүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь Монгол улсын иргэнийхээ хувьд шашин шүтэх, эс шүтэх үндсэн эрх, эрх чөлөөг эдлэх бөгөөд Онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүний амьд явах эрхийн адилаар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон байна<sup>16</sup>. Гэсэн ч эдийн засгийн хувьд дутмаг байдлаас шалтгаалан өөрийн хүсэл, сүсэг бишрэлээр бус байдлаар шашны нөлөөнд орох байдал бий болсон байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцооны байдал дээр дурьдсан нэр бүхий салбаруудын хүрээнд хангалттай гэж боломгүй хэмжээнд байна. Энэ мэдээж: тэгш оролцооны угтвар нөхцөл сайн бүрдээгүйгээс зохих хэмжээнд хамаарах ч, тэгш оролцооны боломжийг олгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх байдалтай ч мөн холбоотой юм.**

### **ТЭГШ ОРОЛЦООНЫ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан, бодитой арга хэмжээг үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай байна.

- Өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлын талаар нэгдсэн мэдээллийн сан байхгүй бөгөөд улсын хэмжээнд хийгдсэн судалгаанууд дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо болон нөхцөл

<sup>16</sup> Монгол Улсын Үндсэн хууль 1992 он

байдлын талаарх мэдээллүүд зөрүүтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар бодитой судалгаа хийхэд нэр томъёо, ойлголтын байдлыг нэн тэргүүнд цэгцлэх, олон улсын жишигт хүргэх нь чухал байна.

- Үндэсний түвшинд төлөвлөж хэрэгжүүлж буй төрийн бодлогуудад болон ерөнхий хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг ерөнхий байдлаар оруулж, орон нутгийн түвшинд үйл ажиллагааг дэмжихэд зохих байдлаар анхаардаг байна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баримталж буй төрийн бодлого хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, төрөөс нэгдсэн байдлаар цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэгч салбар нэгж, санхүүжилтын эх үүсвэр, төрийн бус хийгээд олон улсын байгууллагуудын хувь оролцоог тодотгон өгөх хэрэгцээ байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд хамаарах хууль эрх зүйн орчин зохих түвшинд бүрдэж байна гэх боломжтой ч цаашид мөн улам боловсронгуй болгох, салбар хоорондын бодлого, зохицуулалт, хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах тал дээр анхааран ажиллах шаардлагатай байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох үндэсний хөтөлбөрүүд болон арга хэмжээнүүдийн санхүүжилтийн байдалд олон улсын байгууллагууд, хандивлагчдийн үүрэг оролцоо харьцангуй өндөр байна. Хэдийгээр олон улсын байгууллагуудаас санхүүжигдэж байгаа нь төрийн ачааллыг багасгах, төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад дэмжлэг болж байгаа ч нөгөө талаар төрийн хариуцлагыг саармагжуулах, биеэ даасан бодлого, үйл ажиллагааг алдагдуулах байдалд хүргэх боломжтой юм гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Монголд Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар тэгш оролцооны стандарт дүрмийн хүрээнд байгуулагдсан үндэсний түвшинд үйлчлэх байнгын ажиллагаатай, хууль ёсны Үндэсний зохицуулах хороо буюу түүнтэй ижил төстэй үүрэг бүхий байгууллага одоогоор бүрэн байхгүй байгаа бөгөөд ийм төрлийн үүрэг бүхий байгууллагын хэрэгцээ байна.
- Манайд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд цөөнгүй байгуулагдсан ч оюуны хомсдолтой сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах байгууллага байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага нь нэгдсэн зохион байгуулалтад орох нь байгууллагын чадавхи, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, зорилго, үүргээ биелүүлэх, үр дүнтэй ажиллахад чухал юм. Төрөөс ХБИБ-уудыг шууд дэмжсэн тусламж ч, 2006 оноос төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх хуулийн заалтын дагуу ХХҮГазар, НХХЯамтай ХБИБҮХолбоо гэрээ байгуулан ажиллаж зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх болсон нь сайшаалтай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой ажил, үйлчилгээ эрхлэгчдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх байдалд анхаарах хэрэгтэй байна. Нийгмийн

халамжийн тухай хууль (2005)-д зааснаар халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах нь ХХҮГ-т хамаарах бөгөөд төрийн байгууллагуудын хүрээнд хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ажилтнаа сургалтанд хамруулдаг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын ажилтныг сургах байдал орхигддог байна. Одоогийн байдлаар манайд хэд хэдэн их дээд сургууль, тэр дундаа улсын хэмжээний томоохон сургуулиудад нийгмийн ажилтан бэлтгэж байна. Мэргэшсэн боловсон хүчнээр сургалт явуулах, нарийн мэргэжилтэн бэлтгэх байдал хангалтгүй байгаа бөгөөд 1990 оноос хойш согогзүйч мэргэжилтэн бэлтгээгүй, монголд ийм мэргэжилтэн бэлтгэдэг сургалт байхгүй, одоогоор ажиллаж байгаа согог зүйчид мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж чаддаггүй байна.

- Төрөөс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүдийн үр дүн, хэрэгжилтэд нэгдсэн байдлаар хяналт тавих, үнэлгээ хийх тогтолцоо бүрдээгүй бөгөөд тухайн хөтөлбөрийн хүрээнд дотоодын болон хөндлөнгийн хяналт, үнэлгээ тусгагдсан байна.
- Монголын Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд тэр дундаа Хүүхдийн сан, Боловсрол Шинжлэх ухаан Соёлын Байгууллага, ТАСИС, Хүүхдийг ивээх сан (Англи), АДРА, Дэлхийн зөн, Данида, АИФО, ДЭМБ, ОУХБ, АХБ, Японы Ядуурлыг бууруулах сан зэрэг олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог өндөрөөр үнэлэх нь зүйтэй.

## “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХ” СУДАЛГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Илтгэгч: Д.Даваадамдин,  
Нийгмийн хяналт, хөгжлийн судалгааны төвийн захирал*

### НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХҮРЭЭ, АРГАЧЛАЛ

#### **Судалгааны зорилго**

Монгол Улсад НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенци түүний хэрэгжилт ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үндсэн эрхийн хэрэгжилт ямар төвшинд явагдаж буйг харуулах нөгөө талаар ХБХ-ийн эрх зүйн актууд, холбогдох хууль тогтоомж, бодлого, түүний хэрэгжилтийг харьцуулах, дүн шинжилгээ хийх зорилгоор уг судалгаа хийгдэв.

#### **Судалгааны хүрээ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилтийг тодорхойлох зорилготойгоор уг судалгаа хийгдэж буй тул дараах субъектууд хамрагдлаа.

Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- ХБХ-ийн эцэг, эхчүүд
- ХБХ-тэй ажилладаг мэргэжлийн байгууллага
- Холбогдох бусад байгууллагууд

#### **Судалгааны аргачлал**

Уг судалгаагаар судалгаанд хамрагдсан орон нутаг түүнчлэн тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх тоон ба чанарын мэдээлэл цуглуулж судалгааны эцсийн тайлан мөн санал зөвлөмжийг гаргав. Судалгаанд дор дурдсан аргуудыг ашиглав.

- **Ярилцлага** - Тоон ба чанарын асуултууд орох ба чөлөөт (open-ended), тодорхой хариулт (closed)-аар авна.
- **Хувьчилсан ярилцлага** - тодорхой заасан сэдвээр эсвэл тодорхой хувь хүнтэй ярилцах
- **Асуулга** - хэмжих үзүүдэлттэй холбоотойгоор асуулга авна
- **Бүлгийн ярилцлага** - 12-15 хүнийг багтаасан ярилцлага

- **Кейс жишээ** - Тодорхой болсон үйл явдлын дүн шинжилгээ
- **Харьцуулалт дүн шинжилгээ**
- 2-догч мэдээлэлтэй харьцуулалт хийх.

### **Сонирхогч талууд**

Судалгааны явц, түүний эцсийн тайлан, үр дүн сонирхогч талуудад бүрэн нээлттэй байна.

### **Мэдээлэл цуглуулалт**

Уг судалгаа нь цаг хугацааны хувьд давчуу байсан тул судалгаанд шаардлагатай үндсэн мэдээллийг цуглуулахын тул судалгааны 3-н багийг зохион байгуулж ажиллуулсан. ХБХ-ийн эрх зүйн актууд, хууль тогтоомжуудыг холбогдох байгууллагуудаас тухайлбал БСШУЯам, Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, орон нутгын эрүүл мэндийн газар, боловсролын газар, нийгмийн халамж үйлчилгээний газраас тус тус цуглуулж бодлого, түүний хэрэгжилтийг харьцуулан дүн шинжилгээ хийсэн.

Түүнчлэн судалгааны гол субъектууд болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтан нар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг эмч эмнэлгийн ажилтан, асуудал хариуцсан төрийн албан хаагчид мөн зарим ТББ-ын холбогдох хүмүүстэй бүлгийн болон хувьчилсан ярилцлага, анкетын санал асуулга зохион байгуулан тэдгээрт дүн шинжилгээ хийн уг судалгааны тайланд тусгасан болно.

### **Мэдээлийн боловсруулалт**

Судалгааны баг SPSS10.0 программыг судалгааны мэдээлэл боловсруулахад ашигласан.

## **ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХ**

### **Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох нь**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм хамгааллын тухай хуульд “Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж ойлгоно” хэмээн тодорхойлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тодорхойлсоор Хувийн болоод нийгмийн зүгээс шалтгаалан сурч, хөгжих үйл явцад нь удаашрал учирч байгаа хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэнэ.

Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалалын яамнаас (тухайн үеийн нэрээр) 1998 онд гаргасан мэдээгээр нийт хүн амын 4,8 хувь буюу 115 мянган хүн хөгжлийн бэрхшээлтэй байна.

1998 онд ҮСГ-аас гаргасан мэдээнд нийт 29 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэж тодорхойлж байжээ. 2004 онд Үндэсний статистикийн газраас хийгдсэн түүвэр судалгаанд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 11.0 хувь буюу 7673 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгааг дурджээ.

### **Боловсрол хамрагдах эрх:**

Судалгааны явцад “Сурч боловсрох эрх”-ийн талаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг боловсролын байгууллагын багш сурган хүмүүжүүлэгчид, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдтэй бүлгийн болон хувьчилсан ярилцлагыг зохион байгуулав.

#### **Ярилцлагын чиглэл**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсроход тулгарч буй бэрхшээл
- Хийгдэж буй ажлууд, боловсролын байгууллагын үйл ажиллагааны тогтолцоо
- Ерөнхий боловсролын сургуулиудад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагыг хэрхэн үнэлэх, цаашид эдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрхэн хангах
- Боловсрол хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хэрхэн хангах

#### **Ярилцлагын үед илэрсэн үндсэн асуудлууд**

- Ерөнхий боловсролын сургуульд оюуны хөнгөн хэлбрийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөргүй
- Эрүүл хүүхдийн сурлагын үнэлгээний аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагыг үнэлдэгээс шалтгаалж ерөнхий боловсролын сургуулиудад сурлагын хоцрогдол гардаг
- Нийгэм олон нийтийн зүгээс тэдэнд хандах хандлага харьцангуй сайжирсан.
- Төр засгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар барьж буй цэгцтэй бодлого байдаггүй
- ОУ-ын байгууллага бусад буюны байгууллагууд, мөн зарим төсөл хөтөлбөрийн хүрээнд эдгээр хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явагдаж байгаа
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог хангах зорилгоор тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтэц улсын хэмжээнд үндсэндээ хөгжөөгүй

- Тусгай сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сурах бичиг байхгүй
- Эдгээр сургуулиудад багшлах мэргэжлийн боловсон хүчнийг улсын хэмжээнд бэлтгэхгүй байгаа
- Улсын хэмжээнд хичнээн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдаж чадаагүй байгааг үзүүлэх тоо баримтгүй.

### Эрүүл байх, эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртэх эрх:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрөх тухай заасан байдгаас гадна 24-р зүйлийн 1, тус зүйлийн 2-ийн б-д мөн л хүүхдийн эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчнийг эмчлэх, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлэх тухай заажээ.

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрөх 5 тухай заасан байдгаас гадна 24-р зүйлийн 1, тус зүйлийн 2-ийн б-д мөн л хүүхдийн эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчнийг эмчлэх, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлэх
- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 24 дүгээрт зааснаар тухайн улс эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эцэг эхчүүдэд зориулсан удирдамж заавар, гэр бүл төлөвлөлтийн боловсрол, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай арга хэмжээ авах

Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 2-т “... хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг хүлээн зөвшөөрч, хүүхэд болон түүний эцэг эх, асран халамжлах бусад хүний нөхцөл байдлыг харгалзан, тэдний гаргасан хүсэлтийн дагуу нөөц боломжийнхоо хирээр тусалцаа үзүүлэх, онцгой халамж анхаарал тавихыг дэмжинэ.

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23-р зүйлийн 3-т “... хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцгой хэрэгцээг ухамсарлан, эцэг эх буюу хүүхдийг асран халамжлах бусад хүмүүсийн нөөц бололцоог харгалзан тусламжийг аль болох үнэ төлбөргүй үзүүлэх
- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 2-ийн 6-д “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эм, эмчилгээгээ тогтмол авч өөрсдийн үйл ажиллагааны төвшинг сайжруулах эсвэл хэмжээнд нь байлгах хэрэгцээг Улс орнууд баталгаажуулах ёстой

2005 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн зөвлөмжийн 44-рт заахдаа “...бүх бүс нутгийн хүүхдүүд тэр дундаа алслагдсан хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдэд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг тэгш хүртээмжтэй

хүртээхийн тулд тус салбарт санхүүгийн болон хүний нөөцийг зөв хувиарлахыг..." чухалчилан зөвлөсөн байна.

Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн 23, 24, 25-р зүйлүүдэд заасан хүүхдийн эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийн заалтууд дээр үндэслэн судалгаанд оролцогчидтой урьдчилан боловсруулсан асуултын дагуу хувьчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулав.

- Орон нутагт зонхилон тохиолдож буй хөгжлийн бэрхшээлийн хэлбэрүүд;
- Эрүүл мэндийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд шаардлагатай эм тариа, тэдгээрийн эмчилгээ, оношлогоонд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ;
- Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарын тусламж, үйлчилгээ;
- Орон нутагт цаашлаад улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тодорхой нэгдсэн бодлого байдаггүй
- Хүнд хэлбрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тодруулбал, саажилттай болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд зөвхөн эцэг эхийн халамжинд байхаас эрүүл мэндийн байгууллагын зүгээс ямар нэгэн хяналт, тусгайлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэггүй харин ч тээршаах байдал түгээмэл байдаг
- Эмнэлгийн удирдлага, эмнэлгийн эмч ажилтан нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн талаар цэгцтэй ойлголт байхгүй эдгээр хүүхдүүдийн эрүүл мэндийн талаар тусгайлан хийгдэж буй ажил байхгүй
- Өрхийн эмч нарын зан харьцаа тааруу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндэд анхаарах анхаарал халамж сул
- Эмч нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, сувилгаа, эмчилгээ оношлогооны талаархи мэдлэг тааруу
- Хараа сонсгол хэл ярианы бэрхшээлүүд зонхилдог байна. Тухайлбал, Дорнод аймгийн хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлүүдийн 40 гаруй хувийг хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлүүд эзэлдэг байна.
- Эрт оношилж эмчилгээ хийгддэггүй
- Хөдөө орон нутагт тулгуур эрхтний олдмол хөгжлийн бэрхшээл элбэг байдаг ба энэ нь хөдөөгийн малчдын хүүхдүүдийн дунд ихэнхдээ тохиолддог учир нь малчин айл өрхийн эрхэлж буй аж ахуй, амьдралын хэв маягтай холбоотойгоор морь малнаас унаж гэмтэх үед үүссэн хөгжлийн олдмол бэрхшээлүүд
- Төрөлтийг зөв удирдаж чадаагүй эрүүл мэндийн салбрийн эмч эмнэлгийн ажилтан нарын мэдлэг чадвар сул тэдгээрийн хайхрамжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж төрөх замд хүүхдийн нугас мэдрэл гэмтэн саажилттай хүүхэд мэндлэх явдал байсаар байна



- Сум, багын төвшинд нөхөн үржихүйн талаархи сургалт, сурталчилгаа хангалтгүй үүнээс шалтгаалж хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүст гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн мэдлэг боловсрол байхгүй ба цус ойртолт, архи дарснаас үүдэлтэй оюуны хомсдолтой хүүхэд төрөх явдал элбэг болсон байна.
- Аймаг, сум, багт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эм тарианы хүрэлцээ хангамж гэж ерөнхийдөө байхгүй
- Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ч эдгээр хүүхдүүд эрүүл мэндийн оношлогоо эмчилгээ хийгдэхгүй заавал Улаанбаатарт очиж эрүүл мэндийн байгууллагад хандах шаардлагатай болдог
- Нийслэл болоод аймаг орон нутагт ч нөхөн сэргээх төвүүд хүрэлцээтэй бус байна. Үйл ажиллагаа явуулж буй нөхөн сэргээх төвүүд нь төр засгийн зүгээс бус ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг тусалцаатайгаар үйл ажиллагаагаа явуулж
- Хөдөө орон нутагт эрүүл мэндийн боловсон хүчин дутагдалтай

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн халамж үйлчилгээ:

Судалгааны энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, нийгмийн халамжийн байгууллагын ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, мөн тусгай сургалттай сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо.

- Монгол Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгэм Хамгааллын Тухай Хуулийн 4.1-т “хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд нийгмийн хамгааллын тодорхой үйлчилгээнд хамрагдах эрхтэй
- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 15.3-т “...хөгжлийн бэрхшээлийн талаар тусгай хууль, тогтоомж гаргах, хууль тогтоомжид зарим нэг онцгой сэдвүүдээр хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хамруулах, мөрдөж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхийг онцгойлон дурдсан заалт оруулах” 12 тухай
- Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн Нийгмийн Хамгааллын Тухай Хуулийн 9.3.4-т “гэрлэн дохио, нийтийн үзвэр, үйлчилгээний газрын талбай, зам, харьцаа, холбооны хэрэгсэл эдгээр иргэдийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх” 13 тухай
- Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 5.1-т “... гэр орон, байшин барилга, нийтийн тээврийн үйлчилгээ болон бусад тээврийн хэрэгслүүд, гудамж, талбай, зам мөн бусад гадаад орчин зэргийг хүртээмжтэй байлгахад анхаарлаа хандуулах ёстой
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн 5.3-т “барилга байгууламжийн бүтэц дизайнд үйл явцын эхнээс саадгүй орчин бий болгох хүртээмжийн шаардлагыг хамруулах ёстой”.

Нийт хүүхдүүдийн 58% нь группын тэтгэвэр авдаг, 27% нь байнгын асаргааны тэтгэмж, үлдэж буй 15% нь бусад төрлийн тэтгэмж авдаг гэж тус тус хариулсан байна.

Монгол Улсын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Нийгэм Хамгааллын Тухай Хууль НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох” Стандарт Дүрмийн заалтууд дээр үндэслэн судалгаанд оролцогчидтой урьдчилан боловсруулсан асуултын дагуу хувьчилсан болон бүлгийн ярилцлагыг зохион байгуулав.

- Нийгмийн халамжийн байгууллагаас ХБХ-д үзүүлж буй тусламж, үйлчилгээ төрөлжсөн асрамжийн үйлчилгээ бий эсэх;
- Нийгэм, хамт олны амьдралд оролцох, мэргэжлийн баримжаа олгох талаар баримталж буй бодлого, энэ чиглэлээр хийгдэж буй ажлууд;
- Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэж буй ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан зассан эсэх;
- ХБХ-ийн эцэг эхийн нийгмийн байдал тухайлбал, боловсрол, цалин, өрхийн орон сууцны байдал;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зарим эцэг эхчүүд, асран хамгаалагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын талаарх хууль эрх зүйн актын мэдлэг сул байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Энэ нь хууль батлагдан гардаг боловч түүний хэрэгжилт муу, батлагдсан хууль, эрх зүйн актыг олон нийтэд сурталчилж, таниулдаггүй
- Төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагсадын хууль, эрх зүйн актын талаар мэдлэг сул энэ байдлаас болж эцэстээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хохирч
- Хууль тогтоомжийн зарим заалтууд хэтэрхий бүрхэг тодорхойгүй байдгаас шалтгаалж нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахад бэрхшээл учирдагыг
- Боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тэднийг ахуйн хэв шинжинд сургах, нийгмийн амьдралд оролцуулах тал дээр ямарч санал санаачилга байхгүйг дурджээ.
- Нийгмийн амьдралд ХБХ идэвхтэй оролцоход дэмжлэг болох зорилгоор хийгдэх ёстой ажлууд тухайлбал, нийтийн үзвэр үйлчилгээний газрын гарц, орц, замын тэмдэглэл, гарцыг эдгээр иргэд болон хүүхдүүдэд зориулан засах үйл ажиллагаа явагдахгүй байгааг судалгаанд оролцогчид тэмдэглэсэн байна.
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн гишүүний нэг нь хүүхдээ асарсны улмаас ажил эрхлэх боломжгүй болдог. Иймээс эрүүл хүүхэдтэй гэр бүлийн өрхийн орлоготой харьцуулахад хүнд хэлбрийн ХБХ-тэй гэр бүлийн орлого дунджаар 50%-аар бага байдаг байна.

## ГУРАВ. САНАА, ЗөВЛөМЖ

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн талаар:**

- Хүний хөгжлийн болон эмнэл зүйн аргачлалаар “хөгжлийн бэрхшээл”-ийг тодорхойлж, нэгдсэн нэг ойлголтонд хүрэх
- Дээрх үйл ажиллагаан дээр үндэслэн улсын хэмжээнд нэгдсэн аргачлалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар судалгаа явуулж улсын хэмжээний нэгдсэн мэдээллийн сантай болох
- Үүнтэй уялдуулж, нийгэм эдийн засгийн үндэслэлийг тооцон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулах
- Нийгэм олон нийтийн хандлагыг өөрчлөх
- Эцэг эх, сургуулийн зүгээс тэдэнд тавих анхаарал халамжийг дээшлүүлэх
- ЕБС-дад хөнгөн хэлбэрийн оюуны бэрхшээлтэй болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ерөнхий боловсролын сургуульд сурах стандарт журам боловсруулах, эдгээр хүүхдүүдийг сурлагын ахицаар үнэлэх
- ХБХ-дэд зориулсан арга зүйн болоод техникийн шаардлага хангасан сурах бичигтэй болох
- Тусгай болон ерөнхий боловсролын сургуулиудад ажиллах мэргэжлийн багш сурган хүмүүжүүлэгчдээр хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог хангах зорилгоор нийгмийн дэд бүтэц тухайлбал, налуу шат, нийтийн бие засах газарт тэдэнд зориулсан тусгай суултуур, зам талбайн тусгай тэмдэглэлийн стандарт боловсруулж улсын хэмжээнд мөрдүүлэх
- Сурч боловсрох эрх нь ноцтойгоор зөрчигдөж буй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тодруулбал саажилттай болон тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах зорилгоор ЕБС-дад болон цэцэрлэгүүдэд тусгай анги нээн ажиллуулах

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэх эрхийн талаар:**

- Төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар баримтлах нэгдсэн эрүүл мэндийн бодлоготой болох
- Олон нийтийн ялангуяа эрүүл мэндийн салбарт ажиллагсадын хандлагыг өөрчлөх
- Орон нутагт ажиллаж буй эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, бүсийн оношлогооны төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд оношлогоо, эмчилгээг хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлж оношлох, эмчлэх

- Орон нутагт ажиллах эрүүл мэндийн боловсон хүчний хангамжийг сайжруулах, тэдгээрт орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх
- Орон нутагт амьдарч буй хүмүүсийн гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн мэдлэгийг дээшлүүлэх энэ талаар мэргэжлийн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зайлшгүй шаардлагатай эм тарианы хангамжийг сайжруулах
- Нийгэм, эдийн засгийн үндэслэлийг тооцон бүх аймагт нөхөн сэргээх төвүүдийг нээн ажиллуулах

### **ХБХ-ийн нийгмийн халамж үйлчилгээний эрхийн талаар:**

- Нийгмийн халамжийн тухай хуулийг ХБХ-тэй эцэг эх, олон нийтэд сурталчилах,
- Хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх заалтыг тодруулж оруулах, Тухайлбал: шалгуур үзүүлэлт, тэтгэвэр тэтгэмж
- Хуулинд заасан шалгуур үзүүлэлтийн зарим заалтыг уян хатан болгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх талаар тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, Тухайлбал: бага хүүтэй зээл олгох, аж ахуй эрхлэх тал дээр төр засгаас дэмжих,
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг бий болгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог дээшлүүлэхэд зайлшгүй нэн шаардлагатай тэдэнд зориулсан нийгмийн тусгай дэд бүтцийг бий болгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мэргэжлийн баримжаа олгоход төр засгаас анхаарах,

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцооны талаар:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тэдэнд зориулсан нийгмийн дэд бүтэц тухайлбал нийтийн тээврийн хэрэгсэл, орон сууц, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, тусгай тэмдэглэлүүдийг бий болгох, эдгээрийг стандартчилах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах олон нийтийн хандлагыг өөрчилж эдгээр хүүхдүүдэд нийгэмд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх
- Нийгмийн оролцоог дээшлүүлэх талаар боловсролын байгууллага санаачилга гарган ажиллах тодруулбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш боломжийг хангах үүднээс тэдний аль болох хичээлийн бус цагаар олон нийтийн үйл ажиллагаа болон секц, дугуйланд хамруулах

**Эрхийн мэдлэгийн талаар:**

- Батлагдсан хууль, тогтоомжийг хөгжлийн бэрхшээлтэй нийт хүмүүсийн тусгай хэрэгцээг харгалзан эдгээр хүмүүст зориулсан хууль эрх зүйн актуудын тусгай мэдээллийн сантай болгох
- Ингэхдээ брайлээр, том үсгийн фондоор бичих болон бусад тохирох технологийг ашиглан мэдээллийг хүртээмжтэй болгох
- Нийгмийн харьцааны гол тулгуур болох эрх үүргийн тогтолцоог хүүхдүүдэд багаас нь таниулж, ойлгуулах

## Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн ЭРХ, Хүчирхийлэлийн Асуудалд

*О.Сэлэнгэ,  
Хөгжлийн бэрхшээлтэй  
Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн*

Хүндэт хатагтай ноёд оо

Та бүхний амгаланг эрэн мэндчилэхийн ялдамд олон улсын ХБИ-ийн эрхийн өдрийн мэндийг дэвшүүлж шудрага ёс, хүмүүнлэг нийгмийг цогцлон байгуулах тэмцэлд амжилт хүсье. Өнөөдөр бид ХБИ-д эмэгтэйчүүдийн талаар баримталж буй төрийн бодлого түүний хэрэгжилтийг дүгнэх, гарч буй саад бэрхшээлийг арилгах талаар хамтран ажиллах санал сэтгэгдлээ солилцон дуу хоолойгоо хүргэхээр энэ танхимд цуглаж байна.

1990 оны ардчилсан өөрчлөлтийн дагуу амжилттай хийгдэж байгаа зүйлүүдийг бид улам боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хэрэгжүүлэхэд шаардагддаг хүний эрхэм чанарыг хүндэтгэн хэрэгжүүлэх асуудал хэрэгжихгүй байна. Энэ нь хүн болж төрсний хувьд зайлшгүй эрхээ эдлэж хүн ёсоор амьдрах хэм хэмжээ хангагдсан байхыг хэлдэг.

Манай нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм чанарын тухай ойлголт төлөвшөөгүй байгаа учраас хүний эрх системтэйгээр, хувь хүнээс гадна бүлэг хүмүүсийн эрх зөрчигдөж нийгэмд шудрага бус ёс ялахад хэн ч гайхахгүй болсон байна. Нэгэнт хүний эрхэм чанарыг ойлгохгүй, хүндэтгэхгүй болсон нь хүний эрхийн мэдрэмж, хүний эрхэнд суурилсан хандлага төлөвшихгүй байгаагаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүд хүний эрхийг зөрчих сөрөг үр дагаварт хүргэж байна.

Юуны түрүүнд бид тэгш эрхийг нийгмийн ямар харилцаанд тулгуурлан тунхаглаж амьдрал дээр хэрхэн хүлээн авч байгаагаар авч үзэх хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний байгалиас заяасан эрх нь иргэний нийгэм байгуулах үед нийгмийн гэрээ буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төр засгаас хамгаалан баталгаажуулах үүрэг хариуцлага болтлоо хөгжиж байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой зарим хуулиудад нэмэлт өөрчлөлт нэн даруй хийх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 65%-ийг эзэлдэг эмэгтэйчүүд бид МУ-ын Үндсэн хуульд тэгш эрхтэй гэж тунхагласан ёсоор ХБ хүнд эерэг ханддаг

нийгмийг бүтээн байгуулахад мөр зэрэгцэн оролцохыг хүсдэг. Гэтэл өнөөдөр манай эмэгтэйчүүдийн төлөв байдал ямар байна вэ? 6000 гаруй хүнд хийсэн судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн 11% бичиг үсэггүй байхад дөнгөж 4% нь дээд боловсролтой байна. Эрхтний согогынхоо улмаас насанд хүрэгчдийн гэр бүл болох боломжгүй байдал хараагүйн 45%, сонсох ярих эрхтний 80%, бусад 55%-ийг эзэлдэг байхад 2-5 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд 80% байна. Бусад нь ганц бие буюу бусдын асрамжинд байна. Эмэгтэйчүүдийн нийгэм, соёл, эдийн засгийн эрх хангагдах тийм боломж нөхцөл, нийгмийн сэтгэл зүй бидэнд алга.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх яагаад зөрчигдөж төр засагт гомдол саналаа илэрхийлж байна вэ гэдгийг судлан үзэх хэрэгтэй байна. Бидэнд хамаарах хуулийг боловсруулах ба хэрэгжүүлэх явцад санал авдаггүй өөрөөр эмзэг бүлгийн иргэдийн амьдралыг газар дээр нь биш хөндлөнгөөс хардаг төрийн түшмэдүүдийн боловсруулсан цоорхой хууль, дунд шатны албан хаагчдын хүнд суртал, сэтгэлгээ, чадавхиас шууд нөлөөлж байгааг бид өдөр тутам мэдэрч байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж, ад үздэг байдал нь тэднийг хүчирхийлэлд өртөх үндсэн шалтгаан болж байна. Энэ нь эрхтний согог, биеэ хамгаалах чадвар сулыг далимдуулсан хүний эрхийг ноцтой зөрчиж буй гэмт хэрэг юм. Мөн эмэгтэйчүүдийн нэр төрийг улс төр бизнест ашигладаг байдал газар авлаа. Үүнийг бид эсэргүүцэж байна. Үүний жишээ нь үйл ажиллагаандаа хамруулдаггүй мөртлөө бидний нэрээр байгуулагдсан олон ТББ, сангууд юм. Үүнийг төр анхааралдаа авах ёстой.

Нөгөө нэг асуудал нь нөхөн үржихүйн эрх юм. Гэр бүлийн харилцаа нь өргөн утгаараа нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санаа, өрх гэрийн харилцааг хамаарсан цогц нэгдэл юм. Тэгвэл энэ бүгдэд эмэгтэйчүүд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тэгш эрхтэй оролцож чадаж байна уу гэдэг асуудал тавигдана. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн олонхи нь эрхтний согогоосоо шалтгаалж гэр бүлийн амьдралд оролцож чадахгүй байгаа нь тэгш эрх гэдэг ойлголтыг урвуугаар хэрэглэх үндэс болж байна. Энэ зөрчилд хүргэж байгаа нэг тал нь нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ бөгөөд хүн хүнээ хайрлан энэрэх манай уламжлалт зан үйл устаж монгол хүний зан байдал эвдэрсэнд оршиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн олонхи нь ганц бие буюу өрх толгойлон амьдардаг ч үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, өрх гэрээ авч явах ачааллыг эрүүл эмэгтэйчүүдийн адил нуруун дээр үүрдэг өрхийн тэжээгч боловч үүндээ гуниж гутахгүй үр хүүхэд ирээдүйдээ төгс итгэж, нийгмийн амьдралд эрх тэгш оролцохыг хүсч байна. Гэвч тэднийг төрийн зарим ажилтнаас эхлээд аж ахуйн зарим нэгж байгууллага, ялангуяа үйлчилгээний

байгууллагын ажилтнууд алагчлан үзэх өөриймсөг сэтгэлээр хандахгүй байгаагаас тэд эрхээ зохих ёсоор эдлэж чадахгүй, эрх нь зөрчигдөх явдал түгээмэл байх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг ажилд авахгүй, ажиллаж байгаа тохиолдолд бага цалин өгөх, илүү цагаар ажиллуулах, ялихгүй зүйлээс өөр эрж ажлаас халахыг эрмэлздэг нь амьдралын бодит үнэн. Хүчирхийллээс болж бие сэтгэлээрээ төдийгүй амь насаараа хохирох тохиолдол цөөнгүй гарч гэмт этгээд ял завшиж байна. Ар гэрийн амьдрал дорой байдлыг далимдуулан өсвөр насны үр хүүхдийг нь хуурч Хонгконг гэх мэт газарт аваачин янхны газарт ажиллуулсан тохиолдол гарсан. Мөн гадаад хүнтэй танилцуулах, ажиллуулах нэрээр Солонгос улсад хэлэх, сонсох эрхтний согогтой залуу эмэгтэйчүүдийг гарган дундаас нь мөнгө олдог Монгол, Солонгос хүмүүсийн бүлэг үүсч ажилладаг нь илэрч байна. Хүний газар тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирсон тохиолдолд тэд хэнд хандах вэ хамгаалах аргаа мэдэх нь бүү хэл хэл нэвтрэлцэж чадахгүй чадваргүй хүмүүс байдгийг бүгд анхаармаар байна шүү. Үүнээс үзвэл төр гадаад оронд сууж буй өөрийн иргэнийг ялгахгүй хамгаалах талаар илүү анхаарч зохиох ажилдаа иргэдээ өөрсдийг нь оролцуулж байх хэрэгтэй байна шүү дээ. Насан залуу охид эмэгтэйчүүдээ хэний нутагт хэнтэй явж байгааг анхаарахгүй хөсөр хаядаг зөвхөн олж ирэх мөнгө бусад зүйлийг сонирхдоггүй эх эцэгт үр хүүхдээ анхаараач ээ гэж уриалж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль эрхийн мэдлэг мууг ашиглан эд хөрөнгө, газрыг луйвардах байдал ихэсч байна. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сангийн судалгаанаас үзэхэд насанд хүрсэн 400 эмэгтэйн 39% байнгын бэлгийн дарамтанд өртдөг гэжээ. Бэлгийн хүчирхийлэл нь хөндлөнгийн этгээд оролцоогүй тохиолдолд илрэхгүй нуун дарагдуулж байгаа бөгөөд хэргийг илрүүлэх шийдэх явцад хууль хяналтын байгууллагын ажилтнуудын ёс зүй харьцаа чухал үүрэг гүйцэтгэдэгийг мартаж болохгүй. Хуулийн өмнө бид бүгд тэгш эрхтэй шүү дээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын ирээдүй харанхуй байна. Тэднийг сургах сургалтын модулийг өөрчилж, нийгэмшүүлэх тал дээр илүү анхаарах ёстой атал Боловсролын яам анхаарал тавихгүй зөвхөн бодлогын хэмжээнд дэмжих төдий байгаа нь энэ чиглэлийн багшлах боловсон хүчний бодлого алдагдсантай холбоотой юм. Одоо манай тусгай хэрэгцээт сургуулиудад хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн сурган хүмүүжүүлэгч маш цөөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болох байдал улам залуужиж байгаа бөгөөд улсын хэмжээгээр 37000 гаруй хүүхэд халамжаас тэтгэвэр авч байна.



Хүүхдийн нэрээр мөнгө, ашиг харж байгуулагдсан ТББ-ууд сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэрийг ашиглаж байна. ТББ-ууд зөвхөн хотод бус өвчтэй хүүхдээ төв суурин газар аваачиж эмчлүүлэх боломжгүй харсаар суугаад алдаж байгаа ядуучууд олонтой хөдөө нутагт ажлаа явуулах хэрэгтэй байна. Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй эхчүүд, хүүхдүүд, гэр бүлээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд цөөнгүй байгаа бөгөөд тухайн аймаг сумын засаг захиргааны байгууллагууд анхаарах хэргтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд төрийн цэгцтэй бодлого хэрэгтэй байгаа бөгөөд хаяж орхигдуулбал зөвхөн эмэгтэйчүүд биш үр хүүхэд, нийгэм, хамт олон хохирно гэдгийг УИХ харгалзан шийдвэр гаргах ёстой. Үүнийг Лобби бүлэг, ялангуяа лобби бүлгийн эмэгтэй гишүүд анхааралдаа авах ёстой.

Жэндэрийн асуудал хүний эрхтэй салшгүй холбоотой байдаг нь гэр бүл нийгмийн харилцаанд оршдог ялгавартай байдал нь олон жилийн турш байсаар байсан ба үүнийг хүний жам ёсны ба хууль ёсны эрхтэй холбон үзэхийг уриалж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эрх, хүчирхийлэлээс хамгаалах талаар нэмэлт тусгуулах арга хэмжээ авахыг санал оруулах эрх зүйн өөрчлөлтийг доорхи хуулиудад нэн даруй хийх арга хэмжээ авахыг санал болгож байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хууль
2. Эрүүгийн хууль
3. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
4. Иргэний хууль
5. Эрүүл мэндийн тухай хууль
6. Сууц өмгөөлөгчдийн холбооны тухай хууль зэрэг болно.

**Анхааралтай сонссонд баярлалаа.**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

2006.12.01

Улаанбаатар хот

Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” сэдэвт үндэсний чуулганыг Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбооноос хамтран 2006 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулав. Тус Чуулганд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын 450 гаруй төлөөлөгч оролцлоо.

Үндэсний чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр дэлгэрэнгүй үг хэлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын талаар авч буй арга хэмжээ, цаашид шийдвэрлэх асуудал”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын стандартийн хэрэгжилт”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн төлөв байдал”, “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх” сэдвүүдээр төрийн болон төрийн бус байгууллагуудаас илтгэл тавьж хэлэлцүүлэв. Түүнчлэн Чуулганы оролцогчдоос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх, эрх чөлөөгөө эдлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлууд, цаашид хийх ажил, зохион байгуулах үйл ажиллагааны талаар олон чухал санал дэвшүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх тэгш боломжийг бий болгохын тулд тэдний тусгай хэрэгцээнд нийцсэн хууль эрх зүй, нийгэм, улс төр, эдийн засгийн болон сэтгэлзүйн орчинг бүрдүүлэх асуудал чухал болохыг Чуулганы төлөөлөгчид санал нэгтэй хүлээн зөвшөөрөв. Чуулганаас дараах Зөвлөмжийг гаргаж байна.

### НЭГ. УЛСЫН ИХ ХУРАЛД

**1.1** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс гомдол, санал ихээр ирүүлж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын

тухай хууль, Барилгын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хууль, Гаалийн албан татварын тухай хууль зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх

**1.2** Улсын нэгдсэн төсвийг батлахдаа төрийн захиргааны төв байгууллагууд, клиникийн төв эмнэлэгүүд, боловсролын зарим байгууллагууд, урлаг соёлын төв зэрэг объектууд, нийтийн зориулалтын гудамж, зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн орчин, дэд бүтцийг бий болгох зардлыг тооцож оруулах

**1.3** НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61 дэх удаагийн Чуулганаар хэлэлцэн батлах Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг судлах, сурталчилах, соёрхон батлах талаар арга хэмжээ авах

## ХОЁР. ЗАСГИЙН ГАЗАРТ

**2.1** Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.4.6-р зүйлд заасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх

**2.2** Шинэчлэн батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 2007 онд багтааж уг хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сэргээн засах дэд хөтөлбөрийг боловсруулан батлах

**2.3** Цаашид хэрэгжүүлэх бүх бодлого, хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах асуудлыг тусгаж уялдуулах

**2.4** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаандаа иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саналыг тусгах, оролцоог хангах

**2.5** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудыг дэмжих, тэдний удирдлага, гишүүдийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, төрийн зарим чиг үүргийг тэдгээр байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх

**2.6** Дөчин мянган айлын орон сууц хөтөлбөрт орон гэргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах, тэдний чадавхид нийцсэн санхүү, эргэн төлөлтийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх

**2.7** Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын түвшинд байгуулж буй үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлуудыг тус тусын чиглэлээр хэрхэн шийдвэрлэх талаар тусгуулж, үр дүнг тооцож байх

**ГУРАВ. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД ЗөВЛөМЖ БОЛГОХ НЬ**

**3.1** 2008 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй сонгууль болгон зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах; Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн хараат бус сонголт хийх боломж бий болгох үүднээс бүх төрлийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэв маягаар боловсруулах, сонгуулийн байр, хэрэглэгдэхүүнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцэхүйц байдлаар бэлтгэх

**3.2** Бүх шатны сонгуульд хараагүй иргэн оролцож, саналаа нууцаар өгөх боломжийг бүрдүүлэхийн тулд саналын хуудсан дахь нэр дэвшигчийн өмнөх дэс дугаарыг брайль буюу тактилаар хэвлүүлэх арга хэмжээ авч, холбогдох заавар журамдаа өөрчлөлт оруулан цаашид хэрэгжүүлэх

**ДөрӨВ. ТөРИЙН ЗАХИРГААНЫ ТөВ БАЙГУУЛААГУУДАД  
ЗөВЛөМЖ БОЛГОХ НЬ**

**4.1 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд**

- 4.1.1 2007 оны 2-р улиралд багтаан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 1996 оны А/250 тоот тушаалаар батлагдсан Мэргэжлээс шалтгаалах өвчин, гэмтлийн жагсаалт болон түүнд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, уг жагсаалтын уян хатан биш байдлаас иргэдийн эрх ашиг хохирч байгаа нөхцөл байдлыг засч залруулах;
- 4.1.2 Үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх цогцолбор арга хэмжээ авч, ийм шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болох явдлыг багасгах эрх зүйн болон бусад таатай орчинг бүрдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;
- 4.1.3 Сэргээн засалтын үндэсний төвд онцгойлон анхаарал хандуулж, үйл ажиллагааг нь дэмжин хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн саадгүй орчин болгон засварлан тохижуулах ажлыг эхлүүлэх;
- 4.1.4 Хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгогддог протез, ортопедын хэрэгслийн чанарыг сайжруулах, энэ төрлийн хэрэглэгдэхүүний чанар, хүртээмжийн талаар гарсан гомдол, маргааныг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хянан шалгаж шийдвэрлэх;
- 4.1.5 Сонсголын бэрхшээлтэй хүн сурч боловсрох, эмнэлэгийн тусламж авах, шүүх эрх мэдлийн болон хуулийн байгууллагад хандах болон

бусад үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхэд холбогдох ажилтан, албан тушаалтантай ойлголцохгүй байх хүндрэл бэрхшээл гардгийг харгалзан үзэж, тэдгээр байгууллагуудад дохионы орчуулагчтай болох асуудлыг судлан, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

- 4.1.6 Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хуульд заасан тоогоор ажиллуулж байгаа эсэхэд байнгын хяналт тавих; Хуульд заасан үүргээ биелүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжин хамтран ажиллаж байгаа ажил олгогчийг урамшуулах хөшүүргийг бий болгох;
- 4.1.7 Бүх төрөл хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хялбар хийж чадах, тэдэнд тохирсон ажлын байрны талаар судлан жагсаалт гаргаж, түүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжил эзэмшүүлэх, ажлын байртай болгох арга хэмжээ авах;
- 4.1.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувиараа хөдөлмөр эрхлэх явдлыг дэмжих зорилгоор шаардагдах түүхий эд, материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гадаад улсаас оруулж ирэхэд нь гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, аж ахуй эрхлэх эхний жилүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг төрийн холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

## 4.2 Эрүүл мэндийн яаманд

- 4.2.1 2007 оны 2-р улиралд багтаан Мэргэжлээс шалтгаалах өвчин, гэмтлийн жагсаалтыг шинэчлэн батлах ажлыг зохион байгуулах
- 4.2.2 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийн асуудалд онцгойлон анхаарал тавьж, Сэтгэцийн өвчин судлалын үндэсний төвийн материаллаг баазыг сайжруулах, тэнд ажиллаж буй эмч, эмнэлэгийн ажилтнуудыг чадавхижуулах, цалин хангамжийг нэмэгдүүлэх талаар бодит дэвшил гаргах
- 4.2.3 Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах
- 4.2.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн байдлаар зохион байгуулах нөхцөл бололцоог бий болгох
- 4.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэн үзэж, энэ талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах
- 4.2.6 Төрөлтийг буруу удирдсаны улмаас нярай хүүхэд төрөх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа явдлыг онцгойлон анхаарч, төрөх эмнэлэгүүд болон тэдгээр эмнэлэгийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- 4.2.7 Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролд зориулан үнэ төлбөргүйгээр тараагдаж байгаа гарын авлага, товхимолын тодорхой

хэсгийг хараагүй хүмүүс хэрэгцэхүйц байдлаар тухайлбал, CD бичлэг буюу брайль үсгээр хэвлүүлж, түгээх

- 4.2.8 Олон улсын болон бүсийн хэмжээний тэмцээн, пара-олимпод оролцож өндөр амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад олгох шагналын хэмжээг эрүүл тамирчны нэгэн адил болгож өөрчлөх, бэлтгэл сургуулилт хийдэг заал танхим, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах

#### **4.3 Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд**

- 4.3.1 Өөрийн харьяаны тусгай хэрэгцээт боловсролын байгууллагуудын барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцэхүйц байдлаар засварлаж тоноглох, тусгай зориулалтын ном товхимол, гарын авлага, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах, багшлах боловсон хүчний чадавхи, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах; 2008 он гэхэд тусгай хэрэгцээт боловсролын байгууллагуудад мэргэжлийн чадварлаг нийгмийн ажилтнаар бүрэн хангах;
- 4.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ахисан шатны сургалтын тэтгэлэгт хамруулах, үнэ төлбөргүй сурах бичгээр хангах зэргээр тасралтгүй сурах нөхцлийг бүрдүүлэх;
- 4.3.3 Ерөнхий боловсролын 29, 116-р тусгай сургуулиудыг нэгтгэн цогцолбор болгон зохион байгуулсан шийдвэрийнхээ үр дүнг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбогдох байгууллагуудын төлөөлөгчдийн оролцоотой ажлын хэсэг байгуулан судлаж үзэх;

#### **4.4 Барилга, хот байгуулалтын яаманд:**

- 4.4.1 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын даргын 2004 оны 3-р сарын 4-ны өдрийн 17 тоот тушаалаар батлагдсан “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” (БД 31-101-04)-ийг дахин хянан үзэж, цаашид улсын стандарт болгуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 4.4.2 Хараагүй болон тулгуур эрхтэн, нуруу нугасны гэмтэл согогтой хүнд зориулан дээрх барилга төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04)-ийн дагуу төрийн захиргаа, эмнэлэг, сургууль, соёл урлагийн болон бусад нийтийн үйлчилгээний урьд нь баригдсан буюу шинээр баригдах барилга байгууламжийн гадна, дотор талд тусгай тоноглол бүхий дэд бүтэц (орц, гарц, зам, бие засах өрөө, хаалга, шат, дохио, тактилан зам гэх мэт)-ийг бий болгох асуудлыг зураг төсөлд нь тусгуулан иж бүрэн шийдвэрлүүлэх;

#### **4.5 Зам, тээвэр аялал жуулчлалын яаманд:**

- 4.5.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, талбай, тээврийн хэрэгслийн стандарт боловсруулах ажлыг түргэвчлэх, стандартыг

боловсруулахдаа энэ талаар мэргэшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын саналыг тусгах;

- 4.5.2 Батлагдсан стандартыг холбогдох талуудад мэдээлэх, дагаж мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах талаар хангаарч ажиллах
- 4.5.3 Зам, гүүр, явган хүний гарц, гэрлэн дохио зэрэг нийтийн хэрэгцээний обьектод хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол тавих ажлыг судалгаа, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- 4.5.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх

#### **4.6 Үдэсний Мэргэжлийн Хяналтын Газарт:**

- 4.6.1 Шинээр ашиглалтанд орж буй обьектыг хүлээн авахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай стандартуудыг дагаж мөрдсөн эсэхэд байнгын хяналт тавих
- 4.6.2 Дэд бүтцийн хяналтын албанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан стандартын хэрэгжилтээр мэргэшсэн байцаагчийг ажиллуулах асуудлыг судлаж шийдвэрлэх

#### **4.7 Мэдээлэл, Харилцаа холбоо, Технологийн Газарт:**

- 3.7.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны тусгай техник, технологи, компьютерийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 3.7.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерийн тусгай программ хангамжийг нэвтрүүлэх, хэрэглээг сайжруулах;
- 3.7.3 Хүн ам олноор цуглардаг газруудад байрлах утсан харилцааны болон интернетийн үйлчилгээний цэгүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай төхөөрөмжтэй болгох талаар арга хэмжээ авах;

#### **4.8 Үндэсний Статистикийн Газарт**

- 4.8.1 2007 онд багтааж хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар нарийвчилсан судалгаа хийж, алба ёсны статистик, мэдээллийн сан бий болгох ажлыг эхлүүлэх;

### **ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН БҮХ ШАТНЫ ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД, ЗАСАГ ДАРГА НАРТ**

**4.1** Харьяа нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, боловсрол олгох, хөдөлмөр эрхлэхэд нь бодитой дэмжлэг үзүүлэх;

**4.2** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн статистик мэдээллийг гаргах, тэдгээр хүмүүс төрөөс үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний талаар мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

**4.3** Хараагүй болон тулгуур эрхтэн, нуруу нугасны гэмтэл, согогтой хүнд зориулсан энэхүү зөвлөмжийн 4.4.1-р зүйлд дурдсан нормалийн дагуу нийслэл, аймгийн төв, томоохон суурин газруудын төрийн захиргаа, эмнэлэг, сургууль, соёл урлаг, бусад нийтийн үйлчилгээний урьд нь баригдсан буюу шинээр баригдах барилга байгууламжийн гадна, дотор талд тусгай тоноглол бүхий дэд бүтэц (орц, гарц, зам, бие засах өрөө, хаалга, шат, дохио, тактелин зам гэх мэт)-ийг бий болгох, энэ ажилд шаардагдах хөрөнгийг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

**4.4** Холбогдох байгууллага, албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлуудыг тус тусын чиглэлээр хэрхэн шийдвэрлэх талаар тусгуулж, үр дүнг тооцож байх

### **ТАВ. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛАГУУД, САНХҮҮЖҮҮЛЭГЧДЭД**

**5.1** Олон улсын хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг хангахтай холбоотой асуудал болон тэдний эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажлыг тусган дэмжиж, хамтран ажиллах

**5.2** Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнг зорилтот бүлгийн хүмүүсийн оролцоотойгоор дүгнэх, үнэлгээ хийх, хяналт тавихад хамтарч ажиллах

### **ЗУРГАА. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛАГУУДАД**

**6.1** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хоорондын зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулах, мэдээлэл солилцооны тогтмол урсгалыг бий болгох

**6.2** Үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүдийг оролцуулах, тэдний өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд онцгойлон анхаарч ажиллах

**6.3** Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх нийгэмд тогтсон сөрөг хандлагыг өөрчлөх, энэ талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах

**6.4** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхөн үржихүйн болон гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах



## **ДОЛОО. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, УРЛАГ СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД**

**7.1** Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар хэвлэн нийтлэх болон тоглож үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн сэтгэлзүйд эерэг нөлөө үзүүлэх, улмаар нийгэмд тогтсон хандлага, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг баримтлаж ажиллах

**7.2** Телевизүүдийн мэдээллийн болон эрүүл мэнд, боловсрол, амралт чөлөөт цагийн нэвтрүүлгийг сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох үүднээс дохионы хэлний орчуулгатай нэвтрүүлэх асуудлаар бодит ахиц гаргах

**7.3** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлагийн авьяас, чадварыг хүндэтгэн үзэж, тэдэнд бүтээн туурвихад нь дэмлэг үзүүлэн хамтарч ажиллах

## **НАЙМ. ХУВИЙН ХЭВШЛИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД**

**8.1** 50 буюу түүнээс дээш тооны ажиллагсадтай аж ахуйн нэгж байгууллага ажил, албан тушаалынхаа гурав, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулах тухай Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг хүндэтгэн сахих

**8.2** Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байран дээр сургах сургалтыг холбогдох байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулах

**8.3** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орчны саадыг арилгах үүднээс байгууллагынхаа барилга байгууламж, хамаарах гадны орчныг тохижуулах, засварлах, тусгай тоноглол бүхий дэд бүтцийг бий болгох

## **ЕС. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЛААР**

**9.1** Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтэнд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс хяналт тавьж ажиллана.

**9.2** Зөвлөмж болон түүний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

**9.3** 2007 оны 3-р улиралд багтааж уг зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын тайланг хэлэлцэх, энэ талаар нийтэд мэдээлэх зорилгоор Чуулганд оролцсон бүх талуудыг хамруулсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулна.

ЧУУЛГАНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД



Mongolia

НҮ ХХ нь илүү өндөр амьдрал, нөөцийн хангамж, улс орнуудын өмнөх ач холбогцлыг олон нийтийн хамтын ажиллагаа замаар илүү сайн амьдралыг амьдралын доголлон байгуулахад хамт туслах зорилго бүхий НҮ -ын дэлхий нийтийн хөгжлийн сэлжээ юм.

### *Эрхэм Уншигчид аа!*

*Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.*

#### **Хүний Эрхийн Үндэсний Комисс**

**Хаяг:** Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

**Утас:** 318082, 262971

**Факс:** 262971, 320284

**Цахим шуудан:** [contact@nhrc-mn.org](mailto:contact@nhrc-mn.org)

**Цахим хуудас:** <http://www.mn-nhrc.org>